АНАГААХ УХААНЫ БОЛОВСРОЛ ОЛГОХ ИХ, ДЭЭД СУРГУУЛИЙГ 2025 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛД **СУВИЛАГЧ** МЭРГЭЖЛЭЭР ТӨГСӨГЧДИЙН МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРЛИЙН ШАЛГАЛТЫН **ЖИШИГ СОРИЛ - I**

Сорилын зөв хариулт

1-D, 2-B, 3-C, 4-D, 5-C, 6-A, 7-A, 8-D, 9-C, 10-B, 11-D, 12-C, 13-C, 14-A, 15-B, 16-C, 17-C, 18-B, 19-C, 20-B, 21-C, 22-C, 23-A, 24-C, 25-D, 26-D, 27-B, 28-C, 29-C, 30-B, 31-C, 32-B, 33-E, 34-D, 35-B, 36-A, 37-C, 38-E, 39-C, 40-A, 41-A, 42-C, 43-A, 44-C, 45-A, 46-B, 47-C, 48-D, 49-D, 50-C, 51-C, 52-C, 53-A, 54-A, 55-B, 56-A, 57-A, 58-B, 59-D, 60-D, 61-B, 62-A, 63-B, 64-A, 65-A, 66-A, 67-C, 68-A, 69-A, 70-A, 71-B, 72-C, 73-B, 74-B, 75-A, 76-B, 77-D, 78-C, 79-A, 80-A, 81-A, 82-C, 83-A, 84-B, 85-A, 86-B, 87-C, 88-A, 89-A, 90-E, 91-A, 92-B, 93-C, 94-B, 95-B, 96-A, 97-D, 98-E, 99-B, 100-B, 101-E, 102-C, 103-B, 104-C, 105-C, 106-B, 107-D, 108-B, 109-D, 110-A, 111-A, 112-B, 113-C, 114-A, 115-D, 116-E, 117-C, 118-B, 119-D, 120-A, 121-C, 122-A, 123-B, 124-A, 125-E, 126-B, 127-E, 128-E, 129-C, 130-C, 131-E, 132-D, 133-E, 134-B, 135-B, 136-A, 137-A, 138-E, 139-B, 140-E, 141-B, 142-A, 143-E, 144-E, 145-B, 146-A, 147-A, 148-C, 149-E, 150-C, 151-E, 152-A, 153-C, 154-C, 155-C, 156-E, 157-E, 158-A, 159-A, 160-B, 161-C, 162-E, 163-E, 164-E, 165-D, 166-A, 167-E, 168-E, 169-A, 170-A, 171-E, 172-E, 173-E, 174-E, 175-E, 176-B, 177-A, 178-C, 179-A, 180-C, 181-E, 182-B, 183-E, 184-B, 185-C, 186-A, 187-A, 188-A, 189-B, 190-A, 191-C, 192-A, 193-A, 194-A, 195-E, 196-A, 197-C, 198-A, 199-E, 200-E, 201-C, 202-A, 203-E, 204-B, 205-B, 206-E, 207-B, 208-A, 209-A, 210-E, 211-A, 212-B, 213-B, 214-E, 215-A, 216-A, 217-C, 218-E, 219-A, 220-E, 221-E, 222-A, 223-E, 224-A, 225-A, 226-B, 227-B, 228-A, 229-B, 230-E, 231-B, 232-C, 233-C, 234-C, 235-A, 236-A, 237-A, 238-C, 239-A, 240-A, 241-C, 242-A, 243-D, 244-A, 245-C, 246-C, 247-E, 248-C, 249-C, 250-B, 251-D, 252-A, 253-B, 254-D, 255-C, 256-D, 257-B, 258-E, 259-A, 260-A, 261-E, 262-B, 263-C, 264-C, 265-B, 266-A, 267-A, 268-C, 269-D, 270-E, 271-C, 272-B, 273-C, 274-D, 275-D, 276-B, 277-E, 278-C, 279-A, 280-E, 281-A, 282-A, 283-A, 284-C, 285-E, 286-E, 287-E, 288-D, 289-A, 290-A, 291-A, 292-C, 293-C, 294-E, 295-B, 296-D, 297-C, 298-A, 299-C, 300-A, 301-B, 302-A, 303-E, 304-C, 305-B, 306-B, 307-C, 308-C, 309-B, 310-B, 311-C, 312-C, 313-E, 314-C, 315-B, 316-C, 317-D, 318-A, 319-D, 320-D, 321-B, 322-C, 323-C, 324-D, 325-D, 326-D, 327-C, 328-A, 329-C, 330-C, 331-A, 332-B, 333-C, 334-A, 335-C, 336-D, 337-A, 338-C, 339-C, 340-C, 341-E, 342-D, 343-A, 344-C, 345-A, 346-A, 347-E, 348-E, 349-E, 350-A, 351-A, 352-A, 353-B, 354-E, 355-C, 356-A, 357-E, 358-A, 359-D, 360-E, 361-E, 362-E, 363-E, 364-B, 365-C, 366-E, 367-A, 368-A, 369-E, 370-E, 371-C, 372-C, 373-C, 374-C, 375-C, 376-E, 377-A, 378-A, 379-A, 380-A, 381-E, 382-A, 383-A, 384-A, 385-A, 386-A, 387-A, 388-A, 389-D, 390-D, 391-B, 392-D, 393-A, 394-A, 395-D, 396-C, 397-A, 398-E, 399-E, 400-E, 401-A, 402-A, 403-E, 404-E, 405-A, 406-A, 407-E, 408-D, 409-C, 410-C, 411-D, 412-D, 413-C, 414-B, 415-B, 416-C, 417-D, 418-B, 419-A, 420-D, 421-E, 422-B, 423-C, 424-B, 425-D, 426-D, 427-B, 428-B, 429-A, 430-D, 431-C, 432-B, 433-A, 434-A, 435-C, 436-A, 437-A, 438-B, 439-A, 440-E, 441-E, 442-C, 443-E, 444-B, 445-A, 446-E, 447-C, 448-E, 449-D, 450-B, 451-C, 452-E, 453-E, 454-E, 455-E, 456-B, 457-A, 458-E, 459-B, 460-E, 461-A, 462-A, 463-A, 464-E, 465-C, 466-E, 467-A, 468-A, 469-B, 470-B, 471-B, 472-A, 473-A, 474-D, 475-D, 476-C, 477-D, 478-B, 479-C, 480-D, 481-B, 482-A, 483-E, 484-B, 485-A, 486-C, 487-B, 488-A, 489-A, 490-C, 491-E, 492-B, 493-D, 494-B, 495-E, 496-E, 497-E, 498-E, 499-A, 500-A, 501-E, 502-E, 503-A, 504-E, 505-C, 506-C, 507-B, 508-C, 509-C, 510-B, 511-C, 512-B, 513-A, 514-B, 515-E, 516-E, 517-E, 518-E, 519-E, 520-A, 521-E, 522-A, 523-E, 524-E, 525-E, 526-E, 527-A, 528-E, 529-A, 530-E, 531-A, 532-A, 533-A, 534-E, 535-C, 536-A, 537-D, 538-D, 539-B, 540-C, 541-C, 542-D, 543-B, 544-A, 545-C, 546-D, 547-A, 548-C, 549-E, 550-A, 551-D, 552-C, 553-A,

Сорил хариулах заавар:

1. Нэг сонголттой тест (Зөвхөн 1 хариулт зөв байх) Энэ хэлбэрийн сорил нь A, B, C, D, E гэсэн дугаартай бөгөөд Зөвхөн 1 зөв хариуг сонгоно.
2. Олон сонголттой тест (Хэдэн ч хариулт зөв байж болох)
   1, 2, 3 дугаар хариултууд зөв бол (A.)
   1, 2, 3, 4 дугаар хариултууд зөв бол (B.)
   2 ба 4 дугаар хариултууд зөв бол (C.)
   Зөвхөн 4-р хариулт зөв бол (D.)
   Бүх хариулт зөв бол (E.)
3. Шалтгаан хамаарлын тест (Заагдсан тестүүдийн үнэн зөв хийгээд тэдгээрийн шалтгаан хамаарлыг тодорхойлно.)
   Зөв, Зөв, Зөв (A.)
   Зөв, Зөв, Буруу (B.)
   Зөв, Буруу, Буруу (C.)
   Буруу, Зөв, Буруу (D.)
   Буруу, Буруу, Буруу (E.)

Сонгогдсон сорил

/1./ Сорил тарилгыг хэдэн хэмийн өнцөгөөр хийх вэ?
   A. 90 хэм
   B. 45-60 хэм
   C. 10-15 хэм
   D. 3-5 хэм
   E. 5-10 хэм

/2./ Мантугийн сорилын хариуг хэдийд шалгах вэ?
   A. 1 хоногийн дараа
   B. 48 - 72 цагийн дараа
   C. 38-70 цагийн дараа

/3./ Сувилгааны үйл ажиллагааны “Үнэлгээний” шатлалын үед сувилагч юу хийх ёстой вэ?
   A. Шийдвэрлэсэн асуудалд үнэлгээ өгөх
   B. Тавьсан сувилгааны оношид үнэлгээ өгөх
   C. Өвчтөн үзэж үнэлгээ өгөх
   D. Сувилгааны төлөвлөгөөний боловсруулалтанд үнэлгээ өгөх
   E. Бүгд зөв

/4./ Даавар ялгаруулдаг эрхтэнийг нэрлэнэ үү?
   A. Дэлүү
   B. Уушиг
   C. Цөсний хүүдий
   D. Нойр булчирхай

/5./ Арьсан дор тариа хийхэд хэрэглэх зүүг сонгоно уу?
   A. 18-20G
   B. 20-22G
   C. 23-24G
   D. 25-26G

/6./ Халуун жин тавих хугацааг заана уу?
   A. 10-30 мин
   B. 2-3 цаг
   C. 30 мин -1 цаг
   D. 3-3,5 цаг
   E. 4 цагаас дээш

/7./ Үйлчлүүлэгчийн өтгөн хатсан байна. Аль сувилгааг хийх вэ?
   A. Клизм тавих
   B. Өвчин намдаах эм өгөхгүй
   C. Үйлчлүүлэгчийг алхаж явуулах арга хэмжээ авах
   D. Орон дээр нь өвдөлт намдаах байрлалд хэвтүүлэх

/8./ Сувилгааны төлөвлөгөөг боловсруулахдаа хэнд зориулж боловсруулдаг вэ?

A. Хүнд өвчтөнд
B. Ухаангүй өвчтөнд
C. Өндөр настанд
D. Бүх өвчтөнд
E. Хөнгөн өвчтөнд

/9./ Тарилгын өрөө хэдэн м2 талбайтай байх èстой вэ?
A. 19-20м2
B. 5-6 м2
C. 8-15 м2
D. 2-3 м2

/10./ Эрэгтэй хүнд шээлгүүрийг ямар хэмжээтэй тавих вэ?
A. 3-4 см
B. 18-20 см
C. 5-10 см
D. 10-15 см
E. 15-18 см

/11./ Хэвлийн хөндийд хуримтлагдсан шингэнийг түргэн гоожуулж авбал өвчтөнд ямар хүндрэл илрэх вэ?
A. Хэвлийгээр базалж өвдөнө.
B. Тархины цусан хангамж нарийсч толгой өвдөнө.
C. Дотор муухайрч бөөлжис цутгана.
D. Хэвлийн даралт гэнэт бууж чичрүүлнэ.
E. Хэвлийн даралт гэнэт бууж ухаан алдана.

/12./ Орыг ариутгахдаа ариутгалын уусмалыг цэвэрлэгээний хэдийд нь хэрэглэдэг вэ?
A. Угаалгын эхэнд
B. Угаалгын явцад
C. Бүгдийг нь угааж цэвэрлэсний дараа
D. Угаалга хийхийн урьд өдөр

/13./ Сорил тарилгын үед хэрэглэх зүүний хэмжээг заана уу.
A. 20G
B. 22 G
C. 26 G
D. 23 G
E. 21 G

/14./ Нуралтын үед доорх шинж тэмдгүүдийн аль нь илэрвэл хөдөлгөөнийг хязгаарлах вэ?
A. Улайгаад хорсож эхлэнгүүт
B. Улайсан арьс хагарч өнгөц зулгарсан бол
C. Явахад хөндүүрлэж үрэвслийн шинж илэрвэл
D. Үрэвслийн шинж тэмдэг хүндэрсэн тохиолдолд

/15./ Шээсний хувийн жин хэвийн хэмжээндээ хэд байх вэ?
A. 1000-1005
B. 1010-1020
C. 1030-1040
D. 1050-1060
E. 1040-1050

/16./ Гич тавих зөв заалтыг олно уу?
A. Уушигны хорт хавдар өвчний үед
B. Цустай цэр гарч байгаа үед
C. Уушигны үрэвсэлт өвчний үед
D. 38-аас дээш хэм халуунтай үед

/17./ Зүрхэнд шууд бус массаж хийхэд гарын алгыг хаана байрлуулах вэ?
A. Өвчүүний дээд 1/3
B. Өвчнүүний дээд ба дунд 1/3
C. Өвчүүний дунд ба доод 1/3
D. Зүүн хөхний шугамаар

E. Аюулхайн мөгөөрс дээр
/18./ Тариаг түргэн шахвал ямар хүндрэл өгдөг вэ?
A. Цусны урсгалд хийн бөглөө үүснэ.
B. Шокод орж болно.
C. Цусан үжил үүснэ.
D. Цус эд эсээр бөглөрч болно.
/19./ БЦЖ вакцин 1 ампулдаа хэдэн хүн тарих тунгаар байдаг вэ?
A. 10
B. 15
C. 20
D. 25
E. 30
/20./ Сонин хэвлэл дээр гарч буй эрүүл мэндийн зөвлөгөө аль хэлбэрийн сургалтанд хамаарах вэ?
A. Ганцаарчилсан
B. Зайны
C. Хосолсон
D. Тасралтгүй
/21./ Гепарин эмчилгээний хүндрэлийг нэрлэнэ үү?
A. Харшил
B. Халуурах
C. Цус алдах
D. Бөөлжих
/22./ Арьсан дор тариаг ямар давхаргад хийдэг вэ?
A. Торлог давхарга
B. Суурийн давхарга
C. Өөхөн давхарга
D. Өргөст давхарга
/23./ Зөөлөн эдүүд норж хоорондоо шүргэлцсэний улмаас үүсч байгаа арьсны өөрчлөлтийг юу гэдэг вэ?
A. Нуралт
B. Холголт
C. Цооролт
D. Улайлт
/24./ Давсагыг нэг удаа угаахдаа хэд дахин угаах вэ ?
A. 2 –3 угаана
B. Фурациллинээр угаавал 1 удаа угаана
C. Угааж буй уусмал өнгөөрөө гартал угаана
D. Марганецаар угаавал 2 удаа угаана
/25./ Өндөр халууралтанд хэдэн хэм орох вэ?
A. 37,5-38
B. 38-38,5
C. 38,5-39,5
D. 39,5-41
E. 41 дээш
/26./ Цэвэрлэх бургуй тавихад өвчтөний байрлал ямар байх вэ?
A. Босоо
B. Хэвтээ
C. Баруун хажуугаар нь
D. Зүүн хажуугаар нь
E. Өвдөг тохойн байрлал
/27./ Хөлийг гичтэй ваннад дүрэхдээ 10 л усанд хэдий хэмжээний гич байхаар тооцоолдог вэ?
A. 100 гр
B. 50 гр
C. 30 гр

D. 70 гр
E. 80 гр
/28./ Сорил тариаг зөв хийгдсэн эсэхээ та яаж мэдэх вэ?
A. Өвчтөнд бага зэргийн өвдөлт өгнө.
B. Хэсэг газар улайна.
C. Арьсан дээр жижиг цэврүү үүснэ.
D. Тарих үед халуун оргино.
/29./ Сувилахуйн тохирсон тодорхойлолтыг сонгоно уу?
A. Тухайн хүнд бий болсон асуудлыг шийдвэрлэхийг хэлнэ.
B. Тухайн хүнд бий болсон асуудлыг илрүүлэн оношлож, илааршуулахыг хэлнэ.
C. Тухайн хүнд бий болсон болон бий болох асуудлыг илрүүлж оношлож илааршуулахыг хэлнэ.
D. Тухайн хүнд байгаа аливаа асуудлыг илрүүлж шийдвэрлэхийг хэлнэ.
/30./ Зүрхний шууд бус массажийг минутанд хэдэн удаа хийх вэ?
A. 120
B. 60
C. 30
D. 15
/31./ Сувилагч нь сувилгааны төлөвлөгөө боловсруулахдаа хэрэгцээний эрэмбийн онолыг ашигладаг. Хэрэгцээний эрэмбийн онолыг зохиосон хүнийг нэрлэнэ үү?
A. Ричард Калиш
B. Жим Оттери
C. Абрахам Маслоу
D. Доротеа Орем
E. Рутвайт
/32./ Өвчтөнг орноос зөөх хэрэгсэлд шилжүүлэн зөөх ажилбарыг хэдэн сувилагч хийж гүйцэтгэх нь зөв гэж үздэг вэ?
A. 1 сувилагч
B. 2-3 сувилагч
C. 3-4 сувилагч
D. 4 сувилагч.
/33./ Мантугийн сорилыг эсрэг гэж тооцох гүвдрүүний хэмжээ хэд байдаг вэ?
A. 1-5 мм
B. 5-10 мм
C. 10-17 мм
D. 5-17 мм
E. 17 мм-ээс дээш
/34./ Сорил тарилгын үед хэрэглэх уусмалын хэмжээг заана уу.
A. 1-2 мл
B. 0,3-0,5 мл
C. 0,5-1 мл
D. 0,1-0,3мл
E. 0,2-0,3 мл
/35./ Найруулж бэлтгэсэн преднизолоныг хаана тарих вэ?
A. Арьсан дор
B. Хураагуур судсанд
C. Тараагуур судсанд
D. Булчинд
E. Бургуйгаар
/36./ Венийн судсанд тарилга хийх үед асептик зарчим алдагдвал доорхи хүндрэлүүдээс аль нь тохиолдох вэ?
A. Сепсис
B. Абсцесс
C. Шок
D. Эмболи
E. Тромбо

/37./ Эмнэлгээс шалтгаалах халдвар гэж алийг хэлэх вэ?
A. Эмнэлэгт хэвтэн эмчлүүлж байгаа хүмүүсийн дундаас гарч байгаа халдварыг хэлнэ
B. Эмнэлэгийн ажилчдын дундаас гарсан халдварыг хэлнэ.
C. Эмнэлгийн байгууллага, тэнд ажиллаж байгаа хүмүүсийн үйл ажилллагаатай холбоотой үүсэх бүх төрлийн халдварыг хэлнэ
/38./ Сувилгааны явцын эхний үе шат болох " Үнэлгээний " үед сувилагч юу хийх вэ?
A. Ажилдаа шууд орно. / Үйл ажиллагаагаа эхэлнэ /
B. Сувилгааны оношийг тавина.
C. Сувилгааны төлөвлөгөөг боловсруулна
D. Сувилгааны төлөвлөгөөг хэрэгжүүлнэ.
E. Өвчтөнөө үзэж үнэлгээ өгөх
/39./ Нугасны хатгалтыг хийхдээ өвчтөнийг яаж байрлуулах вэ?
A. Түшлэгтэй сандал мордуулж суулгаад хажуу тал руу нь хазайлгана.
B. Баруун хажуугаар нь хэвтүүлээд дээд талын хөлийг өвдөгний үеэр нугална.
C. Эрүүг өвчүүнд шахаж, өвдөгийг тахимаар нь нугалж хэвлийд нь шахаж байрлуулна.
D. Хагас суугаа байрлалд байрлуулах
/40./ Гич ямар үйлчилгээ үзүүлдэг вэ?
A. Арьс салст бүрхэвчийг цочроож рефлексийн замаар судас өргөсгөн өвчин намдаах
B. Хэсэг газрын цусан хангамжийг сайжруулан, эд эсийг сэргээх
C. Хэсэг газрын цусан хангамжийг бууруулан өвчин намдаах, тайвшруулах
/41./ Эмэгтэйн шээсний сүвийн уртын хэмжээг олно уу?
A. 4 см
B. 6 см
C. 8 см
D. 10см
E. 3 см
/42./ Гич нь цочроох үйлчилгээгээ хэдэн хэмд алддаг вэ?
A. 50С
B. 45С
C. 60С
D. 55С
E. 40С
/43./ Цусанд ямар бодис ихэссэнээс арьсны шарлалт үүсдэг вэ?
A. Билирубин
B. Холестрин
C. Амилаза
D. Трансаминаза
/44./ Арьсан дотор тарилга хийх талбайг нэрлэнэ үү?
A. Далны арьсан дор
B. Гуяны арьсан дор
C. Гарын шууны 1/3
D. Бугалганы арьсан дор
E. Хэвлийн хэсгийн арьсанд
/45./ Цооролт гэж юуг хэлэх вэ?
A. Хэсэг газар удаан хугацаагаар дарагдаж, тэжээлгүйдэж үхжил үүсэх
B. Нимгэн арьстай гэзрын арьс үрэгдэж үрэвсэх
C. Хэсэг газар удаан хугацаагаар үрэгдэж, арьс улайж, хавагнах
D. Удаан хугацаагаар нэг байрлалд хэвтсэн газар улайх
/46./ Аль нь туншилтайгаар бэлтгэгдэн хэрэглэгддэг эм бэ?
A. Синтомицин
B. Витамин К
C. Аспирин
D. Сульфадомизин
/47./ Эмнэлгийн нэг тасагт байх орны эрүүл ахуйн норм хэд вэ?
A. 10-15 ор

B. 50-60 ор
C. 25-30 ор
D. 15-20 ор
E. 30-40 ор

/48./ Гурван бүлгийн цустай гурвуулантай нь наалдах урвал явагдвал энэ хүн хэддүгээр бүлгийн цустай вэ ?

A. 0 I
B. A II
C. B III
D. AB IV

/49./ Халууныг хоол идсэнээс хойш хэдэн цагийн дараа үзэх хэрэгтэй вэ?

A. 1 цаг
B. 2-3 цаг
C. 4 цаг
D. Цаг хамаарахгүй

/50./ Цулцангийн амьсгал гэж юуг хэлэх вэ?

A. Төвөнхөөр үүсэх амьсгалын дууг хэлнэ
B. Амьсгал гарах үед төвөнхөөр дамжин гарах дуу
C. Амьсгал авах үед цулцан агаараар дүүрэхэд цулцангийн хана хэлбэлзэхэд гарах чимээ
D. Дууны хөвчөөр агаар дамжихдаа цагаан мөгөөрсөн хоолойд гарах амьсгалын дууг хэлнэ

/51./ Сорил тариаг хийхэд зүүг арьсанд хэдэн хэмийн өнцөг үүсгэж хатгалт хийх вэ?

A. 15 хэм
B. 45 хэм
C. 5 хэм

/52./ Сувилгааны үйл ажиллагаа гэж юу вэ?

A. Сувилахуйн тусламж үзүүлэх дэс дараалалтай үйл ажиллагаа
B. Хүмүүст тусламж үзүүлэхэд чиглэгдсэн сувилахуйн ажлын төлөвлөгөө
C. Хүн нэг бүрд сувилахуйн тусламж үзүүлэх тасралтгүй үргэлжлэх үйл ажиллагаа юм
D. Хүнийг тайвшруулахад чиглэсэн үйл ажиллагаа юм.

/53./ Даралтны аппаратын манжетийг хэдэн мм секундэнд суллах вэ?

A. 2 мм сек
B. 3 мм сек
C. 4 мм сек
D. 6 мм сек

/54./ “Асран сувилахын тулд хамгийн сайхан орчинд байлгах хэрэгтэй “гэж хэн хэлсэн вэ?

A. Ф. Найтенгель
B. Б. Хендерсон
C. Олон улсын сувилахуйн нийгэмлэгээс
D. Америкийн сувилахуйн нийгэмлэгээс
E. Ирина Шарковска

/55./ 400 мл шингэнийг 2 цагт багтаан сэлбэнэ гэвэл 1 минутанд дусах дуслын тоог хэдээр тохируулах вэ?

A. 55 дуслаар
B. 66 дуслаар
C. 80 дуслаар
D. 75 дуслаар

/56./ Наркозын бус үйлдэлтэй өвдөлт намдаах эмүүд бие махбодид ямар үйлдэл үзүүлэх вэ?

1. Өвдөлт намдаах
2. Халуун бууруулах
3. Үрэвслийн эсрэг
4. Хаван бууруулах
5. Шээс хөөх

/57./ Таны өвчтөн бөөрний өвчтэй байна. Таны өдөр тутмын хийх чухал үнэлгээ аль нь вэ?

A. Цусны даралт үзэх
B. Нойрсолтыг үнэлэх
C. Сэтгэл санааны байдлыг үнэлэх
D. Өвчтөнөөс өөрийнх нь тухай асуух
E. Өвчтөнийг тайван байлгах

/58./ Өгзөгний булчинд тарилгыг хийхдээ хэдэн хэмийн өнцөг үүсгэн хатгалт хийх вэ?

A. 60 хэм
B. 90 хэм
C. 45 хэм

/59./ Эрүүл хүн гэж ямар хүнийг хэлэх вэ?

A. Ямар нэг зовиур шаналгаагүй эрхтэн систем бүрэн бүтэн хүнийг хэлнэ.
B. Ямар нэг зовиур шаналгаагүй гадаад орчинтойгоо дасан зохицох чадвартай хүнийг хэлнэ.
C. Ямар нэг зовиур шаналгаагүй, хөдөлмөрийн чадвартай хүнийг хэлнэ.
D. Ямар нэг зовиур шаналгаагүй, эрхтэн систем бүрэн бүтэн, гадаад орчинтойгоо дасан зохицсон, сэтгэц оюун нийгэм ахуйн өв тэгш эсэн мэнд байдлыг хэлнэ.

/60./ Яаралтай тусламжийн дүрэм буюу ABCD гэж юу вэ?

A. Яаралтай тусламж үзүүлэх
B. Хиймэл амьсгал хийх, зүрхэнд иллэг хийх
C. Цусны эргэлтийг сэргээх амьсгалын дээд замыг чөлөөлөх, хиймэл амьсгал өгөх нэгдсэн арга хэмжээ
D. Амьсгалын дээд замыг чөлөөлөх, хиймэл амьсгалыг хийх, цусны эргэлтийг сэргээх, сэхээн амьдруулах арга хэмжээ

/61./ Антибиотик антисептикийн ямар төрөлд орох вэ?

A. Физикийн
B. Биологийн
C. Химийн
D. Механикийн

/62./ Хандлага гэж юу вэ?

A. Хандлага гэдэг нь èс зүйг бодвол илүү өргөн утгатай ерөнхий ойлголт бөгөөд аливаа юманд хандах хүний үйл хөдлөл, үг яриагаараа илэрхийлж буй сэтгэлийн дотоод илэрхийлэл юм.
B. Хандлага гэдэг нь èс зүй дотор агуулагдах, харилцааны соèлыг утгандаа агуулсан ерөнхий ойлголт бөгөөд хүний аливаа юманд хандах сэтгэл зүй, зан төлөвийг хэлнэ.
C. Хандлага гэдэг нь ердөө хүний боловсролын түвшингээс шалтгаалан хүнтэй харилцах байдал.
D. Хандлага гэдэг нь хүн хүний хоорондын харилцаа
E. Хандлага гэдэг нь хүнийг хүндэтгэж байгаа байдал.

/63./ 2 настай хүүхдийн судасны лугшилтын тоо 1 минутанд хэд байх вэ?

A. 110-130
B. 100
C. 90-95
D. 60-70

/64./ Өвчтөний цусыг авч 1,2,3 бүлгийн ийлдэстэй холиход аль нь ч ээдсэнгүй тул хэд дүгээр бүлгийн цус вэ?

A. 1-р бүлэг
B. 2-р бүлэг
C. 3-р бүлэг
D. 4-р бүлэг

/65./ Пульсийн даралтын зөрүү хэд байвал хэвийн гэж үзэх вэ?

A. 20-30
B. 10-15
C. 15-20
D. 20-25

E. 40-50
/66./ Бичил бургуйг юугаар тавибал тохиромжтой вэ?
A. Ургамлын тосоор
B. Савангийн уусмалаар
C. Содын уусмалаар
D. Буцалсан усаар
E. Бүгд зөв
/67./ Сорил тариаг хийсний дараа үйлчлүүлэгчдэд ямар зөвлөгөө өгөх вэ?
A. Маажиж, ус хүргэж болохгүй
B. Өдөр бүр савантай бүлээн усаар угааж цэвэр байлгах
C. Маажиж ус хүргэж болохгүй, 48-72 цагийн дараа сорилоо шалгуулаарай.
/68./ Үйлчлүүлэгчийн амьсгал авах үйл ажиллагаа түр алдагдсан үед ямар сувилгаа хийх вэ?
A. Хүчилтөрөгч амьсгалуулна
B. Хамрын хөндийг цэвэрлэх
C. Банк тавих
D. Гич хэрэглэх
/69./ Цэвэрлэх бургуй тавихад хэдэн литр ус хэрэглэх вэ?
A. 1-2 л
B. 0,3-0,5 л
C. 3 л
D. 5-8 л
/70./ Биологийн сорил үзэхэд цусыг судсанд яаж явуулах вэ?
A. Урсгаж явуулах
B. 1 минутанд 20-30 дусал
C. 1 минутанд 40-60 дусал
D. 1 минутанд 10-20 дусал
E. 1 минутанд 30-40 дусал
/71./ Клиник үхэл хэдэн цаг үргэлжлэх вэ?
A. 1-2 цаг
B. 5-6 минут
C. 10-15 минут
D. 30 минут
E. 30-40 минут
/72./ Цусны бүлгийг анх хэн хэдэн онд 3 бүлэг гэж нээсэн бэ ?
A. 1628 онд эрдэмтэн Гарвей
B. 1832 онд эрдэмтэн Вольф
C. 1901 онд Ландштейнер
D. 1901 онд Ян-Янский
/73./ Дараахаас ходоод угааж болохгүй ямар заалтыг сонгоно уу?
A. Хоолны хордлого
B. Зүрхний шигдээс
C. Гэдэс дүүрэх
D. Эмийн хордлого
/74./ Булчин тарианы үед асептик зарчим алдагдвал ямар хүндрэл үүсэх вэ?
A. Бэрсүү
B. Буглаа
C. Үрэвсэл
D. Улайлт
/75./ Бие мах бодид сүрьеэ өвчний үүсгэгч байгаа эсэхийг мэдэхийн тулд ямар сорил тавьдаг вэ?
A. Манту-Пиркегийн сорил
B. Бюринегийн сорил
C. Каццоны сорил
/76./ Эрүүл хүн нэг минутанд хичнээн удаа амьсгалдаг вэ?
A. 25-30

B. 16-20
C. 5-10
D. 8-12
E. 30-35

/77./ Инсулин нь 1мл-тээ 100 Ед агуулдаг. Шууд үйлчилгээтэй инсулинээс өвчтөнд 6 Ед-ийг хийхийн тулд тариурт хэдэн мл-ийг соруулах вэ?

A. 0,25мл
B. 0,05мл
C. 0,15мл
D. 0,06мл
E. 1мл

/78./ Нэг минутанд дусах дуслын тоог аль томъёогоор тогтоох вэ?

A. Dt =V/4n
B. Dt = V/6n
C. Dt = V/3n
D. Dt= V/5n

/79./ Таны өвчтөн цусны даралт багатай. Аль нь сувилгааны хамгийн чухал тусламж вэ?

A. Орноос босоход нь тусална
B. 8 цаг тутамд халууныг хэмжинэ.
C. Массаж хийж өгнө
D. Өвчтөнд зүрхний өвчнөөс хамгаалахад нь тусална
E. Эрүүл хооллолтын талаар зааж өгнө

/80./ Эмнэлэг хамгаалалын дэглэм хэнд хамгийн түрүүнд үйлчлэх вэ?

A. Өвчтөнд
B. Эмнэлгийн ажиллагсдад
C. Өвчтний ар гэрт
D. Эмнэлгийн бусад ажилчдад

/81./ Дуслын бургуйг 1-3 настай хүүхдэд хэдэн мл шингэнээр тавьдаг вэ?

A. 40-60мл
B. 10-15 мл
C. 20-30 мл
D. 15-20 мл

/82./ Халууралт гэж юу вэ?

A. Ямарваа нэгэн цочроогчийн улмаас дулааны зохицуулга алдадсан өвчин юм
B. Хүчтэй цочролын улмаас дулааны зохицуулга алдагдаж халуун ихссэнээс бие махбодид үүсч буй үрэвсэл юм
C. Ямар нэгэн хүчтэй цочролоос дулаан зохицуулга алдагдан, биеийн ихссэнээс бие махбодид үүсч буй хариу урвал

/83./ Арьсан дор тарилга хийхдээ зүү тариурыг тарих талбайд хэдэн хэмийн өнцөг үүсгэх вэ ?

A. 45-60 хэм
B. 70 хэм
C. Өнцөг үүсгэхгүй
D. 15 хэм

/84./ Ямар шинжилгээнд өмнө нь цэвэрлэх бургуй тавьдаг вэ?

A. Цээжний зураг
B. Бөөрний зураг
C. Ходоодны зураг
D. Толгойн зураг

/85./ Танд флакондоо 500000ед-ээр савлагдсан пенициллинийг хэдэн граммын ямар уусмалаар найруулж судсанд тарих вэ?

A. 5 гр 0,9%-натрихлорид
B. 4 гр 0,25% новокайн
C. 2 гр 0,9%-натрихлорид
D. 2 гр новокайн 0,25
E. 5 гр новокайн 0,5%

/86./ Хэрвээ та тариа соруулж байх үед зүүнийхээ их биенд хуруугаа хүргэчихвэл ямар арга хэмжээ авах вэ?

A. Бээлийтэй юм чинь зүүг хэрэглэж тариаг хийнэ.
B. Зүүг шинээр сольж өөр зүү хэрэглэнэ.
C. Зүүний их биеийг спиртээр ариутгаад хэрэглэнэ.

/87./ Тариа хийхийн өмнө өвчтөнийхөө биеийн булчинг суллахад яаж туслах вэ?

A. Өвдөгний болон тохойн үеэр нугалах
B. Булчинг суллаж зогсоно.
C. Хэвтүүлнэ
D. Булчингаа сул байлгахыг хүснэ

/88./ Хүлээн авах тасагт бичиг баримтгүй ирсэн хүний бие гэнэт муудахад сувилагч ямар арга хэмжээ авах вэ?

A. Тухайн хүнийг үзэж шаардлагатай тусламжийг үзүүлнэ
B. Түргэн тусламж дуудна
C. Бичиг баримтыг бүрдүүлэхээр буцаана.
D. Шинжилгээ авна.

/89./ Нярай хүүхэд нэг минутанд хэдэн удаа амьсгалах вэ?

A. 40-45
B. 16-20
C. 20-30
D. 30-40
E. 60-80

/90./ Фурациллины хэдэн процентийн уусмалаар шарх угаах вэ?

A. 1х200
B. 1х10000
C. 1х500
D. 2 %
E. 1х5000

/91./ Каццоны сорилоор ямар өвчин тээгчийг илрүүлэх вэ?

A. Бэтэг
B. Бруцеллёз
C. Сүрьеэ
D. Халдварт саа
E. Ревматизм

/92./ Масловийн хэрэгцээний эрэмбийн хамгийн доод ба үндсэн хэрэгцээ юу вэ?

A. Аюулгүй байдал
B. Физиологийн
C. Хайрлах ба хүндлүүлэх
D. Өөрийгөө илэрхийлэх
E. Хайр ба эд юмс

/93./ Булчинд тарилга хийхээр хатгасан газраас цус гарвал тарилгыг яаж хийх вэ?

A. Зүүг гүн хатгаж тариаг шахна.
B. Зүүг сугалан авч өөр талбай сонгон тарилгыг хийнэ.
C. Зүүг сугалж, солиод өөр тайлбайд хатгалтыг хийнэ.
D. Зүүг сугалан авч өөр зүү, тариураар өөр талбайг сонгож хатгалт хийнэ.

/94./ Эмнэлэг хамгааллын дэглэмийг хэн хамгийн түрүүнд мөрдөх вэ ?

A. Өвчтөн
B. Эмнэлгийн ажиллагсад
C. Өвчтний ар гэр
D. Эмнэлгээр үйлчлүүлэгсэд

/95./ Тархинд хий шахсан өвчтөнг хэдэн цаг хэвтрийн дэглэмд байлгах вэ?

A. 24 цаг
B. 48 цаг
C. 72 цаг
D. 2 цаг

E. 12 цаг
/96./ Аль нь биологийн тохироо вэ?
A. Өвчтөнд 25 мл цус хийгээд 5 минут ажиглан, үйлдлийг 3 удаа давтаж хийнэ.
B. Өвчтөний цусны сийвэнг донорын цустай хольж үзнэ.
C. Донорын цусыг өвчтөний цустай хольж үзнэ.
D. Донорын цусны ийлдсийг өвчтөний цустай хольж үзнэ.
/97./ Эмийн бодисыг тарихын өмнө шалгахдаа эхлээд юуг нь шалгах вэ?
A. Нэр, тун, хэмжээ
B. Хугацаа
C. Тунадас
D. Тухайн хүнд хийх тариа мөн эсэхийг эмийн түүвэртэй тулгана
/98./ 3 сартай, өвчний улмаас эмчийн заалтаар пенициллинийг 125000 ед –ээр 6 цагийн зайтай тарих шаардлагатай . Тарих талбайг сонгоно уу.
A. Өгзөгний гадна дээд 1/4
B. Хэвлийн урд хананы булчинд
C. Мөрний гурвалжин булчинд
D. Далны доод дугуй булчинд
E. Гуяны өмнө ба гадна хэсгийн булчинд
/99./ Цэвэрлэх бургуй тавихад өвчтөний байрлал ямар байвал тохиромжтой вэ?
A. Баруун хажуугаар нь хэвтүүлэх
B. Зүүн хажуугаар нь хэвтүүлэх
C. Өвдөг тохойн байрлалд
D. Эгц доош нь харуулах
/100./ Амьсгалын тоо хэвийн хэмжээнээс цөөн болохыг юу гэж нэрлэх вэ?
A. Тахипноэ
B. Брадипноэ
C. Тахикарди
D. Брадикарди
/101./ Новокайны хэдэн процентын уусмалаар антибиотекийг найруулж өвчтөнд тарьж хэрэглэдэг вэ?
A. 10%
B. 5%
C. 2%
D. 1%
E. 0,25 %
/102./ Цусны элментүүд хаана үүсдэг вэ?
A. Элэг
B. Дэлүү
C. Ясны чөмөг
D. Нойр булчирхай
/103./ Булчинд тариа хийхэд хэдэн номерийн ямар хэмжээний зүүг сонгох вэ?
A. 24-26G, 2-3 см-ын урттай нарийн зүү
B. 18-23G, 6-8 см –ийн урттай зүү
C. 20-22G, 4-5 см-ийн урттай зүү
/104./ Кварцын гэрлээр тарианы өрөөний юуг ариутгадаг вэ?
A. Тарилганд хэрэглэгдэх зүйлийг
B. Тарианы ширээг
C. Тасалгааны агаарыг
D. Өрөөнд байгаа эд хогшлыг
/105./ Арьсан дор тариаг шахахын өмнө яагаад бүлүүрийг татаж үздэг вэ?
A. Зүү битүүрсэн эсэхийг шалгах
B. Тариурт хийг нэмэхэд эд эсийг цочроохгүй болгодог
C. Судас дайрсан эсэхийг шалгах
/106./ Бичил бургуйг хэдэн хэмийн уусмалаар тавих вэ?
A. 34 – 35 хэм
B. 37 – 38 хэм

C. 35- 36 хэм
D. 38 – 39 хэм
E. 40 хэм
/107./ Арьсаар эмийн бодис хэрэглэх аргыг сонгоно уу?
A. Нүдэнд эм дусаах
B. Хамарт эм дусаах
C. Чихэнд эм дусаах
D. Түрхлэг хэлбэрээр хэрэглэх
E. Амаар уулгах
/108./ Аль нь хувийн тохироо вэ?
A. Өвчтөнд 25 мл цус хийгээд 5 минут ажиглан, үйлдлийг 3 удаа давтаж хийнэ
B. Өвчтөний цусны сийвэнг донорын цустай хольж үзнэ.
C. Донорын цусыг өвчтөний цустай хольж үзнэ.
D. Донорын цусны ийлдсийг өвчтөний цустай хольж үзнэ.
/109./ Сүрьеэгийн сорилын хариу хэдэн цагийн дараа гарах вэ?
A. 1 цагийн дараа
B. 12 цагийн дараа
C. 48 цагийн дараа
D. 72 цагийн дараа
E. 7 хоногийн дараа
/110./ Яагаад эмчийн оношийг мэдэх нь хамгийн чухал вэ?
A. Өвчтөнийг үнэлэхэд туслана
B. Өвчтөний тухай мэдэхэд илүү хэрэгтэй
C. Өвчтөнд сувилгааны онош тавихад
D. Өвчний түүхийг ойлгоход
/111./ Эмнэлгийн ажилтнаас шалтгаант өвчин гэж юу вэ?
A. Эмнэлгийн ажилтны болгоомжгүй үйлдлээс, бас хариуцлагагүй хандлагаас буюу үгнээс болж үйлчлүүлэгчийн эрүүл мэнд хохирохыг эмнэлгийн ажилтнаас шалтгаант өвчин гэнэ.
B. Эмнэлгийн ажилтны болгоомжгүй үйлдэл ,үг хэллэг эмнэлгийн нууц задрааснаас болох өвчнийг эмнэлгийн ажилтнаас шалтгаант өвчин гэнэ.
C. Эмч сувилагчдын хоорондын хов жив хэрүүл маргаанаас болох өвчнийг эмнэлгийн ажилтнаас шалтгаант өвчин гэнэ.
D. Эмч сувилагч хоорондын үл ойлголцлоос үүсэх өвчнийг эмнэлгийн ажилтнаас шалтгаант өвчин гэнэ.
/112./ Шүлтээр хордсон үед ямар уусмалаар ходоодыг угаах вэ?
A. Буцалгасан ус
B. Нимбэгний хүчлийн уусмалаар
C. Содын уусмалаар
D. Фурациллины уусмал
/113./ Металл багажийг содын 2%-ийн уусмалд эсвэл усанд хэдэн минут буцалгаж ариутгадаг вэ?
A. 5-10мин
B. 10-15 мин
C. 20-30 мин
D. 35-40 мин
E. 40-50мин
/114./ Амьсгалын тоо хэвийн хэмжээнээс олшрохыг юу гэж нэрлэх вэ?
A. Тахипноэ
B. Брадипноэ
C. Тахикарди
D. Брадикарди
/115./ Тарих талбайг ямар бодисоор ариутгах вэ?
A. Натри хлорид 0,9%
B. Маргенц 1:1000
C. Спирт 90%,
D. Спирт 76%

/116./ Хураагуур судаснаас шинжилгээнд зориулж насанд хүрсэн хүнээс хэдэн мл цус авах вэ?

A. 5-10мл
B. 20-25мл
C. 25-30мл
D. 20-30мл
E. 10-18мл

/117./ Булчин тариа хийх үед яагаад тромбо үүсдэг вэ?

1. Асептик зарчим алдагдснаас
2. Судас дайрсан эсэхийг шалгаагүй хийснээс
3. Тосон тариаг хийтэй шахснаас
4. Тосон тариа хийх үед судас дайрсан эсэхийг шалгаагүй хийснээс
5. Тосон тариаг бүлээсгэж хийгээгүйгээс

/118./ Шигдээстэй өвчтөнд сувилгааны дараах зарчим баримтлана.

1. Өдөрт 2-3 удаа хооллоно.
2. Өвчтөнд өнжөөд цэвэрлэх клизм тавьж бие засуулна.
3. Хэвтрийн дэглэм эхний 2,3 өдөр баримтлана.
4. Холголт цооролтоос урьдчилан сэргийлнэ
5. Өвчнийх нь байдлыг нууцлана.

/119./ Халуун бигнүүрт аль нь хамаарагдах вэ?

1. Халуун шүршүүр
2. Халуун ус
3. Бүлээн устай ванн
4. Халуун усанд норгосон алчуур
5. Лааны тос

/120./ Амьсгалын хэлбэрүүдийг нэрлэнэ үү?

1. Цээжний
2. Хэвлийн
3. Холимог
4. Тазны
5. Өрцний

/121./ Эмийн бодисыг парентераль аргаар хэрэглэх гэж юу вэ?

1. Эмийн бодисыг ууж хэрэглэх
2. Эмийн бодисыг арьсан дор тарьж хэрэглэх
3. Эмийн бодисыг шулуун гэдсээр хэрэглэх
4. Эмийн бодисыг судсанд тарьж хэрэглэх
5. Эмийн бодисыг амьсгалын замаар хэрэглэх

/122./ Бумба тавих талбайг сонгоно уу?

1. Цээжний ард багана нурууны 2 талаар
2. Өгзөг, гуяны араар
3. Шилэн хүзүү, мөрөөр
4. Цээжний урд зүүн дээд хэсэгт
5. Нурууны нугалмаар

/123./ Донор цусаа өгөхийг ямар тохиолдлуудад хориглодог вэ?

1. Нян, вирус, бактерийн эрүүл тээгч
2. Мансууруулах донтон
3. Хорт хавдартай
4. Тэмбүү, ДОХ-оор өвчилсөн
5. Тамхи татдаг бол

/124./ Хэвлийн хөндийд хатгалт хийхдээ үйлчлүүлэгчийг хэрхэн байрлуулах вэ ?

1. Сандал дээр гэдрэг нь налуулж суулгана.
2. Хагас суугаа байрлалд байрлуулна.
3. Үйлчлүүлэгчийг орон дээр хажуугийн байрлалаар хэвтүүлнэ
4. Доош харуулан хэвтүүлнэ.
5. Сандал дээр суулгаад эрүүл тал руу нь хазайлгана.

/125./ Зүрхний архаг дутмагшилтай өвчтөний асаргаа сувилгаанд аль нь чухал вэ?

1. Хэвтрийн дэглэм
2. Толгойн хэсгийг өндөрсгөх
3. Хэрэглэх шингэн болон давсны хэмжээг хязгаарлах
4. Хаванг хянах
5. Хүчилтөрөгч эмчилгээ

/126./ Эрүүл мэндийн боловсрол олгох сургалтыг явуулахын гол зорилго юу вэ?
1. Өвчтөнийг хурдан эдгээх
2. Эрүүл аж төрөх
3. Өвчний тухай мэдлэг өгөх
4. Өвчнөөс урьдчилан сэргийлэх
5. Эмнэлэгтэй холбоо тогтоох

/127./ Эрүүл мэндийн боловсрол олгосноор ямар амжилтанд хүрэх вэ?
1. Мэддэггүйгээс мэддэг болох
2. Буруу ойлголтоос зөв ойлголтод шилжих
3. Тохиромжгүй хандлагаас тохиромжтой хандлагад шилжих
4. Буруу зуршлаас зөв дадалд төлөвшинө
5. Эрүүл мэндийн үзүүлэлт нь дээшилнэ

/128./ Цооролт үүсэж болох талбайг сонгоно уу?
1. Ахар сүүлний хэсэг
2. Өсгий
3. Дал нурууны шонтон ясны хэсэг
4. Хөлийн шагай
5. Ташаан толгой

/129./ Давсаг угаахад ямар хүндрэл гарч болох вэ?
1. Шээлгүүр тавьж чадахгүй байх
2. Өгсөх замын халдвар
3. Шүүсний сүв нарийн байх
4. Давсаг, шээсний сүвийг гэмтээх
5. Давсаг чинэрч өвдөх

/130./ Кальци хлоридийг судасны гадуур алдсан тохиолдолд ямар арга хэмжээ авах вэ?
1. 2%-ний натри хлоридийн уусмалаар боолт хийнэ.
2. 25% -ий магнизм сульфатыг алдсан хэсэгт тарина.
3. 15% -ий магнизм сульфуриц алдсан хэсэгт тарина.
4. 10%-ний натри хлоридийн уусмалаар боолт хийнэ.
5. Алдсан газар нэрмэл ус тарина.

/131./ Дотоод халдвар гарч байгаа үндсэн шалтгаануудад юу орох вэ?
1. Эмч эмнэлгийн ажилчид халдвар хамгааллын дэглэм бүрэн сахиагүйгээс
2. Эмчлүүлэгчид эмнэлэг хамгааллын дэглэм сахиагүйгээс
3. Өвчтөнийг буруу дутуу оношлосноос
4. Асептик анти септик дэглэмийг буруу сахиснаас
5. Эмнэлгийн цэвэрлэгээ ариутгал муугаас

/132./ Цус харвалттай өвчтөнд юунаас сэргийлж, хурдан боловсрох эслэг ихтэй хоол өгч, шингэнийг уулгадаг вэ?
1. Цооролт
2. Жин алдалт
3. Хөдөлгөөний хомсдол
4. Өтгөн хаталт
5. Шингэн алдалт

/133./ Сувилгааны үйл ажиллагааг судалж мэдэхийн ач холбогдол юу вэ?
1. Асуудал шийдэх чадвартай болно
2. Дүгнэх аргад суралцана
3. Сэтгэн бодох шийдвэр гаргах аргад суралцана.
4. Эрдэм шинжилгээ судалгааны ажлын үндэс болно.
5. Зөв шийдвэр гаргах аргад суралцана.

/134./ Арьсан дор тариа хийх үед ямар хүндрэлүүд гарч болох вэ?

1. Буглаа үүсэх
2. Судас, мэдрэл гэмтэх
3. Эд эсийн үхжил үүсэх
4. Өвдөлт ихээр өгөх
5. Зүү хугарах

/135./ Өвчтөний өрөөний агааржуулалтыг хэдийд хийвэл хамгийн тохиромжтой вэ?
1. Өглөө боссоны дараа
2. Идээт боолт сольсны дараа
3. Бие зассаны дараа
4. Унтахын өмнө
5. Хоол идэхийн өмнө

/136./ Цөс угааж болохгүй заалтыг нэрлэнэ үү?
1. Цөсний хурц үрэвслийн үед
2. Цөсний чулуутай үед
3. Ходоод улаан хоолойноос цус алдаж байвал
4. Цөс тогтонго болсон үед
5. Цөсний архаг үрэвсэл

/137./ Булчин тарианы үед яагаад бэрсүү үүсдэг вэ?
1. Антибиотикийг шаардагдах хэмжээний уусмалаар найруулаагүйгээс
2. Тарилга арьсан дор хийгдсэнээс
3. Булчинд хэрэглэх зүүг буруу сонгосноос
4. Булчинд буруу эмийн бодисыг хийснээс
5. Удаан шимэгддэг тариаг булчинд тарьснаас

/138./ Хуурай халуун жинг юугаар тавьж болох вэ?
1. Грелкээр
2. Халуун чулуугаар
3. Цахилгаан жинтүү
4. Халуун элсээр
5. Гэрлээр шарах

/139./ Ампициллин хэрэглэж байгаа өвчтөний амны хөндийн салстад цагаан өнгөр бий болов. Ямар арга хэмжээ авах вэ?
1. Амны хөндийн арчилгааг сайжруулах
2. Шүдээ хоол идсэний дараа цэвэрлэхийг зөвлөх
3. Мөөгөнцрийн эсрэг бэлдмэл өгөх /нистатин/
4. Амны хөндийн салстаас арчдас авч, нян судлалын шинжилгээ хийх
5. Хиймэл шүдээ авч байхыг зөвлөх

/140./ Цус цусан бүтээгдэхүүн судсаар юүлэхэд анхаарах зүйлүүд юу вэ?
1. Үйлдвэрлэсэн он, сар, өдөр, серийн дугаар
2. Өвчтөний халууныг үзэх
3. Цусны хувийн тохироо үзэх
4. Бүлгийн тохироо үзэх
5. Биологийн тохироо үзэх

/141./ Шээс хаагдсан өвчтөнд ямар сувилгаа хийх вэ?
1. Өвчтөнг ганцааранг нь түр орхих
2. Бэлэг эрхтэнийг бүлээн усаар угаах
3. Эмчийн заалтаар шээлгүүр тавих
4. Давсган дээр жин тавих
5. Спазм тавиулах эм өгөх

/142./ Эм тараасны дараа нэг өвчтөн маш их айж сандарсан, зовиурласан, сэтгэлээр унасан байдалтай танд хандлаа энэ юунаас болсон гэж бодож байна вэ?
1. Буруу эм ууснаас
2. Эмийн гаж нөлөөг тайлбарлаж өгөөгүйгээс
3. Эмийн гаж нөлөө илэрснээс
4. Эмээ уух цаг болоогүй байхад яарч ууснаас
5. Өвчин нь гэнэт хүндэрсэнээс

/143./ Метронидазолыг энтербиозыг эмчлэхэд хэрэглэнэ. Яагаад гэвэл цагаан хорхойн эсрэг эмийн бүлэгт орно.

/144./ Эм хэрэглэхэд анхаарах дүрмийг дурьдана уу?
1. Харшил урвал өгдөг эсэхийг лавлана
2. Тун хэмжээ нь зөв эсэхийг тодруулна
3. Тухайн өвчтөнд олгох эм мөн эсэхийг тодруулна
4. Тухайн эмийг ямар замаар хэрэглэхийг мэддэг
5. Тухайн эмийг өгөх цаг мөн эсэхийг тодруулна

/145./ Бумба тавих заалтыг тодорхойлно уу?
1. Гуурсан хоолойн үрэвсэл
2. Уушигны үрэвсэл
3. Хавирга хоорондын үрэвсэл
4. Нуруу цээжний өвдөлт
5. Уушигны сүрьеэгийн идэвхитэй хэлбэрийн үед

/146./ Ходоод угааж болохгүй эсрэг заалтыг тодорхойлно уу?
1. Улаан хоолойн венийн судас өргөссөн тохиолдолд
2. Ходоод улаан хоолойноос цус алдаж буй үед
3. Жирэмсний сүүлийн саруудад
4. Эмийн бодисоор хордсон үед
5. Химийн бодисын хордлогын үед

/147./ Цооролт үүсэх гадаад шалтгааныг тодорхойлно уу?
1. Асаргаа, сувилгаа муу байснаас
2. Гадны ямар нэгэн зүйлд удаан хугацаагаар дарагдснаас
3. Үйлчлүүлэгчийг нэг байрлалд удаан хэвтүүлснээс
4. Биеийн эсэргүүцэл муу байснаас
5. Мэдрэл тэжээлийн дутагдал болсноос

/148./ Эмнэлэг хамгаалалын дэглэмийг сахихгүйгээс гарах үр нөлөө хэнд тусах вэ ?
1. Өвчтөнд
2. Эмнэлгийн ажиллагсдад
3. Хамт ажиллагсдад
4. Эмнэлгээр үйлчлүүлэгсдэд
5. Өвчтний ар гэрт

/149./ Сувилагч гардан ур чадварт хэрхэн суралцах вэ?
1. Үйлдлийг олон дахин давтан, чин сэтгэлээсээ гүйцэтгэх
2. Сувилагч нарын туршлагаас судлах, суралцах
3. Алдаан дээрээ ярилцах, мэтгэлцэх
4. Өөрийн туршлагаа баяжуулж, ном унших
5. Сургалтын кино үзэж, ном сэтгүүл ашиглах

/150./ Ямар зорилгоор арьсан дотор тариаг хийдэг вэ?
1. Эмийн бодисыг амаар ууж хэрэглэж чадахгүй үед
2. Харшлыг оношлох, тогтоох
3. Бие махбодид удаан шимэгддэг эмийн бодисыг тарих
4. Бие махбодид өвчний үүсгэгч байгаа эсэхийг мэдэх
5. Зүрх, судас, амьсгалын замыг дэмжих эм тариаг хийх

/151./ Биеийн халууныг хэмждэг хэрэгслүүдийг нэрлэнэ үү?
1. Чихний сувгаар халуун үздэг термометр
2. Амны хөндийгөөр халуун үздэг термометр
3. Шулуун гэдсээр халуун үздэг термометр
4. Арьсны гадаргуугаар халуун үздэг термометр
5. Зайнаас халуун үздэг термометр

/152./ Цус сэлбэж болох заалтуудыг нэрлэнэ үү?
1. Цус багадсан үед
2. Цус алдсан тохиолдолд
3. Хагалгааны өмнө ба хагалгааны дараа
4. Бөөрний хурц үрэвслийн үед

5. Цусны даралт багасах өвчний үед

/153./ Ямар тохиолдолд мөстэй уут /жин/ хэрэглэдэг вэ?
1. Бөөрний колик
2. Дотуур цус алдалт
3. Тарианы дараах бэрсүү үүссэн үед
4. Өндөр халуурах
5. Ходоод өвдөх

/154./ Бөөр, шээсний замын өвчлөлийн үед илрэх хавагналт нь зүрхний хавангаас ямар шинж байдлаар ялгаатай вэ?
1. Хавангийн байдал хатуу
2. Үүссэн хавантай хэсгийн өнгө цайвар
3. Үүссэн хавантай хэсгийн өнгө хөх
4. Хаван нь зөөлөн сэвсгэр, дээрээсээ доош илэрдэг
5. Хавантай хэсгийг дарахад хонхор үүсдэг

/155./ Эмийг харж байгаад уулгах нь ямар ач холбогдолтой вэ?
1. Эдийн засгийн
2. Эмчилгээний үр дүнг хянах
3. Эмэнд итгэх итгэлийг төрүүлэх
4. Хариу урвал өгөх эсэхийг хянах
5. Эмчлүүлэгчийг хянах

/156./ Шээлгүүр тавих зорилгыг тодорхойлно уу?
1. Давсаг угаах
2. Давсган дахь шээсийг авах
3. Давсганд эмийн бодис хийх
4. Давсаг дурандахын өмнө
5. Давсганд мэс засал хийхийн өмнө

/157./ Венийн судсанд тарилга хийх үед юуг анхаарах èстой вэ?
1. Судсаар хольж болохгүй тарилгуудыг
2. Тарих эмийн нэр хаяг, хадгалах хугацаа, тун хэмжээ
3. Тарих талбай хатгах судсыг зөв сонгох
4. Тариурын зүү судсанд байгаа эсэхийг шалгах
5. Тарилыг аажим болгоомжтой шахах

/158./ Сувилгааны үйл ажиллагааны үнэлгээний шатлал ямар үйл ажиллагаанаас бүрдэх вэ?
1. Мэдээлэл цуглуулах
2. Мэдээллийг баталгаажуулах
3. Мэдээллийг эмхлэх цэгцлэх
4. Мэдээлэл дээр үндэслэн төлөвлөгөө зохиох
5. Мэдээлэл дээр үндэслэн сувилгааны онош тавих

/159./ Хаймсуур ходоодонд орсон эсэхийг шалгах аргыг сонгоно уу?
1. Хаймсуурын тэмдэглэлтэй хэсэг бүрэн орсон эсэхийг шалгана.
2. Ходоодноос шингэн соруулна.
3. Ходоод руу хий шахаад чагнана.
4. Өвчтөний амьсгалын хэмийг шалгана.
5. Ходоодыг тэмтэрч үзнэ.

/160./ Булчингийн эдэд ямар эмийн бодисыг хийдэг вэ?
1. Өвдөлт өгдөг, бие мах бодид удаан тархдаг
2. Булчинд тарих заалт бүхий эмийн бодис
3. Зарим нэгэн витаминууд
4. Антибиотикууд
5. Зүрхний глюкозитууд

/161./ Цэвэрлэх бургуй тавих эсрэг заалтыг заана уу?
1. Тэжээлийн бургуй тавихын өмнө
2. Хоол идсэн даруйд
3. Мэс засалд бэлтгэх үед
4. Хоол боловсруулах замаас цус алдаж байвал

5. Хордлогын үед

/162./ Сувилагч хүн үйлчлүүлэгчийн хувьд хэн бэ?
1. Эрүүл мэндээ бэхжүүлэхэд нь туслагч
2. Эрүүл мэндээ хамгаалахад нь туслагч
3. Эрүүл болохын төлөө тэмцэхэд нь туслагч
4. Ойр дотны зөвлөгч
5. Сувилгаа асаргаа үзүүлэх

/163./ Сувилагч тусламж үзүүлээд юуг тэмдэглэх вэ?
1. Өвчтөний биеийн байдлын талаарх мэдээлэл
2. Өвчтөнд үзүүлсэн тусламж, сувилгаа
3. Эмчилгээний хуудас
4. Тусламжийн үр дүн, өвчтөний биеийн өөрчлөлт
5. Ажиглалтын хуудас

/164./ Эмийн бодисыг тарилгаар зөв хийх зарчмыг сонгоно уу?
1. Үйлчлүүлэгч
2. Эмийн доз хэмжээ
3. Хэрэглэх зам
4. Тарих эмийн бодис
5. Хийх хугацаа

/165./ Артерийн даралтыг хэний аргаар хэмждэг вэ?
1. Франкын арга
2. Риво-Роччийн арга
3. Кочергений арга
4. Коротковын арга
5. Клемансын арга

/166./ Цус юүлж болохгүй шалтгаанд аль нь орох вэ?
1. Элэг, бөөрний үйл ажиллагааны хямрал
2. Зүрхний ажиллагааны алдагдал
3. Харшил ба идэвхтэй сүрьеэ
4. Хурц цус багадалтын үед
5. Хавдар өвчний үед

/167./ Халуун жин тавих зорилгыг тодорхойлно уу?
1. Дулаацуулах
2. Булчингийн агшилтыг сулруулах
3. Үрэвслийн процессийг нэмэгдүүлэх
4. Өвдөлт намдаах
5. Цусны судсыг өргөсгөх

/168./ Хүчилтөрөгч өгөх хэлбэрүүдийг сонгоно уу?
1. Хүчилтөрөгчийн дэр
2. Баллоноор амьсгалуулах
3. Хүчилтөрөгчийн майхан
4. Барокамер
5. Хүчилтөрөгчийн коктель

/169./ Бумбаны үйлчилгээг сонгоно уу?
1. Хэсэг газрын цусан хангамжийг сайжруулна.
2. Бие махбодид өөр төрлийн уургийн бодисын нөлөө үзүүлнэ.
3. Судасны нэвчимтгий чанарыг ихэсгэнэ.
4. Үүссэн хаван эргэж шимэгдэнэ.
5. Ойр орчмын эд эсэд хаван үүсгэнэ.

/170./ Судсанд тарилга хийх талбайг нэрлэнэ үү?
1. Тохойн өмнөх венийн судас
2. Шагайн вен
3. Гарын шууны вен
4. Гарын шууны артери
5. Тохойн өмнөх артерийн судас

/171./ Ямар эмгэгүүд шээс цочмог хаагдахад хүргэдэг вэ?

1. Түрүү булчирхайн хавдар
2. Бөөрний дутмагшил
3. Шээсний хос суваг дарагдах
4. Хэвлийн хөндийн хагалгааны дараа
5. Ерөнхий унтуулгатай мэс заслын дараа

/172./ Эмнэлгийн зориулалтын орны үүрэг нь юу вэ?
1. Өвчтөнг тохиромжтой байрлалд байлгах
2. Орыг амархан хялбархан хөдөлгөж байх
3. Сувилгаа, эмчилгээ хийхэд тохиромжтой байх
4. Өвчтөнд тааламжтай нөхцөл бүрдүүлэх
5. Өвчтөний орны өндөр 65-70 см байх

/173./ Хүйтэн жин ямар үйлчилгээ үзүүлэх вэ?
1. Хэсэг газрыг хөргөж цусны судсыг нарийсгана.
2. Мэдрэлийн төгсгөлийн мэдрэх чадварыг бууруулна.
3. Өвчин намдаана
4. Халуун бууруулна
5. Цусан хангамжийг багасгана.

/174./ Хүйтэн жин, бигнүүрийг ямар зорилгоор тавих вэ?
1. Тархины хавангаас урьдчилан сэргийлэх
2. Үрэвсэл намдаах
3. Цус алдалтыг зогсоох
4. Халуун бууруулах
5. Өвдөлт намдаах

/175./ Дусал тариа хийх үед хариу урвал ямар байдлаар илрэх вэ?
1. Ууц, нуруугээр хөших
2. Чичрэх
3. Толгой өвдөх
4. Дотор муухайрах
5. Хүйтэн хөлс гарах

/176./ Өтгөн хаталтын үед сувилгааны ямар арга хэмжээ авах вэ?
1. Эмчийн заалтаар цэвэрлэх бургуй тавих
2. Эмчийн заалтаар эм хэрэглэх
3. Иллэг массаж хийх
4. Хоолыг тохируулах
5. Хүйтэн жин тавих

/177./ Шинжилгээнд түрхэцийг хаанаас авч болох болох вэ?
1. Хоолойноос
2. Цэрнээс
3. Үтрээнээс
4. Хэвлийн хөндийнөөс
5. Үрэвсэлийн голомтоос

/178./ Тэжээлийн бургуйг яагаад дуслаар хийдэг вэ?
1. Гэдсийг хийгээр дүүргэхгүйн тулд
2. Хоолыг сайн шингээхийн тулд
3. Өвчтөнд аятай байлгахын тулд
4. Гэдэсний гүрвэлзэх хөдөлгөөнийг нэмэгдүүлэхгүйн тулд
5. Гэдэсний гүрвэлзэх хөдөлгөөн сайжирна

/179./ Судсанд тариаг ямар зорилгоор хийдэг вэ?
1. Тодруулагч бодисыг шахаж, шинжилгээ хийх
2. Унтуулах эмийн бодисыг тарьж ерөнхий мэдээ алдуулах
3. Шингэн сэлбэх
4. Вакцин тарих
5. Тосон тариаг хийх

/180./ Сувилахуйн тусламж үйлчилгээний чанар юугаар илэрхийлэгдэх вэ?
1. Үйлчлүүлэгч хурдан эдгэрэх
2. Үйлчлүүлэгч үйлчилгээндээ сэтгэл хангалуун байх

3. Үйлчилгээ хурдан байх
4. Үйлчлүүлэгчийн сэтгэлд нь хүртэл үйлчлэх
5. Үйлчлүүлэгчтэй сайхан харилцах

/181./ Ходоодонд зонд тавьж болохгүй заалт юу вэ?
1. Ходоод гэдэсний шархлаатай
2. Улаан хоолой нарийссан ба судас өргөссөн үед
3. Ходоод химийн бодисоор түлэгдсэн үед
4. Жирэмсний сүүлийн сард
5. Ходоод улаан хоолойноос цус алдаж байгаа үед

/182./ Булчинд тариа хийж болох талбайг сонгоно уу?
1. Өгзөгний гадна дээд хэсгийн булчин
2. Мөрний булчин
3. Гуяны гадна дунд хэсгийн булчин
4. Өгзөгний урд дээд хэсгийн булчин
5. Шууны булчин

/183./ Өрхийн сувилагч нар хүн амаа эрүүл мэндийн байдлаар хэдэн бүлэг болгон хуваадаг вэ?
1. Цоо эрүүл
2. Эрүүл
3. Ээнэгшил бүхий архаг өвчтэй
4. Хагас ээнэгшил бүхий архаг өвчтэй
5. Ээнэгшлээ алдсан архаг өвчтэй

/184./ Амьдралын төгсгөлийн шатны асаргаа сувилгааны зарчимд багтдаг зүйлсүүдээс аль нь багтдаг вэ?
1. Асаргааг үргэлжлүүлэх саналыг дэмжих.
2. Өвчтний амьдралын байдлыг өөрчлөх эмчилгээний бодитой аргаар хангах.
3. Хөнгөвчлөх эмчилгээ болон буяны асаргааг нэвтрүүлэх
4. Эмчилгээнээс татгалзах эрхийг хүлээн авахгүй байх
5. Зарим эмчилгээг үргэлжлүүлэхгүй гэсэн өвчтний болон ар гэрийнхний сэтгэл санааны давуу эрхийг хүндэтгэх.

/185./ Шээлгүүр тавилгүйгээр өвчтөнийг шээлгэж болох аргуудыг сонгоно уу?
1. Шээхийг шаардах
2. Шээхэд эвтэй байрлалыг сонгох
3. Бүлээн усанд гарыг дүрэх
4. Ус гоожиж байгаа чимээ сонсгох
5. Давсаг орчим дарах

/186./ Тарих эмийн бодисын хаягийг ямар үед шалгадаг вэ?
1. Тариаг соруулж дуусаад ампулаа хаяхын өмнө
2. Тариагаа сонгохдоо
3. Тариаг соруулахын өмнө
4. Тариаг соруулаад тариур дахь хийг гаргахад
5. Тариурыг угсарч бэлтгэсний дараа

/187./ Судасны лугшилтыг тоолоход тохиромжтой талбайг сонгоно уу?
1. Чамархайн артери
2. Шууны эрхий хуруу талын артери
3. Гүрээний артери дээр
4. Бугалганы артери
5. Хэвлийн артери

/188./ Элэгний архаг үрэвсэлт өвчтэй хүнд сувилахуйн дараах тусламж үзүүлнэ.
1. ХАГ-тай өвчтөний амыг цэвэр усаар өдөрт2-3 удаа зайлуулна
2. Машиндаж ууранд болгосон махтай хоол өгнө
3. Арьсыг цэвэр байлгана сулруулсан спирт камфорийн уусмалаар арчина
4. Өвчтөнд өөх тостой витаминлаг хоол өгнө
5. Хагас суугаа дэглэм сахиулна

/189./ Биеийн хэсэгчилсэн угаалгыг ямар зорилгоор хийдэг вэ?

1. Хувийн ариун цэврийг сахиулах
2. Өвчтөнийг тайвшруулан сэргээх
3. Бодисын солилцоог эрчимжүүлэх
4. Нуралт, цооролтоос сэргийлэх
5. Хурц халдварт өвчтэй хүнд угаалга хийх

/190./ Арьсан дор ямар эмийн бодис хийдэг вэ ?
1. Яаралтай тусламжийн эмийн бодисууд
2. Зарим нэгэн вакцин
3. Арьсан дор тарих заалт бүхий эмийн бодис
4. Бүх төрлийн витамин
5. Зүрх судас, амьсгалын замыг дэмжих эм

/191./ Хэвлий орчим бүлээн жин тавих эсрэг заалтыг нэрлэнэ үү?
1. Ходоодны шархлаа сэдэрсэн үед
2. Дотуур цус алдалт
3. Гэдэс базлах
4. Хэвлийн мэс заслын цочмог өвчин сэжиглэгдэж байгаа бол
5. Ходоод өвдөх

/192./ Дусал тарианы үед яагаад реакц өгдөг вэ?
1. Шингэн өвчтөнд тохирохгүй байснаас
2. Дуслыг хурдан хийснээс
3. Дусал хийж байх үед өвчтөнг дааруулснаас
4. Дуслыг хэт удаан хийснээс
5. Шингэнийг бүлээсгэж хийснээс

/193./ Ходоодыг угаах ямар арга байдаг вэ?
1. Механик арга
2. Хаймсууураар угаах арга
3. Бөөлжүүлэх эмийг арьсан дор тарих арга
4. Физикийн арга
5. Биологийн арга

/194./ Хүйтэн жин тавих зорилгыг тодорхойлно уу?
1. Цус алдалтыг зогсоох
2. Халуун бууруулах
3. Өвдөлт намдаах
4. Хаван бууруулах
5. Булчингийн агшилтыг сулруулах

/195./ Ямар зорилгоор толгойг угаах вэ?
1. Толгой, хуйхны цусан хангамжийг сайжруулах
2. Үсний ариун цэвэр сахиулах
3. Толгой хэсгийн ариун цэвэр эрүүл ахуйг хангах
4. Үйлчлүүлэгчийг амраах
5. Үйлчлүүлэгчийг тайвшруулах

/196./ Дусал тарианы үед яагаад реакц өгдөг вэ?
1. Шингэн өвчтөнд тохирохгүй байснаас
2. Дусал хийж байх үед өвчтөнийг дааруулснаас
3. Дуслыг хурдан хийснээс
4. Шингэнийг бүлээсгэж хийснээс
5. Дуслын хэт удаан хийснээс

/197./ Ходоод нь өвдөж буй өвчтөнд хийгдэх сувилгааг сонгоно уу?
1. Хүйтэн жин тавина.
2. Халуун жин тавина
3. Хоол сойно.
4. Эмчийн заалтаар эмчилгээ хийх
5. Цэвэрлэх бургуй тавина.

/198./ Бургуй тавихад яагаад бургуйн хошууг тослодог вэ?
1. Салт бүрхэвчийг гэмтэхээс сэргийлэх
2. Өвдөлтөөс сэргийлэх

3. Шулуун гэдэс рүү хошуу чөлөөтэй орох боломжийг бүрдүүлнэ
4. Ус чөлөөтэй орох боломжийг бүрдүүлэх
5. Бургуйн хошууг гэмтэхээс сэргийлэх

/199./ Булчин тариа хийх үед өвдөлтийг бага мэдрүүлэхийн тулд авах арга хэмжээг сонгоно уу?
1. Байрлалаа зөв сонгоно.
2. Z хэлбэрийн хатгалт хийнэ.
3. Сэтгэл санааг тайван байлгана.
4. Олон давтан нэг талбайд хатгалт хийж болохгүй.
5. Боломжтой бол эмийн бодисыг тарилгаас өөр замаар хэрэглэнэ

/200./ Амны хөндийг угаахын ач холбогдол юу вэ?
1. Амны хөндийг цэвэр байлгах
2. Амны хөндийн эвгүй үнэр, амтыг арилгах
3. Шүд цоорч буйл үрэвсэхээс сэргийлэх
4. Амны хөндийгөөс халдвар дамжихаас сэргийлэх
5. Хооллох дуршлыг нэмэгдүүлэх

/201./ Арьсан дор тарилга хийх зорилго юу вэ ?
1. Оношлогооны
2. Урьдчилан сэргийлэх
3. Сорил тодорхойлох
4. Эмчилгээний
5. Харшлыг тогтоох

/202./ Ходоод угаахын өмнө үйлчлүүлэгчээ хэрхэн бэлтгэх вэ?
1. Тайван хэвтүүлэх болон суугаа байрлалд
2. Өвчтөний хиймэл, шүд тагнайг авна.
3. Өвчтөнд үйлдлээ тайлбарлаж ойлгуулна.
4. 3 хоногийн өмнөөс цагаан хоол өгнө.
5. Өлөн байлгана.

/203./ Өрхийн сувилагч ямар үндсэн үүрэгтэй вэ?
1. Өрхийн эмчийн ажилд туслана
2. Өндөр настан, хүнд өвчтэй хүмүүст гэрээр тусламж үзүүлэх
3. Жирэмсэн эх, болон нярайг эргэх
4. Сайн дурынханд хичээл заана.
5. ЭМАШТ-ийн тайлан мэдээ гаргана.

/204./ Сувилагчийн чадварыг дотор нь юу гэж ангилдаг вэ?
1. Гардан хийх ур чадвар
2. Харилцааны ур чадвар
3. Сэтгэн бодох, шийдвэр гаргах ур чадвар
4. Хамтран ажиллах, багаар ажиллах чадвар
5. Компьютер дээр ажиллах чадвар

/205./ Сувилагч тариа хийх үед халдвараас сэргийлэх замуудыгсонгоно уу?
1. Хатгах талбайг ариутгана.
2. Бэлтгэсэн тариаг стандартын дагуу тариурт соруулна.
3. Тариурын хошуу заавал зүүтэй буюу тагтай байна.
4. Зүүний бүрхүүлийг авмагц хатгалтыг хийнэ.
5. Зүү тариурыг зөв барина.

/206./ Гич тавих заалтыг тодорхойлно уу?
1. Амьсгалын замын үрэвсэлт өвчнүүд
2. Хоолой өвдөх үед
3. Стеникардийн үед
4. Цусны даралт ихдэх өвчний кризийн үед
5. Невралгийн үед

/207./ Гэдэс дүүрсэн үед ямар арга хэмжээ авах вэ?
1. Гэдсэнд иллэг хийнэ
2. Идэвхижүүлсэн нүүрс өгнө
3. Хий гаргах гуурс тавина

4. Бүлээн жин тавина
5. Цэвэрлэх бургуй тавина

/208./ Цэвэрлэх бургуй тавих эсрэг заалтыг олно уу?
1. Хоол боловсруулах эрхтэнээс цус алдаж байгаа үед
2. Анус урагдах үед
3. Өвчтөн хавантай үед
4. Өтгөн хатахад
5. Янз бүрийн хордлогын үед

/209./ Өгзөгний булчинд тариаг хийхэд яагаад заавал өвчтөнийг хэвтүүлж тарьдаг вэ?
1. Өвдөлтийг бууруулах
2. Булчинг сулруулах
3. Эмийн бодисын шимэгдэх хурдыг нэмэгдүүлэх
4. Тарихад хамгийн эвтэй байрлал учраас
5. Өвчтөний сэтгэл санааг тайвшруулах

/210./ Хүчилтөрөгч өгөх заалтуудыг нэрлэнэ үү?
1. Төвийн хөхрөлт
2. Цээж хүчтэй хонхолзох үед
3. Амьсгалын тоо 70 –аас олон болох
4. Цочромтгой байдал илэрч гарах
5. Унтаарах

/211./ Ходоодонд хаймсуурыг ямар зорилгоор тавьдаг вэ?
1. Ходоод угаахын тулд
2. Хооллохын тулд
3. Эмийн бодис хэрэглэхийн тулд
4. Өвдөлт намдаахын тулд
5. Хоолны шингэц сайжруулахын тулд

/212./ Эрүүл мэндийн боловсрол олгоход ямар зарчим баримтлах вэ?
1. Сэдэв нь өгөөжтэй байх
2. Хугацаа нь богино байх
3. Асуудал, хэрэгцээнд үндэслэсэн байх
4. Суралцагсдийн тоо олон байх
5. Хугацаа нь урт байх

/213./ Хэвтрийн үйлчлүүлэгчийн цагаан хэрэглэлийг солих зорилго юу вэ?
1. Санаа сэтгэлийг өөдрөг тайван байлгах
2. Нуралт, цооролт, холголтоос хамгаалах
3. Жижиг үйрмэг, норсон хэрэглэлийг солих
4. Ариун цэвэр, эрүүл ахуйг сахиулах
5. Зовиур шаналгааг багасгах

/214./ Венийн судсанд дуслаар шингэн юүлэх заалтуудыг сонгоно уу?
1. Бие мах бодид шингэн дутагдсан үед
2. Янз бүрийн хордлогуудын үед хордлого тайлах
3. Цус алдсан үед
4. Хагалгааны өмнө ба дараа
5. Бие мах бодид эргэлдэх цусны нийт хэмжээг нэмэгдүүлэх

/215./ Бронхит ба бронхиалит өвчтэй хүнд хийгдэх сувилгааг тодорхойлно уу?
1. Биеийн идэвхтэй хөдөлгөөн хийлгэх
2. Өвчтэй талаар нь хэвтүүлж байх
3. Илчлэг, хялбар шингэх хоол өгөх
4. Хэвтрийн дэглэмд байлгах
5. Хоол сойх

/216./ Тасралтгүй бөөлжиж буй өвчтөнд ямар сувилахуйн тусламж үзүүлэх вэ?
1. Амыг нь цэвэр усаар байнга зайлуулна
2. Ходоод гэдэс угаана
3. Хиймэл шүднүүдийг авахуулна
4. Хагас суугаа байрлалд байрлана
5. Хэвлийд нь бүлээн жин тавина

/217./ Насанд хүрэгчдэд нуралт ямар шалтгаанаас үүсдэг вэ?
1. Удаан хугацаагаар хэвтэрт байх
2. Тарган хүмүүст
3. Холбох эд, эсийн элемент дутмаг учир
4. Ариун цэвэр сахиагүйгээс
5. Цусны судасны нэвчимтгий чанар ихэсснээс

/218./ Эмийн бодисыг шалгахдаа юуг нь шалгах вэ?
1. Нэр
2. Тун
3. Хэмжээ
4. Тундас
5. Хугацаа

/219./ Төмрийн бэлдмэлийг хэрэглэхэд ходоодны хүчиллэгийг анхаарах нь чухал. Яагаад гэвэл давсны хүчил төмөр шимэгдэхэд оролцоно.

/220./ Эмнэлэг хамгааллын дэглэмд хамаарах нөхцлүүдийг заана уу?
1. Гэрэл, дулаан, агаар
2. Больницын гадаад орчны ариун цэвэр
3. Эмнэлгийн байгууллагын ариун цэвэр
4. Дотоод дүрэм
5. Эмнэлгийн ажилчдын хувцаслалт

/221./ Асаргаа сувилгааны үндсэн зарчмуудад аль нь хамаарагдах вэ?
1. Орчин
2. Хоол
3. Хувцаслалт
4. Сэтгэл зүй
5. Шинж тэмдгийн асаргаа

/222./ Эмийн бодисын тарилгаар хэрэглэхийн дутагдалтай тал нь юу вэ?
1. Бие махбодид халдвар орох боломж бүрдэж болзошгүй
2. Эд эрхтэнийг зүүгээр хатгаж гэмтээдэг
3. Өвтгөж, эд эсийг цочроодог
4. Бие махбодид хурдан шимэгдэж үйлчилгээ үзүүлдэг
5. Халдваргүйжүүлэх дэглэм баримтлах шаардлага гардаггүй

/223./ Гичийг хэрэглэх аргуудыг сонгоно уу?
1. Гичтэй ванн
2. Наамал гич тавих
3. Гичтэй ороолт хийх
4. Гичтэй усанд хөл дүрэх
5. Гич, зөгийн балтай ороолт хийх

/224./ Ямар зорилгоор судсанд хатгалт хийж цус авдаг вэ?
1. Вессерманы урвал тавих
2. Цусны ариун чанарыг тодорхойлох
3. Цусны биохимийн шинжилгээ
4. Тодруулагч бодис шахах
5. Цусны групп тодорхойлох

/225./ Сувилгааны үйл ажиллагааны үнэлгээний шатлалд үнэлгээг хэрхэн өгөх вэ?
1. Ажиглах
2. Ярилцах
3. Үзлэг хийх
4. Онош тогтоох
5. Дүн шинжилгээ хийх

/226./ Цэвэрлэх бургуй тавих заалтыг олно уу?
1. Өтгөн хатсан тохиолдолд
2. Мэс заслын өмнө
3. Хэвлийн хөндийн эрхтэний зураг авахад

4. Янз бүрийн хордлогын үед
5. Өвчтөн хавантай үед

/227./ Стрептомициныг их тунгаар удаан хэрэглэвэл сонсголд нөлөөлдөг учир эмчийн хяналтан дор хэрэглэдэг яагаад гэвэл стрептомицин нь сүрьеэгийн микобактериас өөр нянд нөлөөлөхгүй.

/228./ Гичийг наамал, ороолт байдлаар хэрэглэдэг яагаад гэвэл гичний үйлчилгээ янз бүр байдаг учир тохирох аргыг сонгохдоо насны байдалд тохируулах нь илүү үр дүнтэй байдаг.

/229./ Эрүүл мэндийн боловсрол олгох гол зарчим нь өвчнөөс урьдчилан сэргийлэх учир хүн ардыг эрүүл аж төрөхөд тус болдог мөн, үйлчлүүлэгчийг эмнэлэгтэй холбож өгөхөд чиглэгдэнэ.

/230./ Хүчилтөрөгчийн майхан нь урсгалын хурдыг багаар шаарддаг учир, урсгал саадгүй эсэхийг шалгах, шаардлагагүй ба өртөг бага шаарддаг.

/231./ Сорил тарилгыг хийхэд уусмалын хэмжээ чухал байдаг яагаад гэвэл шууны 1/3 дунд хэсэгт тавьдаг учир өвдөлт үүсгэдэг.

/232./ Хураагуур судаснаас цус авахдаа вакутейнерийг хэрэглэх нь илүү тохиромжтой байдаг яагаад гэвэл нэг удаад 40-50 мл цусыг авдаг ба энэ нь стандарт хэмжээ юм.

/233./ Эмийн бодисыг тарилгаар хэрэглэхийн өмнө шалгахдаа эмийн түүвэртэй тулгадаг учир, соруулахын өмнө шалгах нь үр дүн багатай яагаад гэвэл ижил үйл ажиллагаа юм.

/234./ Биеийн халуун өглөө 9-11 цаг, оройн 16-18 цагийн хооронд багасдаг учир энэ үед өвчтөний халууныг үзэх шаардлагагүй яагаад гэвэл хэмжилт буруу гарна.

/235./ Үйлчлүүлэгчийн ходоодыг хаймсууруур угаахын тулд хиймэл шүдтэй тохиолдолд авдаг яагаад гэвэл хүндрэлээс сэргийлдэг бөгөөд, учир нь энэ үед өвчтөн цацах магадлалтай байдаг.

/236./ Нярай, хөлд ороогүй хүүхдэд өгзөгний арын дээд хэсэгт тарилга хийж болохгүй яагаад гэвэл мэдрэлийн ширхэг элбэг байдаг учир гуяны булчингийн урд 1/3 дунд хэсэгт тарьж болдог.

/237./ Хүчилтөрөгчийгэмчлүүлэгчтөвийн хөхрөлттэй үед өгдөг яагаад гэвэл хөхрөлтийг бууруулдаг бөгөөд мөн эмчлүүлэгчид цочиромтгой байдал илэрвэл хэрэглэнэ.

/238./ Булчин тарилгыг бугалганы дунд хэсэгт болон өгзөгний булчинд 60-90 хэмийн өнцгөөр тарьдаг учир шалгах шаардлагагүй байдаг яагаад гэвэл мэдрэлийн ширхэг багатай байдаг.

/239./ Судасны дотуур урсаж байгаа цус урсах хүчээрээ хананд даралт буй болгодог учир түүнийг цусны даралт гэх ба даралтыг Коротоковын аргаар хэмжинэ.

/240./ Халууралт гэдэг нь бие махбодийн гадны урвалын эсрэг хариу урвал учир, судасны лугшилт болон амьсгалын тоотой шууд хамааралтай.

/241./ Арьсан дор тарилга хийхдээ 30-45 градусын өнцөг үүсгэдэг учир зүүний үзүүрийн налуу хэсгийг дээш харуулж хатгадаг яагаад гэвэл энэ нь тарилгын зөв арга юм.

/242./ Асаргаа сувилгааны үндсэн зарчимд орчин хоол, хувцаслалт нь чухал яагаад гэвэл, эмчлүүлэгчийн сэтгэлзүйг дэмждэг учир хүн бүрт энэ үйл ажиллагааг төлөвлөдөг.

/243./ Амьсгалыг тоолохдоо зөвхөн ажиглах аргаар тоолдог яагаад гэвэл үйлчлүүлэгчид мэдэгдэхгүй байх нь чухал учир бусад арга нь үр дүн багатай байдаг.

/244./ Цэвэрлэх бургуйг янз бүрийн хордлогын үед тавьдаг, учир эмчлүүлэгч хоол боловсруулах эрхтнээс цус алдаж байгаа үед, мөн хавантай байвал цэвэрлэх бургуй тавихыг хориглоно.

/245./ Наамал гич нь цочроох үйлчилгээгээ +60 дээш хэмд алддаг учир 60+65 хэмийн усанд дүрж, хүйс орчимд нааж хэрэглэнэ.

/246./ Амьсгалаа гаргасны дараа цацлага хэрэглэх нь үр дүнтэй яагаад гэвэл үрэвслийг шууд бууруулдаг учраас өдрийн цагаар голчлон хэрэглэнэ.

/247./ Булчин тарилгыг 45 хэмийн өнцгөөр хийдэг яагаад гэвэл цусны судас бага тааралддаг учир өвдөлт бага байдаг.

/248./ Сорил тарилгыг харшлыг илрүүлэх зорилгоор тавьдаг учир бугалганы 1/3 орчмын талбайг сонгодог яагаад гэвэл зарим тохиолдолд халдвараас сэргийлэх зорилгоор тавьдаг.

/249./ Нойр булчирхайн цорго хаана нээгдэх вэ?

A. Нарийн гэдэсний өгсөх хэсэгт
B. Цөсний цоргонд
C. 12 хуруу гэдэсний уруудах хэсэгт

D. 12 хуруу гэдэсний өгсөх хэсэгт
E. Өлөн гэдсэнд
/250./ Насанд хүрсэн хүний цусны улаан эс хэд байх вэ?
A. 4-4.2х1012/л
B. 4.5-5х1012/л
C. 6.5-7х1012/л
D. 10-12х1012/л
E. 7-10х1012/л
/251./ Аккомодаци буюу нүдний зохицол гэж юу вэ
A. Ойрын зайд байгаа зүйлийг тод харахад нүдний зохицох чадвар
B. Холын зайд байгаа зүйлийг тод харахад нүдний зохицох чадвар
C. Бүдэг дүрсийг харахад чиглэгдсэн нүдний зохицол
D. Янз бүрийн зайд байгаа зүйлийг тод харахад нүдний зохицох чадвар
E. Дүрсийг тод харахад чиглэгдсэн нүдний зохицол
/252./ Чихний дэлбээ сонсох үйл ажиллагаанд яаж оролцох вэ?
A. Дууны долгионыг цуглуулна
B. Дууны долгионыг дамжуулна
C. Сонсох үйл ажиллагаанд оролцохгүй
D. Дууны долгионыг ялгана
E. Дууны долгионы хүчийг нэмэгдүүлнэ
/253./ Зүрхний байрлалыг зөв тодорхойлно уу?
A. Цээжний хөндийн голд байрлана
B. Цээжний хөндийд биеийн гол шугамнаас зүүн тийш 2/3 % байрлана
C. Цээжний хөндийд биеийн гол шугамнаас баруун тийш 2/3 % байрлана
D. Цээжний хөндийд биеийн гол шугамнаас зүүн тийш 1/3 % байрлана
E. Цээжний хөндийд биеийн гол шугамнаас баруун тийш 1/3 % байрлана
/254./ Физиологийн шинжлэх ухаан хүний бие махбодын юуг судалдаг вэ?
A. Бүтцийг
B. Өвчлөлийг
C. Гадаад орчны нөлөөллийг
D. Үйл ажиллагааны механизмыг
E. Эрүүл байдлыг
/255./ Цусны их эргэлтийн эхлэл төгсгөлийг сонгоно уу?
A. Баруун тосгуур баруун ховдол
B. Зүүн тосгуур зүүн ховдол
C. Зүүн ховдолоос баруун тосгуур
D. Баруун тосгуур зүүн ховдол
E. Зүүн тосгуур зүүн тосгуур
/256./ Зүрхний зүүн ховдол тосгуурын хооронд ямар хавхлага байрлах вэ?
A. 2 ба 3 хавтаст хавхлага
B. 3 хавтаст хавхлага
C. Хагас саран хавхлага
D. 2 хавтаст хавхлага
E. Хагас саран ба 3 хавтаст хавхлага
/257./ Симпатик мэдрэлийн үйл ажиллагааг сонгоно уу?
1. Хүүхэн харааг өргөсгөнө
2. Хоол боловсруулах шүүрлийг багасгана
3. Зүрхний үйл ажиллагааг идэвхжүүлнэ
4. Гуурсан хоолойг өргөсгөнө
5. Гуурсан хоолойг нарийсгана
/258./ Арьсны дайварт аль нь хамаарагдах вэ?
1. Үс
2. Хумс
3. Тосны булчирхай
4. Хөлсний булчирхай
5. Сүүний булчирхай

/259./ Амьсгалын дамжуулах замд аль нь орох вэ?
1. Хамрын хөндий
2. Төвөнх
3. Мөгөөрсөн хоолой
4. Улаан хоолой
5. Уушиг

/260./ Хамрын дагалдах хөндийд дараахаас аль нь орох вэ?
1. Духны
2. Хоншоорын
3. Самалдагийн
4. Хэнгэргэн хөндий
5. Хамрын хөндийн дээд хэсэг

/261./ Гөлгөр булчин ямар онцлогтой вэ?
1. Уян харимхай шинж чанартай
2. Энерги бага зарцуулна
3. Автомат шинж чанартай
4. Удаан ядрана
5. Үйл ажиллагааны нэгдмэл чанартай

/262./ Ясны ач холбогдолоос дурьдана уу?
1. Тулгуур хөдөлгөөний
2. Хамгаалах
3. Бодисын солилцоонд оролцох
4. Цус төлжүүлэх
5. Тээвэрлэх

/263./ Нейроны үндсэн үүргүүдийг сонгоно уу?
1. Өөртөө цахилгаан импульс үүсгэх
2. Мэдээллийг хүлээн авч задлан шинжлэх, дамжуулах, хадгалах
3. Зөвхөн мэдээллийг дамжуулах
4. Цочролд хариу өгөх, бусад нейронтой холбоо тогтоох
5. Цочролын хүчийг нэмэгдүүлэх

/264./ Үйлийн потенциаль гэж юу вэ?
1. Тайвны потенциалын хэлбэлзэл
2. Сэрэл
3. Зааг хүчээс доогуур хүчээр үйлчлэхэд үүсэх хэлбэлзлэл
4. Зааг хүчний нөлөөгөөр үүсэх потенциалын эгшин зуурын хэлбэлзлэл
5. Бие махбодын хариу урвал

/265./ Харааны туслах эрхтэнд дараахаас аль нь орох вэ?
1. Зовхи
2. Алимны булчин
3. Нулимсны аппарат
4. Нулимсны булчирхай
5. Нүдний алим

/266./ Уртавтар тархинд амьсгал, зүрх судас зэрэг амьдралын чухал үйл ажиллагааг зохицуулдаг төвүүд байдаг. Иймээс уртавтар тархи гэмтвэл шууд үхэлд хүрнэ.

/267./ Улаан хоолойн салст бүрхүүл нь хамгийн дотор талд байрладаг. Учир нь хоол залгих үед тэлж сунахад зохицсон дагуу үрчлээстэй.

/268./ Мейоз хуваагдлын төгсгөлд үүссэн 4 ширхэг төл эс 4 хромосомтой бол эх эс хэдэн хромосомтой байсан вэ?
A. 2
B. 4
C. 8
D. 6
E. 16

/269./ Генотип гэж юу вэ?
A. Хромосомын гаплоид бүрдэл

B. Популяцийн бүх генүүдийн нийлбэр
C. Организмын бүх генүүдийн ба шинж тэмдгүүдийн нийлбэр
D. Организмын бүх генүүдийн нийлбэр
E. Организмын бүх шинж тэмдгүүдийн нийлбэр

/270./ Хромосомын аль нэг хэсэг тасраад хуучин байрандаа 180 градус эргэж буцаж орохыг юу гэж нэрлэдэг вэ?
A. Делеци
B. Дупликаци
C. Индукци
D. Иммерси
E. Инверси

/271./ Хүүхдийн хялгасан хорхойн шинжилгээг хаанаас авдаг вэ?
A. Шээснээс
B. Амны хөндийгөөс
C. Анусны хуниаснаас
D. Цагаан хэрэглэлээс
E. Хумснаас

/272./ Эсийн плазмын мембранд хамгийн их хэмжээтэй байдаг липидийг нэрлэнэ үү?
A. Стерол
B. Фосфолипид
C. Гликолипид
D. Холестерол
E. Өөхтос

/273./ Ген гэж юу вэ?
A. ДНХ-ийн молекул
B. Нэг шинж тэмдгийн тухай мэдээллийг агуулсан РНХ-н молекулын хэсэг
C. Нэг молекул уургийн тухай мэдээлийг агуулсан ДНХ-н молекулын хэсэг
D. Хэд хэдэн молекул уургийн тухай мэдээллийг агуулсан ДНХ-н молекул
E. РНХ-н молекул

/274./ Хүүхдийн хялгасан эрэгчин хорхойн биеийн онцлог юу вэ?
A. Биеийн төгсгөл шулуун
B. Биеийн дунд хэсэг махийсан
C. Биеийн урд хэсэг махийсан
D. Биеийн төгсгөл мушгирч махийсан
E. Биеийн хэмжээ эмэгчинтэйгээ ижил

/275./ Кодоминант удамшил гэж юу вэ?
A. Бүрэн бус давамгайлах үзэгдэл
B. 1 хромосомд байрласан генүүд хамтдаа удамших
C. I үеийн эрлийзэд зөвхөн давамгайлах шинж илэрнэ
D. 2 өөр аллелийн хам үйлчлэлээр шинэ шинж тэмдэг үүснэ
E. Гетерозигот бие махбодид аль1аллель давамгайлахгүй

/276./ Х-хромосомынхоо гомологгүй хэсэгт ганц рецессив аллель агуулсан эрэгтэй хүнийг юу гэж нэрлэх вэ?
A. Гемозигот
B. Гемизигот
C. Зөөвөрлөгч
D. Гетерозигот
E. Гомозигот

/277./ Эрэгтэй хүнд генийн хэдэн хамсал бүлэг байдаг вэ?
A. 22
B. 23
C. 46
D. 4
E. 24

/278./ Аллель генүүд гэж юу вэ?
1. Нэг хромосомд зэрэгцэж байрласан генүүд

2. Нэг шинж тэмдгийн илрэх боломжийг тодорхойлсон генүүд
3. Гомолог бус хромосомуудын ижил локуст байрласан генүүд
4. Гомолог хромосомуудын ижил локуст байрласан генүүд
5. Нэг хромосомд тодорхой зайнд байрласан генүүд

/279./ Биологи нь анагаах ухааны суурь шинжлэх ухаан болдгийн учир юу вэ?
1. Хүн бол байгалийн бүтээгдэхүүн
2. Хүн бол биеэ даасан бүхэл бүтэн организм
3. Хүн бол амьдралын салшгүй чухал хэсэг
4. Хүн бол нийгмийн бүтээгдэхүүн
5. Хүн бол нийгмээрээ амьдардаг

/280./ Эсийн үндсэн үүргийг нэрлэнэ үү?
1. Бүтцийн
2. Үйл ажиллагааны
3. Үржлийн
4. Удамшлын
5. Хувьслын

/281./ Бодисын солилцоо гэж юу вэ?
1. Полимерт нэгдлүүд задарч, энерги ялгаруулна
2. Задрах, нийлэгжих процессын нэгдэл
3. Энгийн мономерт нэгдлүүд нийлж, энерги шингээнэ
4. Полимерт нэгдлүүд задарч, энерги шингээнэ
5. Энгийн мономерт нэгдлүүд нийлж, энерги ялгаруулна

/282./ мРНХ-ийн онцлог шинжийг нэрлэнэ үү?
1. Кариоплазмд байрлана
2. Цитоплазмд байрлана
3. ДНХ-ээс мэдээлэл уншина
4. РНХ-ийн 20%-ийг эзэлнэ
5. Гольджийн аппарат дээр байрлана

/283./ Хромосомын үүргийг нэрлэнэ үү?
1. Удамшлын мэдээлэл хадгална
2. Мэдээлэл дамжуулна
3. Мэдээлэл уншина
4. Мэдээллийг 2 дахин нэмэгдүүлнэ
5. Мэдээлэл ашиглана

/284./ Хүүхдүүд нь I, II, III, IY бүлгийн цустай болох нь тогтоогдсон бол эцэг эхийн цусны бүлгийг олно уу?
1. АА х ВО
2. АО х ВО
3. II х IY
4. II х III
5. АВ х ВО

/285./ Плазман мембраны үүргийг нэрлэнэ үү?
1. Сонгон нэвтрүүлэх
2. Осмос чанартай
3. Бодисын солилцоо явуулах
4. Хамгаалах
5. Эсийн хэлбэрийг хадгалах

/286./ Амёбуудын халдварлах замыг нэрлэнэ үү?
1. Бохир гар
2. Ялаа, жоом
3. Хүнсний ногоо
4. Түүхий ус
5. Бохир жимс, жимсгэнэ

/287./ Бэлгийн эсийн онцлогийг нэрлэнэ үү?
1. Бөөм цитоплазмын харьцаа өөр
2. Хромосомын дан цуглуулгатай

3. Бодисын солилцоо идэвхтэй
4. Мейоз хуваагдлаар хуваагддаг
5. Митоз, мейоз хуваагдлаар хуваагддаг

/288./ Эм цусанд шимэгдсэнийхээ дараа үйлдэл үзүүлэхийг хэсэг газрын үйлдэл гэнэ. Яагаад гэвэл хэсэг газрын үйлдэл гэдэг нь эм хүрэлцсэн тэр хэсэгтээ үйлчлэхийг хэлнэ.

/289./ Фосфолипидүүд плазмын мембраны үндсэн бүрэлдэхүүн мөн, учир нь гидрофоб, гидрофиль чанартай учир усан орчинд хоёр давхар бүхий бөмбөлгийг үүсгэдэг.

/290./ Генийн аллелийн нэг нь эхээс нөгөө нь эцгээс үр удамд дамжин илэрдэг учраас ген хос аллелуудаас тогтдог.

/291./ Биологи нь амьд биеийн оршин тогтнох, хөгжих зүй тогтлыг бүх түвшинд судалдаг учраас анагаах ухааны суурь болно.

/292./ Тураал /ерөнхий хатингаршил/-ын үед арьсанд ямар нөсөө хуримтлагдах вэ?
A. Гемосидерин
B. Меланин
C. Липохром
D. Липофусцин
E. Билирубин
/293./ Бээр гэж юуг хэлэх вэ?
A. Холбогч эдэд хуримтлагдсан идээ
B. Арьс руу нэвтрэн цоорсон идээ
C. Анатомийн хөндийд хуримтлагдсан идээ
D. Эрхтний ханаар тархсан идээ
E. Цул эрхтний идээ
/294./ Орлон томролд тохирох тодорхойлолтыг сонгоно уу?
A. Хос бус эрхтэнүүдэд үүснэ
B. Хөндийт эрхтэнд үүснэ
C. Сүв, цорго хаагдсанаас үүснэ
D. Эрхтэнд холбогч эд ургаснаас үүснэ
E. Хос эрхтнүүдэд үүснэ
/295./ Зүрхний ажлын томорлын үед ямар өөрчлөлт илрэх вэ?
A. Кардиомиоцитууд олширно
B. Кардиомиоцит томорно
C. Завсрын эд нь багасна
D. Өөхөн эд ихэснэ
E. Үнхэлцэг нь зузаарна
/296./ Хавдрын шалтгааныг тайлбарласан онолуудад аль нь орохгүй вэ?
A. Буруу хөгжлийн
B. Физик-химийн
C. Вирус-удамзүйн
D. Тодорхойгүй шалтгаант
E. Олон шалтгаант
/297./ Хуурамч томрол гэж юуг хэлэх вэ?
A. Эрхтэн томрох
B. Эрхтэн жижгэрэх
C. Эрхтний цуллаг хэсэг нь багасах
D. Эрхтний цуллаг хэсэг нь ихсэх
E. Завсарын эд багасах
/298./ Ангал (синус) гэж юуг хэлэх вэ?
A. Үрэвсэлт эд гадагшаа цоорч нүх үүсэх
B. Мэс ажилбараар үүсгэсэн нүх
C. Хөндийт эрхтэнүүдийн хана цоорч холбогдох

D. Цул эдийн гүний үрэвсэл
E. Битүү хөндийд үүссэн идээ

/299./ Хөдөлгөөний мэдрэлийн тасралаас ямар эд хатингарших вэ?
A. Зүрхний булчин
B. Ходоод гэдэсний гөлгөр булчин
C. Араг ясны булчин
D. Цусны судас
E. Үе мөч

/300./ Хоргүй хавдрын шинжүүдийг сонгоно уу?
1. Дахидаггүй
2. Нягт тогтоцтой
3. Эдийн гажигшилтай
4. Богино хугацаанд ургадаг
5. Нэвчрэлтэт ургалттай

/301./ Шүүдэс хуримтлагдахын ач холбогдол юу вэ?
1. Эсрэг биеийг ихэсгэнэ
2. Хорыг шингэлнэ
3. Нянг тархахаас сэргийлнэ
4. Фибринийг бөөгнөрүүлнэ
5. Шархыг эдгэрэхэд сөрөг нөлөө үзүүлнэ

/302./ Төлжлийн ерөнхий хэлбэрүүдийг сонгоно уу?
1. Сэргээлтийн төлжил
2. Эрүүл төлжил
3. Эмгэг төлжил
4. Цус үүсэх тогтолцооны төлжил
5. Мэдрэлийн төлжил

/303./ Үрэвсэл архагших шинжүүдийг олно уу?
1. Нейтрофил эсийн тоо цөөрнө
2. Судасны доторлуур эс үржинэ
3. Лимфоцит олширно
4. Сорвижих үйл явц идэвхжинэ
5. Фибробласт үржинэ

/304./ Аппоптоз гэж юуг хэлэх вэ?
1. Үхжлийн нэг хэлбэр
2. Гэмтсэн эсүүдийг устгах физиологийн үйл явц
3. Аажим удаан явцтай
4. Эсийн хөтөлбөрчлөгдсөн үхэл
5. Гадны хүчээр явагддаг үйл явц

/305./ Цус юүлэхэд 1 минутанд дусаах дуслын тоог тэмдэглэнэ үү?
A. 55 дусал
B. 45 дусал
C. 35 дусал
D. 25 дусал
E. 15 дусал

/306./ Мухар олгойн цочмог үрэвслийн элбэг тохиолдох байрлалыг сонгоно уу?
A. Мухар гэдэсний арын байрлал
B. Ташаа цавины байрлал
C. Аарцгийн байрлал
D. Элэгний дор байрлал
E. Гэдэсний гогцооны завсар

/307./ Биологийн тохироо үзэхдээ 5 минутын зайтайгаар хийх нийт цусны хэмжээг сонгоно уу?
A. 25 мл
B. 35 мл
C. 45 мл
D. 55 мл

E. 65 мл
/308./ Ариутгасан бикстэй материалыг нээгээгүй үед ариун чанараа хадгалах хугацааг
A. 24 цаг
B. 48 цаг
C. 72 цаг
D. 96 цаг
E. 120 цаг
/309./ Мухар олгойн хагалгааны үед ямар аргаар хэсгийн мэдээ алдуулалт хийх вэ?
A. Бөөрний өөхөнд новокайн хийх
B. Нэвчүүлэн мэдээ алдуулалт хийх
C. Хөлдөөж мэдээ алдуулалт хийх
D. Дамжуулах мэдээ алдуулалт хийх
E. Шүршиж мэдээ алдуулалт хийх
/310./ Орой, үзүүр, суурь, их биеэс тогтдог боолт хийх материалыг нэрлэнэ үү?
A. Уян бинт
B. Гурвалжин алчуур
C. Дөрвөлжилсөн марль
D. Цуулбар даавуу
E. Самбай алчуур
/311./ Хэдэн хэмийн усаар хөлдсөн мөчийг гэсгээх вэ?
A. 10 хэм
B. 15 хэм
C. 20 хэм
D. 25 хэм
E. 30 хэм
/312./ Хүний бие махбодид хэдэн литр цус байх вэ?
A. 3-5 л
B. 4-6 л
C. 5-7 л
D. 5-8 л
E. 8-10 л
/313./ Аль нь цээжний хөндийд цус хуралдах эмгэгийн нэршил вэ?
A. Пневмоторакс
B. Пиоторакс
C. Гемартроз
D. Гемоперитониум
E. Гемоторакс
/314./ Зүрх зогссоноос хойш хэдэн минутын дараа тархинд эргэлтгүй өөрчлөлт гарах вэ?
A. 10 минутын дараа
B. 12 минутын дараа
C. 5 минутын дараа
D. 1-2 минутын дараа
E. Зүрх зогсмогц
/315./ Боолт хийсэн мөчний цусан хангамжийг яаж шалгах вэ?
A. Эмчлүүлэгчээс асуух
B. Хумсан дээр дарж үзэх
C. Үеэр нь хөдөлгөж үзэх
D. Боолтоо хөдөлгөж үзэх
E. Мөчийг тэмтэрч үзэх
/316./ Донороос нэг удаа авч болох цусны хэмжээг тэмдэглэнэ үү?
A. 100-300 мл
B. 150-350 мл
C. 200-400 мл
D. 250-450 мл
E. 300-500 мл

/317./ Цээж шахалтыг аврах амьсгалуулалтгай хослуулан хийхдээ цээж шахалт , аврах амьсгалыг ямар харьцаагаар хийх вэ?
A. 100:1
B. 10:1
C. 15:2
D. 30:2
E. 20:2
/318./ Хүний биеийн гадаргуугийн хэдэн % түлэгдэхэд биед ерөнхий өөрчлөлт гарах вэ?
A. 10%-иас дээш
B. 15%-иас дээш
C. 25%-иас дээш
D. 30%-иас дээш
E. 40%-иас дээш
/319./ Хавдрын оношийг баталгаажуулах шинжилгээний аргыг сонгоно уу?
A. Рентген зураг авах
B. Бодит үзлэг хийх
C. Хэт авиан шинжилгээ
D. Эд эсийн шинжилгээ
E. Дурангийн шинжилгээ
/320./ Өөхөн эдийн гаралтай хавдрын нэршилийг тэмдэглэнэ үү?
A. Миома
B. Аденома
C. Ангиома
D. Липома
E. Ясны эдийн
/321./ Мэс засал гэж юуг хэлэх вэ?
A. Эмчилгээ оношлогооны нэгдэл
B. Анагаах ухааны салбар шинжлэх ухаан
C. Багажийн тусламжтай онош тодруулах арга
D. Эмчилгээ сувилгааны үндсэн хэлбэр
E. Судалгаа шинжилгээний үндсэн арга
/322./ Яаралтай тусламжийн тодорхойлолтыг сонгоно уу?
A. Осол гэмтэл, өвчлөлийн үед эмнэлэгт яаралтай хэвтүүлэх арга хэмжээ
B. Осол гэмтэл, өвчлөлийг бүртгэж мэргэжлийн байгуулагад мэдээлэх арга
C. Осол гэмтэл, өвчлөлийн үед эмч ирэх, эмнэлэгт хүргэхээс өмнө үзүүлэх тусламж
D. Үйлчлүүлэгчид тусламжийг сувилахуйн 5 шатлалаар үзүүлэхийг хэлнэ
E. Амьсгал, зүрх судасны үйл ажиллагааг яаралтай дэмжих үйлдэл
/323./ Хүүхдэд клиник үхэл ямар хугацаагаар үргэлжлэх вэ?
A. 1-3 минут
B. 2-4 минут
C. 3-5 минут
D. 5-7 минут
E. 8-10 минут
/324./ Үйлчлүүлэгчид бодит үзлэг хийхдээ тэмтрэлтийг яаж хийх вэ?
A. Өвчтэй хэсгээс нь эхлэн аюулхай руу зөөлөн тэмтэрнэ
B. Хэвлийн баруун доод хэсгээс эхлэн зөөлөн тэмтэрнэ
C. Аюулхайгаас зөөлөн тэмтэрч дараа нь гүнзгий тэмтэрнэ
D. Эрүүл талаас нь өвчтэй хэсэг рүү шилжүүлэн зөөлөн тэмтэрнэ
E. Эрүүл хэсгээс эхлэн хэвлийн баруун хэсэг рүү тэмтэрнэ
/325./ Биеийн гадаргуугийн 9% тай тэнцэх хэсгийг тэмдэглэнэ үү?
A. Ууц нурууны хэсэг
B. Доод мөч тус бүрдээ
C. Их биений урд хэсэг
D. Толгой, хүзүүний хэсэг
E. Гарын алганы хэсэг
/326./ Хамгийн түрүүнд тусламж үзүүлэх тохиолдолыг сонгоно уу?

A. Ухаангүй байгаа үед
B. Цус алдаж байгаа үед
C. Ясны хугаралтай үед
D. Бүтэлттэй байгаа үед
E. Үе нь мултарсан үед

/327./ Хэдэн хувийн фурациллины уусмалаар шарх угаах вэ?
A. 1:1000
B. 1:3000
C. 1:5000
D. 1:4000
E. 1:2000

/328./ Ямар багажийг формалины ууpаар ариутгах вэ?
A. Дурантай багаж
B. Жаньегийн тариур
C. Цус тогтоох багаж
D. Ховилтой сэтгүүр
E. Хутга, хайчнууд

/329./ Насанд хүрэгчдэд клиник үхлийн үеийн үргэлжлэх хугацааг тэмдэглэнэ үү?
A. 1-2 минут
B. 2-4 минут
C. 4-6 минут
D. 6-8 минут
E. 8-10 минут

/330./ Хугарсан мөчинд чиг тавихдаа ямар зарчим баримтлах вэ?
A. Хугацаа алдалгүй боолт хийх
B. Гөлтгөнөн боолт яаралтай тавих
C. Хоёр талын үеийг оролцуулах
D. Өвдөлтийг хурдан намдаах
E. Цус алдалтаас сэргийлэх

/331./ Цээж шахах үйлдлийг 1 минутанд хийх давтамжийн тоог тэмдэглэнэ үү?
A. 100 удаа
B. 90 удаа
C. 80 удаа
D. 60 удаа
E. 50 удаа

/332./ Концентрацитай хүчлээр түлэгдсэн үед үзүүлэх анхны тусламжийг сонгоно уу?
A. Иодын сулруулсан хандаар угаах
B. Содын сул уусмал, хүйтэн усаар угаах
C. Ямар нэгэн тосон түрлэг хийх
D. 10 %-ийн давсны уусмалаар угаах
E. Ариун самбайгаар арчиж хуурайшуулах

/333./ Ямар эрхтнээс цус алдвал хөөстэй цус гарах вэ?
A. Гэдэснээс
B. Ходоодноос
C. Уушгинаас
D. Улаан хоолойноос
E. Хамраас

/334./ Шархадсан хүн бүрт заавал хийх тарилгыг сонгоно уу?
A. Татрангийн эсрэг ийлдэс
B. Галзуугийн эсрэг вакцин
C. Хүний иммуноглобулин
D. Стафилакоккын хоргүйсүүр
E. Гамма глобулин

/335./ АВО стандарт ийлдэс ашиглан цусны бүлэг тодорхойлох үед тавган дээрхи 1,2-р хэсгийн цусанд наалдах урвал явагдсан бол бүлгийг тодорхойлно уу?
A. 1-р бүлэг

B. 2-р бүлэг
C. 3-р бүлэг
D. 4-р бүлэг
E. 5-р бүлэг

/336./ Зүсэх, огтлох, оёх, тэлэх, цус тогтоох зэрэг хагалгаа бүрт хэрэглэгддэг багажнуудын ерөнхий нэршилийг тэмдэглэнэ үү?

A. Мэс заслын багажууд
B. Ерөнхий хэрэглэгддэг багажууд
C. Анхны тусламжийн иж бүрдэл багаж
D. Нийтлэг хэрэглэгддэг багажууд
E. Шархны цэгцэлгээний багажууд

/337./ Өтгөн хатаахгүйн тулд ямар хоолыг зонхилон хэрэглэх вэ?

A. Нүүрс усаар баялаг хоол
B. Уургаар баялаг хоол
C. Түүхий сүүний бяслаг
D. Илчлэг сайтай хоол
E. Өөх тос ихтэй хоол

/338./ Мушгиа болон түрүү хэлбэрийн боолт хийх боолтын материалыг сонгоно уу?

A. Гурвалжин алчуур
B. Самбай алчуур
C. Бинт
D. Гоюу
E. Даавуу

/339./ Цусны сийвэн, дүрст элементийн харьцааг тэмдэглэнэ үү?

A. 45:65
B. 50:50
C. 55:45
D. 70:30
E. 80:20

/340./ Яаралтай журмаар хагалгаа хийх ходоодны эмгэгийг нэрлэнэ үү?

A. Ходоодны үрэвсэл
B. Ходоодны ур
C. Ходоод цоорох
D. Ходоодны шархлаа
E. Ходоодны хорт хавдар

/341./ Жижиг судасны гэмтлийн үед хүйтэн жин тавих хугацааг сонгоно уу?

A. 10 мин
B. 15 мин
C. 20 мин
D. 25 мин
E. 30 мин

/342./ 74. Биеийн халуун 1 хэмээр нэмэгдэхэд судасны лугшилт хэдээр олшрох вэ?

A. 25
B. 20
C. 15
D. 10
E. 5

/343./ Аль нь өнгөц түлэгдэлтэнд хамаарах вэ?

A. Арьсны өнгөн давхарга түлэгдэх
B. Арьс, арьсан доорх өөхөн эд түлэгдэх
C. Булчин шөрмөс түлэгдэх
D. Яс түлэгдэх
E. 3б, 4-р зэргийн түлэгдэлт

/344./ Аль нь мэдээ алдуулалтыг судалдаг шинжлэх ухааны нэршил вэ?

A. Гинекологи
B. Урологи

C. Анестезиологи
D. Физиологи
E. Эпидмиологи

/345./ Мухар олгойн үрэвслийн үед өвдөлт нь хаанаас эхлэх вэ?
A. Аюулхай хүйс орчмоос
B. Хэвлийн зүүн хэсгээс
C. Хэвлийн доод хэсгээс
D. Баруун хавирганаас
E. Бүсэлхий нуруунаас

/346./ Аврах амьсгалуулалтыг нэг удаад хэдэн секундын хугацаагаар хийх вэ?
A. 1 секунд
B. 2 секунд
C. 3 секунд
D. 4 секунд
E. 5 секунд

/347./ Цус гоожилтыг түр тогтоох аргуудыг сонгоно уу?
1. Даралттай боолт хиих
2. Үеэр нугалж боох
3. Судасны дээгүүр чангалуур тавих
4. Том судсан дээр хуруугаар дарах
5. Цус гарч байгаа мөчийг өргөх

/348./ Хагалгааны сувилагчийн гүйцэтгэх үүргийг сонгоно уу?
1. Хийгдэх хагалгаанд шаардлагатай багажийг бүрэн бэлтгэнэ
2. Багаж зөөлөн эдлэлийн ариутгалд хяналт тавьж, эмчид шалгуулна
3. Хэрэглэж буй багаж, бөмбөлөг, самбай алчуурын тоог хянаж тооцно
4. Хагалгааны явцад утас зүүг зөв сонгож өгнө.
5. Хагалгаа хийх эмчийн гарыг ариутгахад тусална.

/349./ Ивэрхийг байрлалаар нь ангилна уу?
1. Хүйсний ивэрхий
2. Гуяны ивэрхий
3. Цавины ивэрхий
4. Хэвлийн цагаан шугамын ивэрхий
5. Хэвлийн ханын ивэрхий

/350./ Хоргүй хавдар ямар шинж тэмдэгтэй вэ?
1. Хил хязгаар нь тодорхой
2. Гадуураа гэр бүрхүүлтэй
3. Мэс заслын дараа дахидаггүй
4. Тунгалагийн булчирхайд үсэрхийлдэг
5. Хавдрын хэмжээ аажим томордог

/351./ Эмчлүүлэгчийг байрлалаар нь ангилна уу?
1. Идэвхитэй
2. Албадмал
3. Идэвхгүй
4. Хэвтрийн
5. Суугаа

/352./ Мэс заслын тусламж үйлчилгээний хэлбэрүүдийг сонгоно уу?
1. Эмнэлгийн анхан шатны тусламж
2. Ерөнхий мэс заслын тусламж
3. Төрөлжсөн нарийн мэргэжлийн тусламж
4. Салбар хэсэг нэгжид үзүүлэх тусламж
5. Мэс заслын өвчтөнд үзүүлэх тусламж

/353./ Цус юүлэхийн өмнө шалгаж үзэх тохироонуудыг сонгоно уу?
1. Резус
2. Хувийн
3. Биологийн
4. Бүлгийн

5. Сийвэнгийн

/354./ Ясны хугарлыг хугарлын шугамаар нь ангилна уу?
1. Хэлтэрсэн
2. Ташуу
3. Мушгирсан
4. Хөндлөн
5. Дагуу

/355./ Эгэмний хугарлын үед ямар боолт хийх вэ?
1. Гарыг гурвалжин алчуураар сойж боох
2. Ситенкогийн цагираг хэрэглэж боох
3. Мөрний үеэнд түрүү хэлбэрийн боолт хийх
4. Наймын тоо хэлбэрийн боолт хийх
5. Цээжинд чагт хэлбэрийн боолт хийх

/356./ Шархны үндсэн шинж тэмдгүүдийг нэрлэнэ үү?
1. Өвдөх
2. Шарх ангайх
3. Цус гоожих
4. Улайх
5. Хавдах

/357./ Хугарлын үед илрэх үндсэн шинжүүдийг сонгоно уу?
1. Цус хурж , үжилгүй үрэвсэл болсноос хавдах
2. Хөдөлгөөн байх ёсгүй хэсэгт эмгэг сул хөдөлгөөн үүсэх
3. Тэмтрэхэд хугархайн үзүүрүүд хавиралдаж мэдэгдэх
4. Тэр хэсгийн мэдрэлийн ширхэгүүд цочирсноос өвдөх
5. Хугархайн үзүүрүүд зөрснөөс мөч богиносох

/358./ Хагалгааны дараа өвчтний ам цанган, уруул нь омголтоход ямар сувилгаа хийх вэ?
1. Норгосон хөвөнтэй савхаар буйл тагнайг цэвэрлэх
2. Ам хамрын нүхэн дээр чийгтэй марль тавих
3. Урууланд вазелин түрхэх
4. Хэл дээр нь чийглэсэн самбай тавих
5. Бүлээсгэсэн шингэн ихээр уулгах

/359./ Шулуун гэдсээр хэрэглэж унтуулдаг эмийн бодисуудыг сонгоно уу?
1. ГОМК
2. Фентанил
3. Закись азот
4. Хлоралгидрат
5. Тракриум

/360./ Хугарлын үед ямар үндсэн шинжүүд илрэх вэ?
1. Цус хурж , үжилгүй үрэвсэл болсноос хавдах
2. Хөдөлгөөн байх ёсгүй хэсэгт эмгэг сул хөдөлгөөн үүснэ
3. Тэмтрэхэд хугархайн үзүүрүүд хавиралдаж мэдэгдэнэ.
4. Тэр хэсгийн мэдрэлийн ширхэгүүд цочирсноос өвдөнө.
5. Хугархайн үзүүрүүд зөрснөөс мөч богиносно.

/361./ Хэвтрийн эмчлүүлэгчийг холголт цооролтоос сэргийлэх сувилгааг сонгоно уу?
1. Өдөрт 2-3 удаа байрлалыг өөрчлөн хэвтүүлэх
2. Дэвсгэр даавууг үрчлээсгүй, цэвэрхэн байлгах
3. Марлин, хийн, хөвөн цагираган жийргүүдийг тавих
4. Холгож болзошгүй хэсгүүдэд вазелин, камфор түрхэх
5. Удаан дарагдсан хэсэгт иллэг хийх

/362./ Төрөлхийн гажиг, зэмдэг хөгжил ямар байдлаар тохиолдож болох вэ?
1. Тархины ивэрхийтэй
2. Сэтэрхий уруултай
3. Салаалсан умайтай
4. Сиамын ихэр
5. Майга тавхайтай

/363./ Биеийн ямар хэсгүүдэд хаван үүсэх боломжтой вэ?

1. уц нуруу
2. Хөлийн шилбэ
3. Өгзөг
4. Зовхи
5. Хэвлийн урд хана

/364./ Мэс заслын багажинд тавигдах шаардлагуудыг тэмдэглэнэ үү?
1. Зэвэрдэггүй материалаар хийгдсэн байх
2. Хөнгөн, хялбар ариутгагддаг байх
3. Хэрэглэхэд тохиромжтой, хүртээмжтэй байх
4. Зориулалтын үүргээ бүрэн гүйцэтгэж чаддаг байх
5. Нийтлэг хэрэглэгддэг дүрэмтэй байх

/365./ Мэдээ алдуулалтын ангилалыг тэмдэглэнэ үү?
1. Дусааж мэдээ алдуулах
2. Хэсгийн мэдээ алдуулалт
3. Дамжуулах мэдээ алдуулалт
4. Ерөнхий мэдээ алдуулалт
5. Нэвчүүлж мэдээ алдуулах

/366./ Ивэрхийн хагалгааны дараа хийгдэх сувилгааг сонгоно уу?
1. Хагалгааны дараа өвдөлт намдаах лаа хэрэглэх
2. Цус алдахаас сэргийлж шарханд хүйтэн жин тавих
3. Ханиахдаа шархны боолтон дээр зөөлөн дарахыг зөвлөх
4. Хушга, гуяны ивэрхийн хагалгааны дараа хуухнагт сойлт хийх
5. Эмчлүүлэгчийн тахиман дор ивээс хийж хэвтүүлэх

/367./ Үйлчлүүлэгчид бодит үзлэг хийх аргуудыг сонгоно уу?.
1. Харж ажиглах
2. Тогшиж тэмтрэх
3. Хэмжих
4. Үнэрлэх
5. Барьж үзэх

/368./ Боолтын сувилагчийн гүйцэтгэх үүргийг сонгоно уу?
1. Ажлын хувцас, малгай, амны хаалттай ажиллана
2. Үжилгүйжүүлэх, үжил эсэргүүцэх дэгийг баримтална
3. Өглөө бүр багаж боолтын материалыг шинээр дэлгэнэ
4. Шинжилгээ, оношлогооны асуудлыг хариуцаж ажиллана
5. Хагалгааны цагаан хэрэглэлийг бэлтгэж ариутгана.

/369./ Хүний биед цус ямар үүрэг гүйцэтгэх вэ?
1. Хамгаалах
2. Тэжээх
3. Ялгаруулах
4. Цус тогтоох
5. Амьсгалуулах

/370./ Эмчлүүлэгчийг хагалгааны өрөө рүү хүргэхийн өмнө ямар үйлдэл хийх вэ?
1. Халуун үзэж тэмдэглэх
2. Хиймэл эрхтэн байвал авах
3. Цэвэрлэх клизм тавих
4. Шээлгэх буюу шээсийг нь авах
5. Хувцсыг нь бүрэн тайлах

/371./ Новокайны хоригийг ямар зорилгоор хийх вэ?
1. Тайвшруулах
2. Өвдөлт намдаах
3. Хэсгийн мэдээ алдуулах
4. Шокоос урьдчилан сэргийлэх
5. Халдвараас сэргийлэх

/372./ Эрүү нүүрний мэс засалч эмчид үзүүлэх эмгэгийг нэрлэнэ үү?
1. Тархины ивэрхий
2. Сэтэрхий уруул

3. Заадас эрт битүүрэх
4. Тагнай сэтэрхий
5. Усан тархитай байх

/373./ Ямар бодисыг хэсгийн мэдээгүйжүүлэгт хэрэглэж болох вэ?
1. Закись азот
2. Дикайн
3. Эфир
4. Лигнокайн
5. Прокайн

/374./ Эмчлүүлэгчийг хагалгаанд бэлтгэх үндсэн чиглэлийг сонгоно уу?
1. Сахиурыг нь бэлтгэх
2. Биеийг нь бэлтгэх
3. Хувцсыг нь бэлтгэх
4. Сэтгэл санааг нь бэлтгэх
5. Эм тариаг нь бэлтгэх

/375./ Ерөнхий мэдээ алдуулалтын ангилалыг сонгоно уу?
1. Нугасаар мэдээ алдуулах
2. Амьсгалын замаар мэдээ алдуулах
3. Судсаар мэдээ алдуулах
4. Амьсгалын бус замаар мэдээ алдуулах
5. Шүршиж хөлдөөж мэдээ алдуулах

/376./ Боолт тогтоож болох материалуудыг сонгоно уу?
1. Бинт
2. Алчуур
3. Гоюу
4. Арьсны цавуу
5. Даавуу

/377./ Хөхний цочмог үрэвсэл нь:
1. Хөхүүл эмэгтэйчүүдэд элбэг тохиолдоно
2. Анхны төрөгчдөд ихэнхдээ тохиолдоно
3. Төрсний дараах эхний сард элбэг тохиолдоно
4. Төрөөгүй эмэгтэйчүүдэд элбэг тохиолдоно.
5. Цэвэршилтийн үед элбэг тохиолдоно.

/378./ Мэс засал хийхийн өмнө гарыг ариутгаж хүрэлцэх халдвараас сэргийлэх учир мэс заслын сувилагчийн гар шархгүй, хумс нь өөгүй, будаггүй байх шаардлагатай.

/379./ Хэвлийн гялтангийн цочмог үрэвслийн гол шалтгаан нь мухар олгойн цочмог үрэвсэл учраас мухар олгойн цочмог үрэвслийн үед яаралтай хагалгаа хийхгүй бол бага аарцгийн хөндийн гялтангийн үрэвсэл үүснэ.

/380./ Флегмон нь булчин эдийн завсраар тарж урссан идээ учраас буглаанаас ялгагдан, байрлалаасаа хамаарч өөр өөр нэршилтэй байдаг.

/381./ Антибиотик нь химийн үжилгүйжүүлэх аргын нэг учраас шарханд байгаа нянгийн өсөлт үржилтэнд сөрөг нөлөө үзүүлэхгүй.

/382./ Исэлдүүлэгчийн бүлгийн бодисууд нь найрлагандаа хүчилтөрөгч агуулах учир агааргүй орчинд өсч үрждэг бичил биетнээр үүссэн халдварын үед өргөн хэрэглэнэ

/383./ Ивэрхий нь ердийн юмуу олдмол нүхээр хажуугийн хөндий рүү эсвэл арьсан дор шилжин гарах учраас гадна ивэрхий, дотор ивэрхий гэж ангилна.

/384./ Жирэмсэн эмэгтэйн мухар олгойн үрэвслийн үед томорсон умай гэдсийг дээш шахсанаас өвдөлтийн байрлал өөрчлөгдөх учраас эмэгтэйг хажуу талаар нь хэвтүүлэн үзлэг хийнэ.

/385./ Кариестэй шүд, гүйлсэн булчирхайн архаг үрэвсэл нь халдварын голомт учраас дотоод халдварын эх уурхай нь өвчтөн өөрөө болно.

/386./ Тунгалагийн булчирхайн үрэвсэл нь ихэвчлэн хоёрдогчоор үүсэх учраас зүүн хөлийн тавхайд хатгагдсан шархтай эмчлүүлэгчийн цавины булчирхай нь томорч, өвдөх шинж илрэх боломжтой.

/387./ Ходоод, дээрх гэдэсний шархлаа хүндрэн хэвлийн хөндий рүү цоорч болох учраас агуулагдхуун нь хэвлийн хөндий рүү орж гялтангийн үрэвсэл үүсгэх ба рентгенд харахад өрцөн дор хадуур хэлбэрийн хий харагдана.
/388./ Татрангийн үүсгэгч нь газрын хөрсөнд удаан хугацаагаар хадгалагдан шархаар бие махбодид нэвтрэн өвчин үүсгэх чадвартай учир хөлдөлт , түлэгдэлт, шарх үүссэн үед татрангийн эсрэг ийлдэс тарина.
/389./ Халдварт бус архаг өвчний завсрын эрсдэлт хүчин зүйлийг заана уу?
1. Зохисгүй хооллолт
2. Нас
3. Хөдөлгөөний хомстол
4. Таргалалт
5. Хүйс
/390./ Эмч ажилчид амны хаалтаа хэдэн цаг тутамд солих вэ?
A. 1 цаг
B. 6 цаг
C. 4 цаг
D. 2 цаг
E. 3 цаг
/391./ Эмэгтэйн нөхөн үржихүйн хамгийн тохиромжтой насыг заана уу?
A. 18-20 нас
B. 20-35 нас
C. 21-25 нас
D. 26-30 нас
E. 30-35 нас
/392./ Өртөмтгий бүлгийн жирэмсэн эмэгтэйг хэн хянах вэ?
A. Өрхийн их эмч
B. Эх барих эмэгтэйчүүдийн нарийн мэргэжлийн эмч
C. Сумын их эмч
D. Эх барих эмэгтэйчүүдийн нарийн мэргэжлийн эмч бусад нарийн мэргэжлийн эмчтэй хамтран

E. Сумын эх баригч
/393./ Хэвийн үед үтрээний орчин ямар байх вэ?
A. Хүчиллэг
B. Шүлтлэг
C. Саармаг
D. Сул хүчиллэг
E. Сул шүлтлэг
/394./ Цус алдахаас урьдчилан сэргийлэх зорилгоор ургийн толгой төрсөн үед голдуу юу хэрэглэх вэ?
A. Окситоцин
B. Мизопростол
C. Метилэргометри
D. Синтоцинон
E. Простагландин
/395./ Төрөх үеийн цус алдалтын эрүүл эмгэгийн заагийг тодорхойлно уу?
A. 80 мл
B. 100 мл
C. 150-300 мл
D. 400 мл
E. 500 мл
/396./ Гэртээ төрсөн эхийг аль тасагт хүлээн авах вэ?
A. Эхийн I тасагт
B. Аль ч тасагт хүлээн авч болно
C. Эхийн II тасагт
D. ЖЭЭТ-ийн тасагт

E. Хэвийн төрсөн бол эмнэлэгт хүлээн авах шаардлагагүй
/397./ Эрүүл нярай хүүхдийг төрснөөс хойш ямар хугацаанд амлуулах вэ?
A. Дөнгөж төрмөгц
B. Төрснөөс хойш 2 цагийн дараа
C. Төрснөөс хойш 4 цагийн дараа
D. Төрснөөс хойш 5 цагийн дараа
E. Төрснөөс хойш 6 цагийн дараа
/398./ Үтрээ ямар, ямар үүрэг гүйцэтгэдэг вэ?
1. Хамгаалах үүрэгтэй
2. Үр тогтолтонд оролцдог
3. Төрөх замын зөөлөн хэсэг болдог
4. Биений юмны цус дамжин гадагшилдаг
5. Умайн хүзүүний шүүрэл гадагшилна
/399./ Ураг орчмын шингэн ямар ач холбогдолтой вэ ?
1. Ураг чөлөөтэй өсөж хөгжих, хөдлөх нөхцлийг бүрдүүлнэ
2. Ургийг гадаад орчны таагүй нөлөөнөөс хамгаална
3. Ургийн бодисын солилцоонд оролцоно
4. Умайн хүзүү нээгдэхэд тусална
5. Хүй дарагдахаас хамгаална
/400./ Хэвийн биений юмны мөчлөгийн шинж чанаруудыг тодорхойлно уу?
1. Дунджаар 28 хоногийн мөчлөгтэй
2. 2-7 хоног үргэлжилдэг
3. Гарах цусны хэмжээ 50-150 мл
4. Хоѐр хэсэгтэй
5. Мөчлөг нь тогтмол байх
/401./ Төрлөгийн I үе эхэлсэн шинжүүд юу байх вэ?
1. Ургийн бүрхүүл хальсны хэлбэршилт
2. Умайн хүзүүний толийлт ба нээгдэлт
3. Жигд базлалт
4. Ургийн толгой бага аарцгийн гарах хэсэгт
5. Умайн хүзүү бүрэн нээгдсэн
/402./ Жирэмсэн үед зохисгүй хооллох нь ураг, нярайд ямар нөлөөтэй вэ?
1. Өсөлт саатах, амьгүй болох
2. Бага жинтэй төрөх
3. Халдварт өртөмхий
4. Ургийн шингэн багасна
5. Урагт удамшлын эмгэг тохиолдох нь
/403./ Эмэгтэйчүүдийн өвчинд дараах эмгэгүүдийн аль нь орох вэ?
1. Биений юм хаагдах
2. Умайн хүзүүний үрэвсэл
3. Бэлгийн уруулын цагаарал
4. Биений юм өвдөлттэй ирэх
5. Бэлэг эрхтний унжилт
/404./ Ихсийн анатоми бүтцийг нэрлэнэ үү
1. Олон тооны салаалсан цэлмэнгүүдээс бүрдэнэ
2. Дугариг улаан саарал өнгөтэй
3. Зузаан нь 2-3 см. голч нь 15-18 см
4. 18-20 долькоос тогтоно
5. Махархуу бүтэцтэй
/405./ Умайн үүргийг нэрлэнэ үү?
1. Ургийг тээж төрүүлнэ
2. Үр тогтсон өндгөн эсийг бэхлэх
3. Биений юмны үед умайн салст хуурч гадагшилна
4. Эм бэлгийн дааврыг ялгаруулна
5. Үр тогтолт явагдана
/406./ Биений юмны мөчлөгийн өндгөвчийн үе шатыг хэлнэ үү?

1. Фолликул өсөж хөгжих
2. Овуляци
3. Шар бие үүсч хөгжих
4. Хуурах
5. Нөхөн төлжих

/407./ Жирэмсний эргэлзээтэй шинжүүдийг нэрлэнэ үү?
1. Өглөөгүүр бөөлжих
2. Үнэрлэх мэдрэхүйн өөрчлөлт
3. Цочромхой, унтамхай болох
4. Хэвлийн цагаан шугам тодрох
5. Хоолны дуршил өөрчлөгдөх

/408./ Манас таталтын урьдалтай эмэгтэйчүүдэд цүс алдах риск бага байдаг тул ургийн толгой төрсөн үед окситоцин 10 единицийг венийн судсанд хийдэг.

/409./ Зүрх судасны өвчтэй жирэмсэн эхчүүдийг эх барих их эмч болон зүрх судасны эмчийн хяналтанд төрүүлэх бөгөөд төрөлтийн 1-р үед шингэн ихээр уулгавал шингэн дутагдал үүсэхээс сэргийлж чадна.

/410./ Жирэмсэн эмэгтэй бүрт өвчингүй төрүүлэх аргыг зөв сонгож хэрэглэдэг бөгөөд энэ нь төрөлт, төрсний дараах үеийн цус алдалтаас сэргийлэх чухал асуудлын нэг мөн.

/411./ Сэргийлэх тунгаар витамин Д-г яаж хэрэглэх вэ?
A. Сард 2 капсул 2нас хүртэл 6-9 сард завсарлана
B. Сард 3 тунгаар 2 нас хүртэл 6-9 сард завсарлана
C. Сард 4 капсул 3 нас хүртэл 6,7,8, сард завсарлана
D. Сард 1 капсул 2 нас хүртэл 6-9 сард завсарлана
E. Сард 2 капсул

/412./ Дутуу нярайн өрөөний дулаан хэдэн хэм байх вэ?
A. 15 – 18 хэм
B. 18 - 20 хэм
C. 20 -22 хэм
D. 22- 24 хэм
E. 25 хэм

/413./ Шүүдэст эмзэгшил үүсэхэд нөлөөлдөг хүчин зүйл
A. Хүүхдийг хөхөөр хооллосноос
B. Нэмэгдэл хоол эрт өгсөнөөс
C. Эх, харшил үүсгэх бүтээгдэхүүн хэрэглэснээс
D. Жимс, хүнсний ногоо хэрэглэснээс
E. Тэжээвэр болгосноос

/414./ Төрсний дараа хэдэн минутын дотор амлуулах вэ?
A. 24 цагийн дотор
B. 30 минутад
C. 6 цагийн дотор
D. 12 цагт
E. 15 цагийн дотор

/415./ Ужиг суулгалт гэж юу вэ?
A. Баасны тоо олшрох
B. 14 хоногоос удаан суулгах
C. Эмгэг хольцтой баах
D. Баас шингэрч, бөөлжих
E. Хоногт 3-аас дээш устай суулгах

/416./ Гүйцэд нярайн өрөөний дулаан хэдэн хэм байх вэ?
A. 15 – 18 хэм
B. 18 - 20 хэм
C. 20 -22 хэм
D. 22- 24 хэм
E. 25 хэм

/417./ Д аминдэм 1 капсулдаа хэдэн МЕ -г агуулдаг вэ?
A. 20.000МЕ

B. 30.000МЕ
C. 40.000МЕ
D. 50.000МЕ
E. 100.000МЕ

/418./ Усан суулгалт гэж юу вэ?
A. Баасны тоо олширох
B. Хоногт 3 ба түүнээс дээш устай суулгах
C. Эмгэг хольцтой гарах
D. Баас шингэрч, бөөлжих
E. Хоногт 3-аас дээш баах

/419./ Хүнд цус багадалтын шинжийг нэрлэнэ үү ?
A. Алга хувхай цагаан
B. Алга цайсан
C. 2 хөл хавантай
D. Насанд тохирсон жин бага
E. Арьс цонхийсон

/420./ Хүүхдийн их зулай хэдийд битүүрдэг вэ?
A. 8 сартайд
B. 9-10 сартайд
C. 11-12 сартайд
D. 9 сараас 1,5 настайд
E. 1 насанд

/421./ Дараах шинжүүдээс аль нь илэрвэл эмнэлэгт яаралтай хэвтүүлэх вэ?
A. 14 хоногоос дээш ханиалгах
B. Халуурах
C. Амьсгал олшрох
D. Цустай цэр гарах
E. Цээж хонхолзох

/422./ Рахитын өвөрмөц сэргийлэлт гэж юу вэ?
A. Нар агаарт гаргах
B. Д аминдэм уулгах
C. Усанд тогтмол оруулах
D. Хөхөөр хооллох
E. Иллэг хийх

/423./ Нярай үе хэд хоног үргэлжилдэг вэ?
A. Төрсний дараах эхний 1 сар
B. Төрсний дараах эхний 21 хоног
C. Төрсний дараах эхний 28 хоног
D. Төрсний дараах 3 сар
E. Төрсний дараах 2 сар

/424./ Шүүдэст эмзэгшилтэй хүүхдэд нэмэгдэл хоолыг юугаар эхлэх нь зохимжтой вэ?
A. Хүүхдийн будаа
B. Тараг
C. Бантан
D. Ногооны нухаш
E. Жимсний шүүс

/425./ Монгол хүүхдийн биеийн цул эхний 6 сард хэдэн гр-аар нэмэгдэх èстой вэ?
A. 400 гр
B. 500 гр
C. 600 гр
D. 700 гр
E. 800 гр

/426./ Нярайг төрөхөөс гармагц идэвхтэй эргэлтийг хэзээ хийх вэ?
A. 24 цагийн дотор
B. 12 цагийн дотор

C. 15 цагийн дотор
D. 24-72 цагийн дотор
E. 3 хоногийн дараа

/427./ Цус багадалттай, жин багатай хүүхдийг хэдэн сараас нь нэмэгдэл хоолонд оруулах нь зохимжтой вэ?
A. 3 сар
B. 4 сар
C. 6 сар
D. 7 сар

/428./ Дархлаат бодис ихээр агуулдаг сүү аль нь вэ?
A. Шилжвэрт сүү
B. Ангир уураг
C. Найрлага тогтмолжсон сүү
D. Үнээний сүү
E. Зохицуулалт хийсэн сүүн холимог

/429./ Нэмэгдэл хоолыг тэжээвэр хооллолтын хэлбэртэй хүүхдэд хэдэн сартайгаас эхэлж өгөх вэ?
A. 3-4 сараас
B. 4-6 сартайгаас
C. 7-8 сартайгаас
D. 6 сараас
E. 9 сараас

/430./ Витамин Д-г эмчилгээний тунгаар хэрхэн өгөх вэ?
A. 1 капсулаар долоо хоногт 2 удаа 14 хоног
B. 2 капсулаар долоо хоногт 3удаа 7хоног
C. 3 капсулаар долоо хоногт 4удаа 30 хоног
D. 1 капсулаар даваа пүрэв гаригт нийтдээ 7 удаа
E. Даваа пүрэв гаригт 2 удаа

/431./ Хүүхдэд сувилгааны оношийг юуг үндэслэж тавих вэ?
1. Биеийн байдал
2. Зовиур
3. Айдас
4. Шалтгаан
5. Төлөвлөгөөг

/432./ Эх хүүхдийг хөхүүлэхэд дэмжлэг үзүүлэхийг заана уу?
1. Эх 4 хуруугаа цээжний хананд наалдуулан хөхний доогуур байрлуулна
2. Долоовор хуруугаараа хөхөө өргөж дэмжлэг үзүүлнэ
3. Эрхий хуруугаа хөхний дээр байрлуулна
4. Эхийн хуруунууд хөхний толгойтой хэт ойрхон байрлаж болохгүй
5. Эх долоовор ба дунд хуруугаараа хайчилж барина

/433./ Хүүхдийн амьсгал олширсон босгыг тодорхойлно уу?
1. 2 сар хүртэлх хүүхдэд 1 минутанд 60 буюу түүнээс дээш
2. 2 сараас 12 сар хүртэл 1 минутанд 50 буюу түүнээс олон
3. 12 сараас 5 нас хүртэл 1 минутанд 40 буюу түүнээс олон
4. Нярайд 60 ба түүнээс олон
5. 2 – 12 сард 50-аас дээш

/434./ Рахитын эхлэл үед ямар шинж илрэх вэ?
1. Цочромтгой болох
2. Шээс үнэртэй гарах
3. Хөлрөх
4. Нуруу муруйх
5. Сампингийн эрхийн шинж

/435./ Чихний цочмог халдварын үед ямар шинж илрэх вэ?
1. Чихний ард хавдсан, хөндүүр
2. Чих өвдсөн
3. Чихнээс булаг харагдах ба 14 хоногоос удаан гоожсон

4. Чихнээс булаг гараад 14 хоноогүй
5. Халуурсан

/436./ Хүүхдийн хөхүүлэх нь эхэд ямар тустай вэ?
1. Жирэмслэлтээс сэргийлэх
2. Эхийн ажлыг хөнгөвчлөх
3. Хөхний өмөн үү өвчнөөс сэргийлэх
4. Умайн өмөн үү өвчнөөс сэргийлнэ
5. Сав агшиж, төрсний дараах цус алдалтаас сэргийлэх

/437./ Усан суулгалтын уршиг юу вэ?
1. Баасаар их хэмжээний эрдэс бодисууд алдагддаг
2. Баасаар их хэмжээний ус алдагддаг
3. Баасаар шимт бодис алдагдана
4. Баасаар зөвхөн ус л алдагдана
5. Баасаар зөвхөн давс алдагдана

/438./ Цагаан хорхойтох өвчнийг үнэлнэ үү?
1. Хүүхдийн хошного загатнадаг уу?
2. Нойронд муу юу? Хорхой гарч байсан уу? гэж асууна
3. Хошногоны амсар, хярзан орчим улайсан буюу маажсан эсэхийг ажиглана
4. Цагаан хорхойтсон
5. Цагаан хорхойтой байж болзошгүй, цагаан хорхойгүй

/439./ Хөхний сүүний гарцыг нэмэгдүүлэх хүчин зүйлсийг дурдана уу?
1. =Эхийн хоолны чанар сайн байх
2. Хөхүүл эх сайн унтаж амрах
3. Ойр ойрхон хөхүүлэх
4. Хөхөө олон дахин угаах
5. Эх хүссэн үедээ хүүхдээ хөхүүлж байх

/440./ Хүчилтөрөгч өгөх үед анхаарах зүйл юу вэ?
1. Хүчилтөрөгч өгөхийн өмнө амьсгалын замыг чөлөөлөх
2. Хүчилтөрөгч авч байгаа хүүхдийг пульсоксиметрээр байнга хянах
3. Хүчилтөрөгчийн дамжуулах гуурсыг 72 цаг болоод солих
4. Хүчилтөрөгчийн урсгал болон гуурсыг 15 минут тутамд шалгах
5. Пульсоксиметрээр3 цаг тутам хөл, гарт ээлжлэн солих

/441./ Нярайг төрмөгц дулаан алдалтаас яаж сэргийлэх вэ?
1. Хуурайшуулах
2. Имж арга
3. Дулаан өрөөнд байлгах
4. Хөхөөр хооллох
5. Дулаацуулах төхөөрөмж ашиглах

/442./ Хэрэв хүүхэд зөвхөн хөхөөрөө хооллодог бол суулгалтын үед алийг нь зөвлөх вэ?
1. Тараг, хоормог
2. ШСД-ны уусмал
3. Цагаан будааны шүүс
4. Буцалсан ус
5. Шөл

/443./ Хүүхдэд эм өгөхөд анхаарах зүйл юу вэ?
1. Нэг дор 2-3 өөр төрлийн эм өгөхгүй байх
2. Сайтар нухаж бэлтгээгүй бүхэл, ширхэгтэй эм өгөхгүй байх
3. Хооллохоос өмнө эсвэл дараа уулгах заалтыг анхаарах
4. Эм өгсний дараа хүүхдэд хариу урвал илрэх эсэхийг ажиглах
5. Хүүхэд хахаж цацах, бөөлжих зэргийг анхаарч ажиглан эхэд зөвлөх, хэлэх

/444./ Хүүхдэд цэвэрлэх бургуй тавих үед ямар хүндрэл гарч болох вэ?
1. Бургуй тавих усны халуун бүлээнийг тохируулагүйгээс цочрол үүсэх
2. Баллоны хошууг сайн тослоогүйгээс салстыг гэмтээх
3. Тавих усны хэмжээг тохируулаагүйгээс хүндрэл гарах
4. Хүүхдийн гэдсэнд хий оруулах
5. Хүүхэд халуурах

/445./ Гүйцэт нярайн гадаад шинжийг тодорхойлно уу?
1. Дуу чанга
2. Арьсан доорхи өөхөн эдийн хөгжил сайн
3. Хумс нь хурууныхаа үзүүрт хүрсэн
4. Рефлексүүд сул
5. Эрэгтэй хүүхдийн төмсөг хуйхнагтаа буугаагүй

/446./ Хүүхдэд чийрэгжүүлэлт хийхэд баримтлах зарчим
1. Тухайн хүүхдийн хувийн онцлогт тохируулан хийх
2. Дасгалыг эрүүл байгаа үед нь эхлэх
3. Чийрэгжүүлэх дасгалыг багаас их рүү
4. Хөнгөнөөс нарийн руу аажим шилжүүлэх
5. Тогтмол хийх

/447./ Нярай үед шүүдэст эмзэгшлийн илрэл ямар шинжээр илрэх вэ?
1. Нүүрээр тууралт гарах
2. Арьс амархан нурах
3. Их хөлрөх
4. Толгойд зузаан хаг тогтох
5. Зулайны ирмэг зөөлрөх

/448./ Хүйний идээт үрэвслийн шинж юу вэ?
1. Цусан,идээрхэг тав үүсэх
2. Хүйг тойрсон арьс улайх
3. Ялимгүй халуурах
4. Хүй орчимд овойх
5. Хүйнээс идээрхэг шүүс гарах

/449./ Сүүн шүд хэдэн сараас эхлэн ургах вэ?
1. 5 сараас
2. 7-8 сард
3. 4 сараас
4. 6-7 сараас
5. 9 сараас

/450./ Ангир уураг ямар онцлогтой вэ?
1. Маш өтгөн
2. Уураг ихтэй
3. Бага хэмжээтэй
4. Шаргал өнгөтэй
5. Их хэмжээтэй

/451./ Төмрийн бэлдмэлийг ямар уусмалтай хамт өгвөл шингэц нь сайжрах вэ?
1. Буцалсан ус
2. Жимсний шүүс
3. Шүлтлэг уусмалууд
4. Аскорбины хүчлийн уусмал
5. Цай,кофе

/452./ Дутуу нярайн гадаад шинжийг тодорхойлно уу?
1. Мөчүүд харьцангуй урт
2. Дух нүүрний хэсгээс том
3. Хүйс дор байрлалтай, умдагт ойрхон
4. Чихний мөгөөрс зөөлөн, хэлбэржээгүй, толгойд наалдсан
5. Арьс нь үрчгэр улаан

/453./ Хөхүүл үе ямар онцлогтой вэ?
1. Бие махбодийн хөгжил өсөлт эрчимтэй явагдана
2. Сүүн шүд ургаж эхэлнэ
3. Хөдөлгөөний идэвх эрчимжинэ
4. Болзолт рефлексүүд үүснэ
5. Ясжилт эрчимтэй байна

/454./ Нярайн сувилгаанд юу анхаарах вэ?
1. Өрөөг цэвэр байлгах

2. Гараа сайн угаах
3. Өрөөнд олон хүн орохыг хориглох
4. Гэрэлтүүлэг, агааржилт сайтай байх
5. Өрөө дулаан байх

/455./ Тураалтай хүүхдэд ямар сувилгаа хийх вэ?
1. Өдрийн дэглэм зөв баримтлах
2. Зөв зохистой хооллох
3. Шалтгааныг илрүүлж арилгах
4. Аминдэм уулгах
5. Иллэг хийх

/456./ Хүүхэд хөхөө зөв үмхүүлэх шинжийг сонгоно уу?
1. Эрүү хөхөнд хүрэх
2. Хүүхэд амаа том ангайсан байна
3. Доод уруул гадагшаа цорвойх
4. Хөхний нөсөөт хэсэг уруулын дээд талд харагдах
5. Хөхний нөсөө хүүхэд хөхөж байхад бүх хэсгээр харагдах

/457./ Хоолонд тулгуурласан шингэнийг нэрлэнэ үү?
1. Шөл
2. Хоормог
3. Цагаан будааны шүүс
4. ШСД
5. Буцалсан ус

/458./ Шингэн алдалтыг хэрхэн үнэлдэг вэ?
1. Хэр удаан, баасанд нь цус байна уу? гэж асуух
2. Хүүхдийн ерөнхий байдлыг ажиглах
3. Нүд хонхойсон эсэхийг ажиглана
4. Хүүхдэд шингэн өгөх
5. Хэвлийн арьсыг чимхээд тавихад арьсны хуниас арилах

/459./ Хүүхдэд хүчилтөрөгч өгөх заалтыг тодорхойлно уу?
1. Төвийн хөхрөлт
2. Цээж хүчтэй хонхолзох
3. Амьсгалын тоо 60-аас олон болох
4. Тайван бус цочромтгой болох
5. Ханиалгах

/460./ Олон найрлагат бичил тэжээлийн бэлдмэл нь бага насны хүүхдэд өгснөөр ямар ач холбогдолтой вэ?
1. Бичил тэжээлийн дутал, түүн дотроос цус багадалт, цайрын дутлаас сэргийлнэ
2. Хүүхдийн нэмэгдэл хоолны чанрыг сайжруулан хоолны дуршлыг нэмэгдүүлнэ
3. Биеийн эсэргүүцлийг сайжруулах
4. Хүүхдийн өсөлт хөгжилтийг сайжруулах
5. Хүүхдийн оюун ухааны хөгжлийг сайжруулах

/461./ Рахитын өвөрмөц бус сэргийлэлт
1. Хүүхдийг хөхөөр хооллох
2. Нар агаарт гаргаж байх
3. Усанд тогтмол оруулах
4. Аминдэм Д уулгах
5. Аминдэм А уулгах

/462./ Хөхөөр хооллож буй хүүхдийн өтгөн ямар байдаг вэ?
1. Алтлаг шар өнгөтэй
2. Исгэлэн үнэртэй
3. Нялцгайвтар
4. Тогтворгүй
5. Эвгүй үнэртэй

/463./ Нэмэгдэл хоол өгөх зарчим юу вэ?
1. Нойрмог биш, сэргэлэн байх үед нь өгөх
2. Хөхүүлэхээс өмнө өгөх

3. Бага багаар дасгаж өгөх
4. Хөхүүлсний дараа өгнө
5. Хоолыг зэрэг эхэлж өгнө

/464./ Хүүхдийн бие бялдрын өсөлтийг үнэлэх үзүүлэлтүүд аль нь вэ?
1. Биеийн жин
2. Биеийн өндөр
3. Толгойн тойрог
4. Цээжний тойрог
5. Чулецкийн индекс

/465./ А аминдэмийг хүүхдэд яаж уулгах вэ?
1. Хүнд тураалын эмчилгээнд 2 тун уулгана
2. Улаанбурхантсан хүүхдэд 2 тун уулгана
3. А аминдэмийн дутлаас сэргийлж нас харгалзахгүйгээр 6 сар дутамд уулгана
4. А аминдэмийн дутлаас сэргийлж 6 сартайгаас эхлэж 5 нас хүртэл уулгана
5. 2 нас хүртэл өгнө

/466./ ШСД-ны уусмалыг хэрхэн бэлтгэх вэ?
1. Гараа угаах
2. Цэвэр саванд 1 уут нунтгийг бүгдийг хийх
3. Нэг литр ус хэмжиж авах
4. ШСД-тай сав руу усаа юүлж нунтгаа бүрэн уустал сайн хутгах
5. Уусмалаа амталж үз

/467./ Хүүхдийг чийрэгжүүлэх байгалийн 3 эрдэнэ гэж юу вэ?
1. Нар
2. Ус
3. Агаар
4. Иллэг
5. Хөдөлгөөн

/468./ А аминдэмийг ямар зорилгоор хэрэглэдэг вэ?
1. Улаан бурханы эмчилгээнд
2. Хүнд тураалын эмчилгээнд
3. А аминдэмийн дутлаас сэргийлэх зорилгоор
4. Рахитын эмчилгээнд
5. Цус багадалтын сэргийлэлтэнд

/469./ Хүүхдийн бие бялдрын өсөлтийг зөв үнэлэхийн ач холбогдол юу вэ?
1. Хүүхдийн бие бялдрын өсөлт хөгжил насандаа тохирч байгаа эсэх
2. Хүүхдийн хоолны үндсэн шимт бодисын хоногийн хэрэгцээг тооцох
3. Хүүхдэд хэрэглэх эмийн тун, дуслын шингэний хэмжээг тооцох
4. Хүүхдийн насыг баримжаалан тогтоох
5. Цус багадалттай эсэх

/470./ Нярайн эрүүл эмгэгийн зааг байдал аль нь вэ?
1. Жин бууралт
2. Нярайн шарлалт
3. Халууралт
4. Дулааны тэнцвэрийн өөрчлөлт
5. Хүйнээс цус гарах

/471./ Цагаан хорхойтсон бол эмчилгээг тогтоож зөвлөгөө өгнө үү?
1. Мебендазол өгнө
2. Мультивитамин өгнө
3. Эрүүл ахуйн зөвлөгөөг өгнө
4. 30 хоноод давтан үзүүлнэ
5. 14 хоноод давтан үзүүлнэ

/472./ Суулгалтын үед гэрээр зөвлөдөг шингэнүүдийг нэрлэнэ үү?
1. Буцалсан ус
2. ШСД-ны уусмал
3. Давс сахарын уусмал
4. Давстай ус

5. Чихэртэй ус

/473./ Рахит өвчний үед Д аминднэм дутагдсанаас Са, Р – ийн солилцоо гүнзгий доголддог учраас хүүхдэд яс булчин, мэдрэлийн тогтолцооны эмгэг шинж илэрдэг.

/474./ Сэтгэцийн хувьд эрүүл хүмүүс нь сэтгэцийн эрүүл мэндийн сэргийллийн ямар түвшинд хамаарах вэ?

A. СЭМ-н дөрөвдөгч сэргийлэлт
B. СЭМ-н гуравдагч сэргийлэлт
C. СЭМ-н хоёрдогч сэргийлэлт
D. СЭМ-н анхдагч сэргийлэлт
E. СЭМ-н урьдчилан сэргийлэлт

/475./ Сэтгэцийн өвчтэй хүн гэж хэнийг хэлэх вэ?

A. Нийгэм сэтгэлзүйн гаралтай, түр зуурын хямралд өртсөн хүнийг
B. Оюуны хомсдол өвчтэй хүнийг
C. Биемахбодийн өвчингүй боловч сэтгэцийн өөрчлөлт бүхий хувь хүнийг
D. Өвчний олон улсын ангиллын хэмжүүрээр онош тавьж болохуйц өвчтэй хүнийг
E. Сэтгэцийн өөрчлөлт бүхий хувь хүнийг

/476./ Сэтгэцийн тулгамдсан асуудал гэж юу вэ?

A. Сэтгэцийн сэтгэл хөдлөл, сэтгэхүй түр хямрах
B. Нийгэм сэтгэл зүйн шалтгааны улмаас сэтгэл хөдлөл, зан үйл түр хямрах
C. Нийгэм сэтгэл зүйн шалтгааны улмаас сэтгэл хөдлөл, сэтгэхүй, зан үйл түр хямрах
D. Нийгэм сэтгэл зүйн шалтгааны улмаас сэтгэл хөдлөл, сэтгэхүй түр хямрах
E. Нийгэм сэтгэл зүйн шалтгааны улмаас сэтгэл хөдлөл түр хямрах

/477./ Өвчтөнд хамгийн тод тусгагддаг эмч, эмнэлгийн ажилчдын сөрөг чанарыг нэрлэнэ үү?

A. Ажлын эмх цэгц муу
B. Дадлага туршлага бага байх
C. Мэргэжил мэдлэг хангалтгүй байх
D. Харьцааны ур чадварын хомсдол
E. Мэргэжлийн ур чадварын хомсдол

/478./ Нийгэмд аюултай үйлдэл хийж болзошгүй өвчтөн гэж хэнийг хэлэх вэ?

A. Нийгэм, хамт олонтой дасан зохицох чадвар муутай
B. Хурц солиоролтой өвчтөн
C. Нойргүйдэлтэй өвчтөн
D. Айдастай өвчтөн
E. Сэтгэл түгшилтэй өвчтөн

/479./ Сэтгэцийн өвчтөнд үзүүлэх сувилахуйн тусламж ямар үйл ажиллагаанд чиглэгдсэн байдаг вэ?

A. Өвчтөнд тариа хийхэд
B. Өвчтөнг асрах
C. Бусдад болон нийгэмд аюултай үйлдэл хийхээс урьдчилан сэргийлсэн
D. Өвчтөн хооллоход чиглэгдсэн
E. Өвчтөнг сувилах

/480./ Оюуны хомсдолтой хүмүүст аль хандлага нь заавал хэрэгтэй вэ?

A. Оюун ухааныг сайжруулах эмийн эмчилгээ
B. Ад шоо үзэхгүй байх
C. Тусгай сургуульд суралцуулах
D. Амьдрах ур чадвар эзэмшүүлэх
E. Гэр бүлийнхний асрамжинд байлгах

/481./ Сэтгэцийн өвчтөнд шөнийн цагт хяналт явуулахад баримтлах зарчим

1. Өвчтөнийг толгой дээгүүр нь хөнжил нөмрүүлэхгүй байх
2. Палатны үүдийг онгорхой байлгах
3. Өвчтөнүүдийг байнга хянаж, унтаж буй эсэхийг шалгах
4. Ерөнхий гэрэлтүүлэгтэй байх
5. Палатны гэрлийг асаалттай байлгах

/482./ Дараах сэтгэцийн өвчнүүдээс сэтгэцийн яаралтай тусламж шаарддаг байдлыг нэрлэнэ үү?

1. Хурц солиорол

2. Гүнзгий сэтгэл гутрал
3. Догшрол
4. Архинд донтох
5. Айдастай өвчтөн

/483./ Сэтгэцийн өвчтөнд эм олгоход заавал баримтлах зарчмуудыг нэрлэнэ үү?

1. Эмийг нухаж бэлтгэнэ
2. Эмийг сувилагч заавал өөрийн гараар өвчтөний аманд хийнэ
3. Эмийг 37 С бүлээн усаар даруулж уулгана
4. Эм уусаны дараа өвчтөний амыг заавал шалгана
5. Эм ууснаас хойш 30 минут өвчтөнг хянах

/484./ Амиа хорлох хандлагатай өвчтөнд хийх сувилахуйг нэрлэнэ үү?

1. Өвчтөний бие болоод сэтгэцийн байдлыг сайн мэдэж байх
2. Өвчтөнг ганцааранг орхиж хэрхэвч болохгүй
3. Орондоо хэвтэж байгаа тохиолдолд толгойг нь үргэлж ил байлгах
4. Тарианы өрөөг эзэнгүй онгорхой орхихгүй байх, эмийг цоожтой саванд хадгалах
5. Өвчтөнг оронд нь даруулгатай байлгах

/485./ Уналт таталт бүхий өвчтөний асаргаа сувилгаанд юуг анхаарах шаардлагатай вэ?

1. Уналтын үед амьсгалын замыг чөлөөлөх
2. Өвчтөнд гарч буй сэтгэцийн өөрчлөлтийг нарийн ажиглах
3. Өвчтөнийг аюултай байдлаас холдуулах
4. Уналт таталтыг зогсоохын тулд механик арга хэрэглэх
5. Уналтын үед уналт таталтын эсрэг эмийг яаралтай өгөх

/486./ Сэтгэцийн өвчтөний эмнэлэг хамгааллын хамгаалах дэглэмд байгаа өвчтөнүүд ямар үйл ажиллагаанд хамрагдах вэ?

1. Тасгийн дотор чөлөөтэй байх, тасгийн доторхи нөхөн сэргээх эмчилгээнд оролцох
2. Хэвтрийн дэглэм сахих
3. Гэртээ чөлөөгөөр гарах, эмнэлгийн нөхөн сэргээх эмчилгээнд оролцох
4. Зөвхөн палатан дотор чөлөөтэй байх
5. Эмнэлгийн доторхи нөхөн сэргээх эмчилгээнд оролцох

/487./ Сэтгэцийн эмгэгтэй хүмүүс ямар нөхцөлд нийгэмд аюултай үйлдэл хийх магадлал өндөр байдаг вэ?

1. Өвчин дахих хөдлөх үед
2. Өвчин хурцдах буюу сэдрэх үед
3. Сэтгэцийн нэг болон хэд хэдэн шинж нөгөөгөөр солигдох үед
4. Өвчний хурц үе намжих үед
5. Харьцангуй сайжрал авсан үед

/488./ Сэтгэцийн өвчтэй гэдэг нь бүрэн батлагдсан өвчтөнд ямар арга хэмжээ авах вэ?

1. Нийгэм хамт олны дунд эмчлэхийг эрмэлзэнэ
2. Сэтгэцийн эмчийн хяналтанд байлгана
3. Шаардлагатай үед сэтгэцийн эмнэлэгт хэвтүүлнэ
4. Нийгмээс тусгаарлана
5. Байнгын эмнэлэгт байлгах

/489./ Догширсон өвчтөнийг машинд суулгах ба нэг тасгаас нөгөө тасагт шилжүүлэн зөөвөрлөхөд ямар ямар арга барилыг хэрэглэж болох вэ?

1. Өвчтөнийг хоёр сувилагч 2 талаас нь сугадаж бие рүүгээ шахаж авч явах
2. Өвчтөнөө дамнуурга дээр хэвтүүлж орны даавуугаар цээж, өвдөгний тус газраар боолт хийж эсвэл хөнжилд нь өлгийдөж дамнуургаар авч явна
3. 3 хүний оролцоотой өвчтөнийг авч явах
4. Дамнуурга дээр хэвтүүлж зөөвөрлөх
5. Өөрөөр нь явуулж зөөвөрлөх

/490./ Ухаангүй өвчтөнг сувилахуйн ямар хэмжүүрээр оношлох вэ?

A. Асуумжийн аргаар
B. Ажиглалтын аргаар
C. Глазгогийн үнэлгээ хийх
D. КТГ

E. Лабораторын шинжилгээ хийх
/491./ Уналт таталтай өвчтөнд үл илрэх ерөнхий шинжүүдийг тоочино уу?
A. Чангарсан таталт илэрнэ
B. Чичирхийлсэн таталт илэрнэ
C. Ухаан алдана
D. Ёр дохио илрэх
E. Хүүхэн хараа өргөссөн байна
/492./ Цус харвалтын сэргэлтийн үед ямар сувилгаа шаардлагатай вэ?
A. Саатай гар хөлд эхлээд хөдөлгөх
B. Сэргэлтийн үеэс тэргэнцэр таягийг ашиглах
C. Идэвхтэй хөдөлгөөн дасгал хийлгэх
D. Хагас суугаа байдалд суулгах
E. Бусдын тусламжтайгаар явуулж сургах
/493./ Уналт таталтын хам шинжийн яаралтай тусламжийг дурьдана уу?
A. Бүсэлхийн хатгалт
B. Агаар оруулах
C. Хиймэл амьсгал хийх
D. Амьсгалын замыг чөлөөлөх
E. Ерөнхий унтуулга
/494./ Гавлын дотоод даралт ихдэлттэй өвчтөнийг сувилахад хориглох заалтыг тоочно уу?
A. Толгойг хагас өндөрлөх
B. Өвчтөний байрлалыг хурдан өөрчлөх
C. Чийглэсэн хүчилтөрөгчөөр амьсгалуулах
D. Хүзүүг аажим эргүүлэх, бөхийлгөх
E. Хүзүүг аажим эргүүлэх
/495./ Цус харвалттай өвчтөнд ямар сувилгаа шаардлагатай вэ?
1. Өвчний эхэн үед хаймсууpаар шингэн хоол өгөх
2. Давс, өөх тосыг хязгаарлах
3. Хоолыг хэт халуун өгөхгүй байх
4. Хоолыг бага багаар бэлтгэх
5. Эслэг ихтэй хоол хүнс хэрэглэх
/496./ Цус харвах инсульт ямар шалтгаанаар үүсэх вэ?
1. Артерын даралт ихдэх өвчин
2. Бөөрний шалтгаантай даралт ихдэлт
3. Тархины судасны төрөлхийн гажиг
4. Халдвар харшлын гаралтай судасны үрэвсэл
5. Цусны зарим өвчнүүдийн үед
/497./ Бүсэлхий ууцны радикулитын үед хийх асаргаа сувилгааны дэглэм аль нь вэ?
1. Хатуу орон дээр хэвтрийн дэглэм сахих
2. Хэсэг газрын дулаан эмчилгээ-грылка, банк, горчичник
3. Шавар, лаа эмчилгээ
4. Зүү эмчилгээ
5. Татлага эмчилгээ
/498./ Уналт таталт өвчин үүсэх хүчин зүйлсийг нэрлэнэ үү?
1. Хүүхдийн халуурaлтын сууринд үүсэх таталт
2. Тархины органик эмгэг
3. Тархины үйл ажиллагааны байдал
4. Удамын хүчин зүйл
5. Гематомын суурин дээр
/499./ Цээжээр өвдөх өвдөлтийн байрлалын шинжийг нэрлэнэ үү?
1. Өвдөлт дал хооронд байрлах
2. Хавирга хооронд дарахад эмзэглэлтэй
3. Хавирга руу дамжиж өвдөх
4. Ханиах найтаахад сэдэрнэ
5. Ханиах найтаахад эмзэглэлтэй
/500./ Саа саажилтай өвчтөнийг сувилагч хэрхэн оношлох вэ?

1. Өвчтөнөөр дөрвөн мөчийг өөрөөр нь хөдөлгөх
2. Саа саажилт байгаа эсэхийг ажиглах
3. Булчингийн хүчдэлийг сувилагч өөрөө хөдөлгөж шалгах
4. Өвчтөний дөрвөн мөчийг сувилагч өөрөө хөдөлгөж шалгах
5. Булчингийн хүчдэлийг өөрөөр нь хөдөлгөж шалгах

/501./ Нугасны эмгэгтэй өвчтөний байрлал ба хөдөлгөөний сувилгааг нэрлэнэ үү?
1. Хэвтээ болон суугаа байрлалд ойрхон солих
2. Цооролтоос сэргийлэх
3. Ивээс зөөлөвчийг байнга хэрэглэх
4. Үе мөчинд иллэг идэвхтэй хөдөлгөөн хийх
5. Гутал нь үдээгүй өмсөхөд хялбар байх

/502./ Цус харвалт, цус хомсрох үед ямар дэглэмүүдийг баримтлах вэ?
1. Өвчтөнийг зөв тээвэрлэх
2. Хэвтрийн дэглэм 28 хоног сахиулах
3. Ухаангүй үед цэр, салстыг соруулах, цооролт, нуралтаас сэргийлэх
4. Эмчилгээг эрчимтэй зөв, цаг алдалгүй хэрэглэх
5. Нөхөн сэргээх эмчилгээ

/503./ Бүсэлхийгээр өвдөх өвдөлт ямар тохиолдолд сэдэрдэг вэ?
1. Хүнд юм өргөх
2. Эвгүй огцом хөдлөх
3. Даарч хөрөх
4. Эвтэй байдалд удаан суухад
5. Хэт удаан суух

/504./ Паркинсонизм архаг даамжрах явцтай эмгэг учраас тархины гадрын удаах хэсэг дэх хар бодисын нөсөөт эсүүдийн сөнөрөлтэй холбоотой.

/505./ Өргөн утгаараа эрүүл мэндийн анхан шатны тусламжийг хэнд үзүүлэх вэ?
A. Малчдад
B. Эх нялхаст
C. Бүх хүн амд
D. Хүн амын эмзэг хэсэгт
E. Өндөр настанд

/506./ Эрүүл ахуй, ариун цэврийн хяналт шалгалтын ажлыг ямар зорилгод хамгийн түрүүнд чиглүүлэх ёстой вэ?
A. Зөрчлийг газар дээр нь засуулахад
B. Зөрчил гаргагсдын торгож шийтгэхэд
C. Аливаа зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд
D. Аливаа зөрчлийг илрүүлэхэд
E. Ажил сайжруулахад

/507./ Нийгмийн эрүүл мэндийн үйл ажиллагаанд хамгийн чухал үзүүлэлт юу вэ?
A. 10000 хүн тутамд ноогдох эмнэлгийн ажилтны тоо олон байх
B. Нэг хүнд ноогдох цэвэр ус, хүнсний бүтээгдэхүүн хүртээмжтэй байх
C. Эдийн засгийн чадавхтай байдал
D. Өрхийн ам бүл цөөн байх
E. Эмнэлгийн орны тоо олон байх

/508./ Эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг чиглүүлэх оновчтой байдлыг нэрлэнэ үү?
A. Хувь хүнд
B. Бие хүнд
C. Хамт олонд
D. Улс нийгэмд
E. Гэр бүлд

/509./ “Амьдралын чанар” хэмээх ойлголтонд ямар ухагдахуун хамрах вэ?
A. Урт наслалт
B. Хангалуун байдал
C. Эрүүл энх байдал
D. Албан тушаалын байдал
E. Эдийн засгийн чадавхит байдал

/510./ Хүн бүр эрүүл ахуйн шаардлагаар хоногт хичнээн литр ус хэрэглэвэл зохих вэ?
A. 5-15 литр
B. 20-40 литр
C. 45-65 литр
D. 70-90 литр
E. 100 литр
/511./ НЭМ-ийн талаар төрөөс баримтлах бодлого нь хэдэн оны ямар тушаалаар батлагдсан вэ?
A. Засгийн газрын 2000 оны 81-р тогтоол
B. Засгийн газрын 2001 оны 81-р тогтоол
C. УИХ-ын 2001 оны 81-р тогтоол
D. УИХ-ын 2002 оны 81-р тогтоол
E. ЭМ-н сайдын 2004 оны 81-р тушаал
/512./ Халдварт өвчлөлөөс сэргийлэх идэвхит арга хэмжээг нэрлэнэ үү?
A. Чийрэгжүүлэлт
B. Дархлаажуулалт
C. Ахуйн соёлжилт, эрүүл орчин
D. Эрүүл мэндийн боловсрол
E. Эрүүл мэндийг дэмжих зан үйл
/513./ Эрүүл мэндийн анхан шатны тусламжийн зорилго нь юу вэ?
A. Амьдралын чанарыг дээшлүүлэх
B. Өвчлөлөөс хоёрдогч, гуравдагч сэргийлэлт
C. Эмнэлгийн ерөнхий ба нарийн мэргэжлийн тусламж
D. Хөдөлмөрийн чадварыг нь сэргээх
E. Эмчлэн эрүүлжүүлэх
/514./ “Эрүүл энх” байдлын талаарх зах зээлийн сэтгэлгээ хүмүүсийн юунд эхэлж бүрэлдэх нь оновчтой вэ?
A. Ахуй орчинд
B. Оюун ухаанд
C. Нийгмийн амьдралд
D. Эдийн засагт
E. Ажлын байранд
/515./ Цаг агаарын байдлыг шинжиж хүн амд мэдээлэх нь ямар ач тустай вэ?
1. Эрүүл мэндээ хамгаалах
2. Гарч болзошгүй сөрөг зүйлсээс сэргийлэх
3. Ажил албаа зохицуулах
4. Хувцаслалтандаа анхаарах
5. Өвчлөхөөс сэргийлэх
/516./ “ Эрүүл” гэдэг нь ямар ойлголт вэ?
1. Биед ямар нэг өөрчлөлтгүй байхыг хэлнэ
2. Эрхтэн системүүд нь бүрэн бүтэн байгааг хэлнэ
3. Бие бялдар оюун санааны өв тэгш хүмүүжлийг хэлнэ
4. Эрхтний үйл ажиллагаа гадаад орчинтойгоо бүрэн зохицсон байдлыг хэлнэ
5. Нийгэм ахуйн өв тэгш, эсэн мэнд байдлыг хэлнэ
/517./ Хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох нь ямар ач холбогдолтой вэ?
1. Эрүүл мэндийн мэдлэг олгох
2. Амьдралын зөв хэвшил дадалтай болгох
3. Үзэл баримтлал, эрүүл мэнддээ хандах хандлагыг өөрчлөх
4. Эмнэлгийн тусламжийг зөв авах чадвартай болгох
5. Эмгэг байдалд өртөхгүй байх
/518./ Эрүүл мэндийн анхан шатны тусламжуудыг нэрлэнэ үү?
1. Гэр бүл төлөвлөлтийн арга хэмжээ
2. Ундны цэвэр усны хангамж
3. Нутагшмал өвчлөлөөс сэргийлэх
4. Зохистой хоол хүнсээр хангах

5. Хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох

/519./ Ундны усны зөв хэрэглээг бий болгоход анхаарах зүйлс нь юу вэ?

1. Уух усыг буцалгаж хэрэглэж занших
2. Усны эх булгийг зөв сонгох
3. Усны савны багтаамж, цэвэрлэгээг анхаарах
4. Усны хэрэглээний эрүүл ахуйн нормыг хангах
5. Ундны устай харьцах зөв зан үйлийг хэвшүүлэх

/520./ Жорлон, бохир усны нүхэнд эрүүл ахуйн ямар шаардлага тавигддаг вэ?

1. Ус үл нэвтрэх материалаар ханыг нь доторлосон байх
2. Зай завсаргүй хаалт хамгаалалт, агааржуулалт тагтай байх
3. Улирал бүр ариутгаж халдваргүйжүүлж байх
4. Жилд 1 удаа ариутгаж халдваргүйжүүлж байх
5. Модон материалаар л хийх

/521./ Эрүүлийг хамгаалах гэдэг нь ямар ойлголт вэ?

1. Хүн амын эрүүл мэндийг сайжруулах талаар төр засгаас авч хэрэгжүүлж буй арга хэмжээ
2. Эрүүл мэндээ сайн байлгах талаар хувь хүмүүсийн зүгээс авах арга хэмжээ
3. Хүн амыг эрүүл мэндийн үйлчилгээгээр хангах
4. Нийт хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох
5. Гэр бүлийн эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаа

/522./ Нийгмийн эрүүл мэндийн наад захын хэрэглээг нэрлэнэ үү ?

1. Аюулгүй байдал
2. Хөдөлмөр, биеийн тамир
3. Эрүүл мэндийн хүмүүжил боловсрол
4. Эмнэлгийн үйлчилгээ, эм тариа
5. Архи тамхины хэрэглээ

/523./ Эрүүл байхын тулд хүн бүр заавал хэвшүүлэх зүйлс юу вэ?

1. Гимнастикийг тогтмолжуулах
2. Өдөр бүр 10000-аас доошгүй алхах (6-10км)
3. Биед тогтмол ачаалал өгч жин, өндрийн харьцаагаа хянах
4. Нар усаар биеэ чийрэгжүүлэх
5. Амьдралын аюулгүй эерэг зан үйл эзэмшсэн байх

/524./ Хүн амыг зохистой хоол хүнсээр хангах үндсэн асуудал юу вэ?

1. Хоол хүнсний зүйлд тавих хяналтыг сайжруулах
2. Үндэсний чанартай уламжлалт хоол хүнсээр хангах
3. Хүнсний ногоон, цагаан хувьсгалын үйл ажиллагааг өргөжүүлэх
4. Хүнсний аюулгүй байдлыг хангасан байх
5. Хоол хүнсний найрлагын зөв зохистой байдал

/525./ Хүний эрүүл мэндийн байдал ба нийгмийн амьдралын шүтэлцээ юу вэ?

1. Эрүүл хүн нийгмийн гол нөөц баялаг мөн
2. Эрүүл энх байдал хүн бүрийн хүслэн, эдлэх ёстой эрх юм
3. Эрүүл мэнд байдал нь нийгмийн амьдралын чанарын гол үзүүлэлт болно
4. Эрүүл мэнд байдал нь хөдөлмөрийн чадвар өндөр байх зайлшгүй хэрэгцээ юм
5. Эрүүл хүн үйлдвэрлэх хүчний гол элемент болдог

/526./ Хүрээлэн буй орчны эрүүл байдал алдагдасны үр дагавар юу вэ?

1. Байгаль орчин бохирдоно
2. Хүн амын дунд өвчлөл ихэснэ
3. Хүмүүсийн амьдралын чанарт сөрөг нөлөөлөл гарна
4. Амьдарч ажиллах тааламжтай байдал алдагдана
5. Ажлын бүтээмж буурна

/527./ Өвчлөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлийн үндсэн ажлуудыг нэрлэнэ үү?

1. Эрүүл мэндийн сургалт сурталчилгаах
2. Ариун цэврийн урьдчилсан ба байнгын хяналт
3. Халдварт өвчлөлөөс сэргийлэх ажил
4. Оновчтой сувилан эмчлэх
5. Өвчлөлтийн тархалтын хүрээг тогтоох

/528./ Эрүүл мэндийн анхан шатны тусламж үзүүлэхэд баримтлах зарчмуудыг нэрлэнэ үү?
1. Эрүүл мэндийн анхны тусламж нь өргөн олныг хамарсан байх
2. Тусламж энгийн хялбар технологитой байх
3. Тусламж үзүүлэхэд орон нутгийн нөөц бололцоог ашиглах
4. Амьдралын чанарыг дээшлүүлэх
5. Салбар хоорондын хамтын ажиллагаанд тулгуурлах

/529./ Хүн амын дунд нэн түрүүнд хэвшүүлбэл зохих зан үйлийг нэрлэнэ үү?
1. Зохистой хооллох
2. Хорт зуршлаас зайлсхийх
3. Байгаль орчинтой зөв харьцах
4. Хүн амын өсөлтийг дээшлүүлэх
5. Хүн амын хүйсийн харьцааг тэнцвэржүүлэх

/530./ Эрүүл мэндийн боловсрол олгох үйл ажиллагааны үр дүнгийн шалгуур нь юу вэ?
1. Мэдэхгүй зүйлээ мэддэг болно
2. Буруу дадал зуршлаа орхин зөвд шилжинэ
3. Хүмүүсийн ахуй соёлжилтыг сайжруулна
4. Байгаль орчныг бохирдолтоос хамгаална
5. Эмгэг байдалд өртөхгүй байна

/531./ Өвчлөхөөс анхдагч урьдчилан сэргийлэлтэнд хамрах асуудлуудыг тэмдэглэнэ үү?
1. Хүүхэд багачуудын дархлаажуулалт
2. Унд ахуйн хэрэглээний усыг халдваргүйжүүлэх
3. Машинаар зорчихдоо суудлын бэхэлгээг хэрэглэх
4. Өвчлөл даамжрахаас сэргийлэх
5. Өвчний тархалтыг зогсоох

/532./ Эрүүл мэндийн анхан шатны тусламжуудыг нэрлэнэ үү?
1. Хүмүүст эрүүл мэндээ хамгаалах мэдлэг олгох
2. Нэн шаардлагатай эмээр хүн амыг хангах
3. Халдварт өвчлөлөөс сэргийлэх тарилга
4. Эмнэлгийн ерөнхий ба нарийн мэргэжлийн тусламж
5. Мэс ажилбар хийх

/533./ Бөөлжилтийн эсрэг үйлдэлтэй эмийг сонгоно уу.
A. Церукал
B. Фестал
C. Апоморфины гидрохлорид
D. Зофран
E. Контрикал

/534./ Хлорамфеникол ямар бүлгийн антибиотик вэ?
A. Пенициллины бүлэг
B. Цефалоспорины бүлэг
C. Макролидын бүлэг
D. Тетрациклины бүлэг
E. Левомицетины бүлэг

/535./ Захын үйлдэлтэй ханиалга дарах эмийг сонгоно уу.
A. Сальбутамол
B. Интал
C. Либексин
D. Бромгексин
E. Цититон

/536./ Инсулин ямар булчирхайнаас ялгарах вэ?
A. Нойр булчирхай
B. Бөөрний дээд булчирхай
C. Бамбай булчирхай
D. Өнчин тархи
E. Бэлгийн булчирхай

/537./ Цэр шингэлэх, ховхлох үйлдэлтэй эмийг сонгоно уу.
A. Сальбутамол

B. Интал
C. Либексин
D. Бромгексин
E. Цититон

/538./ Умайн булчинг сулруулах эмийг сонгоно уу.
A. Окситоцин
B. Динопрост
C. Питиутрин
D. Сальбутамол
E. Метилэргометрин

/539./ Анальгиний олон улсын нэршлийг сонгоно уу.
A. Ибупрофен
B. Метамизол натри
C. Индометазон
D. Фенилбутазон
E. Ацетилсалицилын хүчил

/540./ Нунтаг эмийн латин нэрийг сонгоно уу.
A. Capsula
B. Dragee
C. Pulvis
D. Pilula
E. Tabuletta

/541./ Окситоцин фармакологийн ямар үйлдэл үзүүлэх вэ?
A. Бөөрний дааврын холтослог давхаргыг идэвхжүүлнэ.
B. Бөөрний дааврын холтослог давхаргыг дарангуйлна.
C. Умайн булчинг агшааж, төрөлтийг түргэсгэнэ.
D. Умайн булчин сулруулж, төрөлтийг удаашруулна
E. Цусанд сахарын хэмжээг багасгана.

/542./ Хоол боловсруулах замаар орсон эм хаана цусруу шимэгдэх вэ?
A. Амны хөндийн салст
B. Ходоодны салст
C. 12 хуруу гэдэс
D. Нарийн гэдэс
E. Бүдүүн гэдэс

/543./ Мэдрэх мэдрэлийн сэрэл хүлээн авч дамжуулах чадварыг саатуулах буюу бууруулах эмийн зүйлд хамаарах эмийн бүлгийг сонгоно уу.
1. Хэсгийг мэдээгүйжүүлэх эм
2. Бүрхэх эм
3. Аргаах эм
4. Шингээх эм
5. Татах эм

/544./ Цөс хөөх эмүүдийг нэрлэнэ үү?
1. Холензим
2. Холосас
3. Аллохол
4. Панзинорм
5. Эссенциал

/545./ Шууд үйлдэлтэй амьсгал сэргээх эмийг сонгоно уу.
1. Пертуссин
2. Кофейн
3. Бромгексин
4. Бемегрид
5. Ацетилцистейн

/546./ Элэг хамгаалах бэлдмэлүүдийг нэрлэнэ үү.
1. Имодиум
2. Легалон

3. Денол
4. Эссенциал
5. Катерген

/547./ Мэдрэх мэдрэлийн сэрэл хүлээн авч дамжуулах чадварыг идэвхжүүлэх буюу сэргээх эмэнд дараахь бүлэг эмүүдээс аль нь орох вэ?

1. Рефлексээр амьсгал сэргээх эм
2. Цочроох эм
3. Рефлексээр цөс хөөх эм
4. Хэсгийг мэдээгүйжүүлэх эм
5. Аргаах эм

/548./ Дараах бэлдмэлүүдийн аль нь үрэвслийн эсрэг үйлдэлтэй вэ?

1. Тиреоидин
2. Дексаметазон
3. Инсулин
4. Преднизолон
5. Прогестерон

/549./ Өвдөлтийг мэдэрдэг рецептор хаана байрлах вэ?

1. Арьс
2. Салст
3. Булчин үений капсул
4. Ясны хальс
5. Дотор эрхтэнд

/550./ Ходоодны хүчлийг саармагжуулдаг эмүүдийг нэрлэнэ үү.

1. Магнийн исэл
2. Алмагель
3. Маалокс
4. Церукал
5. Фестал

/551./ Төмрийн бэлдмэлийг гиперхром цус багадалтанд хэрэглэнэ. Яагаад гэвэл гемоглобины үндсэн бүрэлдэхүүн төмөр юм.

/552./ Тетрациклины бүлгийн антибиотикийг сонгоно уу

1. Амоксиллин
2. Доксициклиныгидрохлорид
3. Цефотаксим
4. Тетрациклин
5. Тробицин

/553./ Нойрсуулах эмийг хэрхэн ангилдаг вэ?

1. Наркозын үйлдэлтэй нойрсуулах эм
2. Сэтгэл засах бүлгийн нойрсуулах эм
3. Нийлмэл найрлагатай нойрсуулах эм
4. Наркозын бус үйлдэлтэй нойрсуулах эм
5. Тайвшруулах бүлгийн нойрсуулах эм

АНАГААХ УХААНЫ БОЛОВСРОЛ ОЛГОХ ИХ, ДЭЭД СУРГУУЛИЙГ 2025 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛД **СУВИЛАГЧ** МЭРГЭЖЛЭЭР ТӨГСӨГЧДИЙН МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРЛИЙН ШАЛГАЛТЫН **ЖИШИГ СОРИЛ - II**

Сорилын зөв хариулт

1-A, 2-E, 3-A, 4-B, 5-C, 6-C, 7-B, 8-A, 9-E, 10-E, 11-B, 12-A, 13-B, 14-E, 15-E, 16-A, 17-E, 18-B, 19-E, 20-E, 21-E, 22-A, 23-E, 24-C, 25-E, 26-B, 27-E, 28-E, 29-C, 30-A, 31-B, 32-A, 33-C, 34-C, 35-B, 36-B, 37-A, 38-C, 39-A, 40-E, 41-A, 42-E, 43-C, 44-A, 45-B, 46-E, 47-A, 48-E, 49-B, 50-D, 51-A, 52-A, 53-E, 54-A, 55-B, 56-A, 57-A, 58-A, 59-E, 60-E, 61-A, 62-C, 63-E, 64-C, 65-E, 66-A, 67-A, 68-C, 69-B, 70-C, 71-D, 72-A, 73-D, 74-C, 75-B, 76-E, 77-A, 78-E, 79-E, 80-A, 81-A, 82-D, 83-A, 84-E, 85-B, 86-A, 87-E, 88-C, 89-B, 90-B, 91-E, 92-C, 93-A, 94-A, 95-C, 96-E, 97-B, 98-E, 99-E, 100-C, 101-A, 102-B, 103-A, 104-A, 105-C, 106-A, 107-C, 108-A, 109-C, 110-C, 111-A, 112-C, 113-B, 114-D, 115-A, 116-B, 117-A, 118-D, 119-C, 120-B, 121-A, 122-B, 123-B, 124-C, 125-E, 126-A, 127-A, 128-E, 129-C, 130-B, 131-C, 132-A, 133-A, 134-C, 135-E, 136-C, 137-C, 138-D, 139-A, 140-B, 141-C, 142-A, 143-D, 144-C, 145-C, 146-E, 147-C, 148-A, 149-D, 150-C, 151-C, 152-B, 153-A, 154-D, 155-C, 156-C, 157-A, 158-E, 159-B, 160-E, 161-B, 162-E, 163-A, 164-E, 165-E, 166-C, 167-E, 168-A, 169-A, 170-E, 171-C, 172-E, 173-E, 174-A, 175-C, 176-A, 177-A, 178-B, 179-E, 180-A, 181-A, 182-A, 183-A, 184-A, 185-A, 186-A, 187-A, 188-A, 189-A, 190-A, 191-E, 192-C, 193-C, 194-E, 195-A, 196-A, 197-D, 198-B, 199-E, 200-E, 201-A, 202-E, 203-E, 204-C, 205-E, 206-D, 207-D, 208-A, 209-E, 210-E, 211-E, 212-E, 213-E, 214-D, 215-E, 216-E, 217-A, 218-A, 219-E, 220-E, 221-D, 222-A, 223-B, 224-C, 225-C, 226-B, 227-E, 228-C, 229-B, 230-B, 231-B, 232-B, 233-D, 234-A, 235-D, 236-D, 237-B, 238-D, 239-A, 240-A, 241-B, 242-B, 243-E, 244-A, 245-B, 246-A, 247-A, 248-A, 249-E, 250-E, 251-E, 252-B, 253-A, 254-B, 255-C, 256-E, 257-E, 258-B, 259-A, 260-A, 261-D, 262-D, 263-B, 264-A, 265-C, 266-C, 267-C, 268-B, 269-B, 270-B, 271-A, 272-C, 273-E, 274-A, 275-C, 276-E, 277-A, 278-A, 279-E, 280-E, 281-E, 282-E, 283-C, 284-E, 285-A, 286-C, 287-D, 288-B, 289-B, 290-A, 291-E, 292-D, 293-A, 294-D, 295-B, 296-D, 297-B, 298-C, 299-A, 300-A, 301-D, 302-D, 303-D, 304-C, 305-C, 306-A, 307-B, 308-A, 309-B, 310-C, 311-C, 312-C, 313-E, 314-B, 315-D, 316-C, 317-D, 318-A, 319-A, 320-D, 321-A, 322-B, 323-D, 324-B, 325-E, 326-B, 327-C, 328-E, 329-A, 330-A, 331-E, 332-A, 333-A, 334-C, 335-E, 336-C, 337-A, 338-B, 339-B, 340-D, 341-C, 342-B, 343-A, 344-B, 345-A, 346-A,

1. Нэг сонголттой тест (Зөвхөн 1 хариулт зөв байх) Энэ хэлбэрийн сорил нь A, B, C, D, E гэсэн дугаартай бөгөөд Зөвхөн 1 зөв хариуг сонгоно.
2. Олон сонголттой тест (Хэдэн ч хариулт зөв байж болох)
   1, 2, 3 дугаар хариултууд зөв бол (A.)
   1, 2, 3, 4 дугаар хариултууд зөв бол (B.)
   2 ба 4 дугаар хариултууд зөв бол (C.)
   Зөвхөн 4-р хариулт зөв бол (D.)
   Бүх хариулт зөв бол (E.)
3. Шалтгаан хамаарлын тест (Заагдсан тестүүдийн үнэн зөв хийгээд тэдгээрийн шалтгаан хамаарлыг тодорхойлно.)
   Зөв, Зөв, Зөв (A.)
   Зөв, Зөв, Буруу (B.)
   Зөв, Буруу, Буруу (C.)
   Буруу, Зөв, Буруу (D.)
   Буруу, Буруу, Буруу (E.)

/1./ Сувилгааны үйл ажиллагааны үнэлгээний шатлал ямар үйл ажиллагаанаас бүрдэх вэ?
   1. Мэдээлэл цуглуулах
   2. Мэдээллийг баталгаажуулах

3. Мэдээллийг эмхлэх цэгцлэх
4. Мэдээлэл дээр үндэслэн төлөвлөгөө зохиох
5. Мэдээлэл дээр үндэслэн сувилгааны онош тавих

/2./ Сувилгааны үйл ажиллагааг судалж мэдэхийн ач холбогдол юу вэ?
1. Асуудал шийдэх чадвартай болно
2. Дүгнэх аргад суралцана
3. Сэтгэн бодох шийдвэр гаргах аргад суралцана.
4. Эрдэм шинжилгээ судалгааны ажлын үндэс болно.
5. Зөв шийдвэр гаргах аргад суралцана.

/3./ Сувилгааны үйл ажиллагааны үнэлгээний шатлалд үнэлгээг хэрхэн өгөх вэ?
1. Ажиглах
2. Ярилцах
3. Үзлэг хийх
4. Онош тогтоох
5. Дүн шинжилгээ хийх

/4./ Масловийн хэрэгцээний эрэмбийн хамгийн доод ба үндсэн хэрэгцээ юу вэ?
A. Аюулгүй байдал
B. Физиологийн
C. Хайрлах ба хүндлүүлэх
D. Өөрийгөө илэрхийлэх
E. Хайр ба эд юмс

/5./ Ходоод нь өвдөж буй өвчтөнд хийгдэх сувилгааг сонгоно уу?
1. Хүйтэн жин тавина.
2. Халуун жин тавина
3. Хоол сойно.
4. Эмчийн заалтаар эмчилгээ хийх
5. Цэвэрлэх бургуй тавина.

/6./ Бөөр, шээсний замын өвчлөлийн үед илрэх хавагналт нь зүрхний хавангаас ямар шинж байдлаар ялгаатай вэ?
1. Хавангийн байдал хатуу
2. Үүссэн хавантай хэсгийн өнгө цайвар
3. Үүссэн хавантай хэсгийн өнгө хөх
4. Хаван нь зөөлөн сэвсгэр, дээрээсээ доош илэрдэг
5. Хавантай хэсгийг дарахад хонхор үүсдэг

/7./ Эрүүл мэндийн боловсрол олгоход ямар зарчим баримтлах вэ?
1. Сэдэв нь өгөөжтэй байх
2. Хугацаа нь богино байх
3. Асуудал, хэрэгцээнд үндэслэсэн байх
4. Суралцагсдийн тоо олон байх
5. Хугацаа нь урт байх

/8./ Хүйтэн жин тавих зорилгыг тодорхойлно уу?
1. Цус алдалтыг зогсоох
2. Халуун бууруулах
3. Өвдөлт намдаах
4. Хаван бууруулах
5. Булчингийн агшилтыг сулруулах

/9./ Хүйтэн жин ямар үйлчилгээ үзүүлэх вэ?
1. Хэсэг газрыг хөргөж цусны судсыг нарийсгана.
2. Мэдрэлийн төгсгөлийн мэдрэх чадварыг бууруулна.
3. Өвчин намдаана
4. Халуун бууруулна
5. Цусан хангамжийг багасгана.

/10./ Халуун жин тавих зорилгыг тодорхойлно уу?
1. Дулаацуулах
2. Булчингийн агшилтыг сулруулах
3. Үрэвслийн процессийг нэмэгдүүлэх

4. Өвдөлт намдаах
5. Цусны судсыг өргөсгөх

/11./ Хуурай халуун жинг юугаар тавьж болох вэ?
1. Грелкээр
2. Халуун чулуугаар
3. Цахилгаан жинтүү
4. Халуун элсээр
5. Гэрлээр шарах

/12./ Бумбаны үйлчилгээг сонгоно уу?
1. Хэсэг газрын цусан хангамжийг сайжруулна.
2. Бие махбодид өөр төрлийн уургийн бодисын нөлөө үзүүлнэ.
3. Судасны нэвчимтгий чанарыг ихэсгэнэ.
4. Үүссэн хаван эргэж шимэгдэнэ.
5. Ойр орчмын эд эсэд хаван үүсгэнэ.

/13./ Бумба тавих заалтыг тодорхойлно уу?
1. Гуурсан хоолойн үрэвсэл
2. Уушигны үрэвсэл
3. Хавирга хоорондын үрэвсэл
4. Нуруу цээжний өвдөлт
5. Уушигны сүрьеэгийн идэвхитэй хэлбэрийн үед

/14./ Гичийг хэрэглэх аргуудыг сонгоно уу?
1. Гичтэй ванн
2. Наамал гич тавих
3. Гичтэй ороолт хийх
4. Гичтэй усанд хөл дүрэх
5. Гич, зөгийн балтай ороолт хийх

/15./ Гич тавих заалтыг тодорхойлно уу?
1. Амьсгалын замын үрэвсэлт өвчнүүд
2. Хоолой өвдөх үед
3. Стеникардийн үед
4. Цусны даралт ихдэх өвчний кризийн үед
5. Невралгийн үед

/16./ Судасны лугшилтыг тоолоход тохиромжтой талбайг сонгоно уу?
1. Чамархайн артери
2. Шууны эрхий хуруу талын артери
3. Гүрээний артери дээр
4. Бугалганы артери
5. Хэвлийн артери

/17./ Биеийн халууныг хэмждэг хэрэгслүүдийг нэрлэнэ үү?
1. Чихний сувгаар халуун үздэг термометр
2. Амны хөндийгөөр халуун үздэг термометр
3. Шулуун гэдсээр халуун үздэг термометр
4. Арьсны гадаргуугаар халуун үздэг термометр
5. Зайнаас халуун үздэг термометр

/18./ Өвчтөний өрөөний агааржуулалтыг хэдийд хийвэл хамгийн тохиромжтой вэ?
1. Өглөө боссоны дараа
2. Идээт боолт сольсны дараа
3. Бие зассаны дараа
4. Унтахын өмнө
5. Хоол идэхийн өмнө

/19./ Эмнэлэг хамгааллын дэглэмд хамаарах нөхцлүүдийг заана уу?
1. Гэрэл, дулаан, агаар
2. Больницын гадаад орчны ариун цэвэр
3. Эмнэлгийн байгууллагын ариун цэвэр
4. Дотоод дүрэм
5. Эмнэлгийн ажилчдын хувцаслалт

/20./ Өрхийн сувилагч ямар үндсэн үүрэгтэй вэ?
1. Өрхийн эмчийн ажилд туслана
2. Өндөр настан, хүнд өвчтэй хүмүүст гэрээр тусламж үзүүлэх
3. Жирэмсэн эх, болон нярайг эргэх
4. Сайн дурынханд хичээл заана.
5. ЭМАШТ-ийн тайлан мэдээ гаргана.

/21./ Өрхийн сувилагч нар хүн амаа эрүүл мэндийн байдлаар хэдэн бүлэг болгон хуваадаг вэ?
1. Цоо эрүүл
2. Эрүүл
3. Ээнэгшил бүхий архаг өвчтэй
4. Хагас ээнэгшил бүхий архаг өвчтэй
5. Ээнэгшлээ алдсан архаг өвчтэй

/22./ Цооролт үүсэх гадаад шалтгааныг тодорхойлно уу?
1. Асаргаа, сувилгаа муу байснаас
2. Гадны ямар нэгэн зүйлд удаан хугацаагаар дарагдснаас
3. Үйлчлүүлэгчийг нэг байрлалд удаан хэвтүүлснээс
4. Биеийн эсэргүүцэл муу байснаас
5. Мэдрэл тэжээлийн дутагдал болсноос

/23./ Цооролт үүсэж болох талбайг сонгоно уу?
1. Ахар сүүлний хэсэг
2. Өсгий
3. Дал нурууны шонтон ясны хэсэг
4. Хөлийн шагай
5. Ташаан толгой

/24./ Насанд хүрэгчдэд нуралт ямар шалтгаанаас үүсдэг вэ?
1. Удаан хугацаагаар хэвтэрт байх
2. Тарган хүмүүст
3. Холбох эд, эсийн элемент дутмаг учир
4. Ариун цэвэр сахиагүйгээс
5. Цусны судасны нэвчимтгий чанар ихэсснээс

/25./ Амны хөндийг угаахын ач холбогдол юу вэ?
1. Амны хөндийг цэвэр байлгах
2. Амны хөндийн эвгүй үнэр, амтыг арилгах
3. Шүд цоорч буйл үрэвсэхээс сэргийлэх
4. Амны хөндийгөөс халдвар дамжихаас сэргийлэх
5. Хооллох дуршлыг нэмэгдүүлэх

/26./ Биеийн хэсэгчилсэн угаалгыг ямар зорилгоор хийдэг вэ?
1. Хувийн ариун цэврийг сахиулах
2. Өвчтөнийг тайвшруулан сэргээх
3. Бодисын солилцоог эрчимжүүлэх
4. Нуралт, цооролтоос сэргийлэх
5. Хурц халдварт өвчтэй хүнд угаалга хийх

/27./ Хүчилтөрөгч өгөх хэлбэрүүдийг сонгоно уу?
1. Хүчилтөрөгчийн дэр
2. Баллоноор амьсгалуулах
3. Хүчилтөрөгчийн майхан
4. Барокамер
5. Хүчилтөрөгчийн коктель

/28./ Эм хэрэглэхэд анхаарах дүрмийг дурьдана уу?
1. Харшил урвал өгдөг эсэхийг лавлана
2. Тун хэмжээ нь зөв эсэхийг тодруулна
3. Тухайн өвчтөнд олгох эм мөн эсэхийг тодруулна
4. Тухайн эмийг ямар замаар хэрэглэхийг мэддэг
5. Тухайн эмийг өгөх цаг мөн эсэхийг тодруулна

/29./ Эмийн бодисыг парентераль аргаар хэрэглэх гэж юу вэ?

1. Эмийн бодисыг ууж хэрэглэх
2. Эмийн бодисыг арьсан дор тарьж хэрэглэх
3. Эмийн бодисыг шулуун гэдсээр хэрэглэх
4. Эмийн бодисыг судсанд тарьж хэрэглэх
5. Эмийн бодисыг амьсгалын замаар хэрэглэх

/30./ Эмийн бодисын тарилгаар хэрэглэхийн дутагдалтай тал нь юу вэ?
1. Бие махбодид халдвар орох боломж бүрдэж болзошгүй
2. Эд эрхтэнийг зүүгээр хатгаж гэмтээдэг
3. Өвтгөж, эд эсийг цочроодог
4. Бие махбодид хурдан шимэгдэж үйлчилгээ үзүүлдэг
5. Халдваргүйжүүлэх дэглэм баримтлах шаардлага гардаггүй

/31./ Сувилагч тариа хийх үед халдвараас сэргийлэх замуудыгсонгоно уу?
1. Хатгах талбайг ариутгана.
2. Бэлтгэсэн тариаг стандартын дагуу тариурт соруулна.
3. Тариурын хошуу заавал зүүтэй буюу тагтай байна.
4. Зүүний бүрхүүлийг авмагц хатгалтыг хийнэ.
5. Зүү тариурыг зөв барина.

/32./ Тарих эмийн бодисын хаягийг ямар үед шалгадаг вэ?
1. Тариаг соруулж дуусаад ампулаа хаяхын өмнө
2. Тариагаа сонгохдоо
3. Тариаг соруулахын өмнө
4. Тариаг соруулаад тариур дахь хийг гаргахад
5. Тариурыг угсарч бэлтгэсний дараа

/33./ Ямар зорилгоор арьсан дотор тариаг хийдэг вэ?
1. Эмийн бодисыг амаар ууж хэрэглэж чадахгүй үед
2. Харшлыг оношлох, тогтоох
3. Бие махбодид удаан шимэгддэг эмийн бодисыг тарих
4. Бие махбодид өвчний үүсгэгч байгаа эсэхийг мэдэх
5. Зүрх, судас, амьсгалын замыг дэмжих эм тариаг хийх

/34./ Арьсан дотор тарилга хийх талбайг нэрлэнэ үү?
A. Далны арьсан дор
B. Гуяны арьсан дор
C. Шууны арьсан дор
D. Бугалганы арьсан дор
E. Хэвлийн арьсан дор

/35./ Булчинд тариа хийж болох талбайг сонгоно уу?
1. Өгзөгний гадна дээд хэсгийн булчин
2. Мөрний булчин
3. Гуяны гадна дунд хэсгийн булчин
4. Өгзөгний урд дээд хэсгийн булчин
5. Шууны булчин

/36./ Булчингийн эдэд ямар эмийн бодисыг хийдэг вэ?
1. Өвдөлт өгдөг, бие мах бодид удаан тархдаг
2. Булчинд тарих заалт бүхий эмийн бодис
3. Зарим нэгэн витаминууд
4. Антибиотикууд
5. Зүрхний глюкозитууд

/37./ Булчин тарианы үед яагаад бэрсүү үүсдэг вэ?
1. Антибиотикийг шаардагдах хэмжээний уусмалаар найруулаагүйгээс
2. Тарилга арьсан дор хийгдсэнээс
3. Булчинд хэрэглэх зүүг буруу сонгосноос
4. Булчинд буруу эмийн бодисыг хийснээс
5. Удаан шимэгддэг тариаг булчинд тарьснаас

/38./ Булчин тариа хийх үед яагаад тромбо үүсдэг вэ?
1. Асептик зарчим алдагдснаас
2. Судас дайрсан эсэхийг шалгаагүй хийснээс

3. Тосон тариаг хийтэй шахснаас
4. Тосон тариа хийх үед судас дайрсан эсэхийг шалгаагүй хийснээс
5. Тосон тариаг бүлээсгэж хийгээгүйгээс

/39./ Өгзөгний булчинд тариаг хийхэд яагаад заавал өвчтөнийг хэвтүүлж тарьдаг вэ?
1. Өвдөлтийг бууруулах
2. Булчинг сулруулах
3. Эмийн бодисын шимэгдэх хурдыг нэмэгдүүлэх
4. Тарихад хамгийн эвтэй байрлал учраас
5. Өвчтөний сэтгэл санааг тайвшруулах

/40./ Булчин тариа хийх үед өвдөлтийг бага мэдрүүлэхийн тулд авах арга хэмжээг сонгоно уу?
1. Байрлалаа зөв сонгоно.
2. Z хэлбэрийн хатгалт хийнэ.
3. Сэтгэл санааг тайван байлгана.
4. Олон давтан нэг талбайд хатгалт хийж болохгүй.
5. Боломжтой бол эмийн бодисыг тарилгаас өөр замаар хэрэглэнэ

/41./ Венийн судсанд тарилга хийх үед асептик зарчим алдагдвал доорхи хүндрэлүүдээс аль нь тохиолдох вэ?
A. Сепсис
B. Абсцесс
C. Шок
D. Эмболи
E. Тромбо

/42./ Венийн судсанд тарилга хийх үед юуг анхаарах èстой вэ?
1. Судсаар хольж болохгүй тарилгуудыг
2. Тарих эмийн нэр хаяг, хадгалах хугацаа, тун хэмжээ
3. Тарих талбай хатгах судсыг зөв сонгох
4. Тариурын зүү судсанд байгаа эсэхийг шалгах
5. Тарилыг аажим болгоомжтой шахах

/43./ Кальци хлоридийг судасны гадуур алдсан тохиолдолд ямар арга хэмжээ авах вэ?
1. 2%-ний натри хлоридийн уусмалаар боолт хийнэ.
2. 25% -ий магнизм сульфатыг алдсан хэсэгт тарина.
3. 15% -ий магнизм сульфуриц алдсан хэсэгт тарина.
4. 10%-ний натри хлоридийн уусмалаар боолт хийнэ.
5. Алдсан газар нэрмэл ус тарина.

/44./ Ямар зорилгоор судсанд хатгалт хийж цус авдаг вэ?
1. Вессерманы урвал тавих
2. Цусны ариун чанарыг тодорхойлох
3. Цусны биохимийн шинжилгээ
4. Тодруулагч бодис шахах
5. Цусны групп тодорхойлох

/45./ Венийн судсанд дуслаар шингэн юүлэх заалтуудыг сонгоно уу?
1. Бие мах бодид шингэн дутагдсан үед
2. Янз бүрийн хордлогуудын үед хордлого тайлах
3. Цус алдсан үед
4. Хагалгааны өмнө ба дараа
5. Бие мах бодид эргэлдэх цусны нийт хэмжээг нэмэгдүүлэх

/46./ Дусал тариа хийх үед хариу урвал ямар байдлаар илрэх вэ?
1. Ууц, нуруугээр хөших
2. Чичрэх
3. Толгой өвдөх
4. Дотор муухайрах
5. Хүйтэн хөлс гарах

/47./ Цус сэлбэж болох заалтуудыг нэрлэнэ үү?
1. Цус багадсан үед
2. Цус алдсан тохиолдолд

3. Хагалгааны өмнө ба хагалгааны дараа
4. Бөөрний хурц үрэвслийн үед
5. Цусны даралт багасах өвчний үед

/48./ Цус цусан бүтээгдэхүүн судсаар юүлэхэд анхаарах зүйлүүд юу вэ?
1. Үйлдвэрлэсэн он, сар, өдөр, серийн дугаар
2. Өвчтөний халууныг үзэх
3. Цусны хувийн тохироо үзэх
4. Бүлгийн тохироо үзэх
5. Биологийн тохироо үзэх

/49./ Донор цусаа өгөхийг ямар тохиолдлуудад хориглодог вэ?
1. Нян, вирус, бактерийн эрүүл тээгч
2. Мансууруулах донтон
3. Хорт хавдартай
4. Тэмбүү, ДОХ-оор өвчилсөн
5. Тамхи татдаг бол

/50./ Хэвлийн хөндийд хуримтлагдсан шингэнийг түргэн гоожуулж авбал өвчтөнд ямар хүндрэл илрэх вэ?
A. Хэвлийгээр базалж өвдөнө.
B. Тархины цусан хангамж нарийсч толгой өвдөнө.
C. Дотор муухайрч бөөлжис цутгана.
D. Хэвлийн даралт гэнэт бууж чичрүүлнэ.
E. Хэвлийн даралт гэнэт бууж ухаан алдана.

/51./ Ходоодонд хаймсуурыг ямар зорилгоор тавьдаг вэ?
1. Ходоод угаахын тулд
2. Хооллохын тулд
3. Эмийн бодис хэрэглэхийн тулд
4. Өвдөлт намдаахын тулд
5. Хоолны шингэц сайжруулахын тулд

/52./ Ходоодыг угаах ямар арга байдаг вэ?
1. Механик арга
2. Хаймсууруар угаах арга
3. Бөөлжүүлэх эмийг арьсан дор тарих арга
4. Физикийн арга
5. Биологийн арга

/53./ Ходоодонд зонд тавьж болохгүй заалт юу вэ?
1. Ходоод гэдэсний шархлаатай
2. Улаан хоолой нарийссан ба судас өргөссөн үед
3. Ходоод химийн бодисоор түлэгдсэн үед
4. Жирэмсний сүүлийн сард
5. Ходоод улаан хоолойноос цус алдаж байгаа үед

/54./ Цөс угааж болохгүй заалтыг нэрлэнэ үү?
1. Цөсний хурц үрэвслийн үед
2. Цөсний чулуутай үед
3. Ходоод улаан хоолойноос цус алдаж байвал
4. Цөс тогтонго болсон үед
5. Цөсний архаг үрэвсэл

/55./ Цэвэрлэх бургуй тавих заалтыг олно уу?
1. Өтгөн хатсан тохиолдолд
2. Мэс заслын өмнө
3. Хэвлийн хөндийн эрхтэний зураг авахад
4. Янз бүрийн хордлогын үед
5. Өвчтөн хавантай үед

/56./ Цэвэрлэх бургуй тавих эсрэг заалтыг олно уу?
1. Хоол боловсруулах эрхтэнээс цус алдаж байгаа үед
2. Анус урагдах үед
3. Өвчтөн хавантай үед

4. Өтгөн хатахад
5. Янз бүрийн хордлогын үед

/57./ Бичил бургуйг юугаар тавибал тохиромжтой вэ?
A. Ургамлын тосоор
B. Савангийн уусмалаар
C. Содын уусмалаар
D. Буцалсан усаар
E. Бүгд зөв

/58./ Бургуй тавихад яагаад бургуйн хошууг тослодог вэ?
1. Салт бүрхэвчийг гэмтэхээс сэргийлэх
2. Өвдөлтөөс сэргийлэх
3. Шулуун гэдэс рүү хошуу чөлөөтэй орох боломжийг бүрдүүлнэ
4. Ус чөлөөтэй орох боломжийг бүрдүүлэх
5. Бургуйн хошууг гэмтэхээс сэргийлэх

/59./ Шээлгүүр тавих зорилгыг тодорхойлно уу?
1. Давсаг угаах
2. Давсган дахь шээсийг авах
3. Давсганд эмийн бодис хийх
4. Давсаг дурандахын өмнө
5. Давсганд мэс засал хийхийн өмнө

/60./ Сувилагч тусламж үзүүлээд юуг тэмдэглэх вэ?
1. Өвчтөний биеийн байдлын талаарх мэдээлэл
2. Өвчтөнд үзүүлсэн тусламж, сувилгаа
3. Эмчилгээний хуудас
4. Тусламжийн үр дүн, өвчтөний биеийн өөрчлөлт
5. Ажиглалтын хуудас

/61./ Ходоод угаахын өмнө үйлчлүүлэгчээ хэрхэн бэлтгэх вэ?
1. Тайван хэвтүүлэх болон суугаа байрлалд
2. Өвчтөний хиймэл, шүд тагнайг авна.
3. Өвчтөнд үйлдлээ тайлбарлаж ойлгуулна.
4. 3 хоногийн өмнөөс цагаан хоол өгнө.
5. Өлөн байлгана.

/62./ Хэвлий орчим бүлээн жин тавих эсрэг заалтыг нэрлэнэ үү?
1. Ходоодны шархлаа сэдэрсэн үед
2. Дотуур цус алдалт
3. Гэдэс базлах
4. Хэвлийн мэс заслын цочмог өвчин сэжиглэгдэж байгаа бол
5. Ходоод өвдөх

/63./ Ямар эмгэгүүд шээс цочмог хаагдахад хүргэдэг вэ?
1. Түрүү булчирхайн хавдар
2. Бөөрний дутмагшил
3. Шээсний хос суваг дарагдах
4. Хэвлийн хөндийн хагалгааны дараа
5. Ерөнхий унтуулгатай мэс заслын дараа

/64./ Ямар тохиолдолд мөстэй уут /жин/ хэрэглэдэг вэ?
1. Бөөрний колик
2. Дотуур цус алдалт
3. Тарианы дараах бэрсүү үүссэн үед
4. Өндөр халуурах
5. Ходоод өвдөх

/65./ Зүрхний архаг дутмагшилтай өвчтөний асаргаа сувилгаанд аль нь чухал вэ?
1. Хэвтрийн дэглэм
2. Толгойн хэсгийг өндөрсгөх
3. Хэрэглэх шингэн болон давсны хэмжээг хязгаарлах
4. Хаванг хянах
5. Хүчилтөрөгч эмчилгээ

/66./ Тасралтгүй бөөлжиж буй өвчтөнд ямар сувилахуйн тусламж үзүүлэх вэ?
1. Амыг нь цэвэр усаар байнга зайлуулна
2. Ходоод гэдэс угаана
3. Хиймэл шүднүүдийг авахуулна
4. Хагас суугаа байрлалд байрлана
5. Хэвлийд нь бүлээн жин тавина

/67./ Цус юүлж болохгүй шалтгаанд аль нь орох вэ?
1. Элэг, бөөрний үйл ажиллагааны хямрал
2. Зүрхний ажиллагааны алдагдал
3. Харшил ба идэвхтэй сүрьеэ
4. Хурц цус багадалтын үед
5. Хавдар өвчний үед

/68./ Зүрхэнд шууд бус массаж хийхэд гарын алгыг хаана байрлуулах вэ?
A. Өвчүүний дээд 1/3
B. Өвчнүүний дээд ба дунд 1/3
C. Өвчүүний дунд ба доод 1/3
D. Зүүн хөхний шугамаар
E. Аюулхайн мөгөөрс дээр

/69./ Шигдээстэй өвчтөнд сувилгааны дараах зарчим баримтлана.
1. Өдөрт 2-3 удаа хооллоно.
2. Өвчтөнд өнжөөд цэвэрлэх клизм тавьж бие засуулна.
3. Хэвтрийн дэглэм эхний 2,3 өдөр баримтлана.
4. Холголт цооролтоос урьдчилан сэргийлнэ
5. Өвчнийх нь байдлыг нууцлана.

/70./ Гич нь цочроох үйлчилгээгээ хэдэн хэмд алддаг вэ?
A. 50C
B. 45C
C. 60C
D. 55C
E. 40C

/71./ Сүрьеэгийн сорилын хариу хэдэн цагийн дараа гарах вэ?
A. 1 цагийн дараа
B. 12 цагийн дараа
C. 48 цагийн дараа
D. 72 цагийн дараа
E. 7 хоногийн дараа

/72./ Каццоны сорилоор ямар өвчин тээгчийг илрүүлэх вэ?
A. Бэтэг
B. Бруцеллёз
C. Сүрьеэ
D. Халдварт саа
E. Ревматизм

/73./ Сорил тарилгын үед хэрэглэх уусмалын хэмжээг заана уу.
A. 1-2 мл
B. 0,3-0,5 мл
C. 0,5-1 мл
D. 0,1-0,3мл
E. 0,2-0,3 мл

/74./ Сорил тарилгын үед хэрэглэх зүүний хэмжээг заана уу.
A. 20G
B. 22 G
C. 26 G
D. 23 G
E. 21 G

/75./ Тархинд хий шахсан өвчтөнг хэдэн цаг хэвтрийн дэглэмд байлгах вэ?
A. 24 цаг

B. 48 цаг
C. 72 цаг
D. 2 цаг
E. 12 цаг

/76./ Сувилгааны явцын эхний үе шат болох “ Үнэлгээний “ үед сувилагч юу хийх вэ?
A. Ажилдаа шууд орно. / Үйл ажиллагаагаа эхэлнэ /
B. Сувилгааны оношийг тавина.
C. Сувилгааны төлөвлөгөөг боловсруулна
D. Сувилгааны төлөвлөгөөг хэрэгжүүлнэ.
E. Өвчтөнөө үзэж үнэлгээ өгөх

/77./ Халуун жин тавих хугацааг заана уу?
A. 10-30 мин
B. 2-3 цаг
C. 30 мин -1 цаг
D. 3-3,5 цаг
E. 4 цагаас дээш

/78./ Хураагуур судаснаас шинжилгээнд зориулж насанд хүрсэн хүнээс хэдэн мл цус авах вэ?
A. 5-10мл
B. 20-25мл
C. 25-30мл
D. 20-30мл
E. 10-18мл

/79./ 3 сартай, өвчний улмаас эмчийн заалтаар пенициллинийг 125000 ед –ээр 6 цагийн зайтай тарих шаардлагатай . Тарих талбайг сонгоно уу.
A. Өгзөгний гадна дээд 1/4
B. Хэвлийн урд хананы булчинд
C. Мөрний гурвалжин булчинд
D. Далны доод дугуй булчинд
E. Гуяны өмнө ба гадна хэсгийн булчинд

/80./ Өвчтөний цусыг авч 1,2,3 бүлгийн ийлдэстэй холиход аль нь ч ээдсэнгүй тул хэд дүгээр бүлгийн цус вэ?
A. 1-р бүлэг
B. 2-р бүлэг
C. 3-р бүлэг
D. 4-р бүлэг

/81./ Эмэгтэйн шээсний сүвийн уртын хэмжээг олно уу?
A. 4 см
B. 6 см
C. 8 см
D. 10см
E. 3 см

/82./ Сорил тарилгыг хэдэн хэмийн өнцөгөөр хийх вэ?
A. 90 хэм
B. 45-60 хэм
C. 10-15 хэм
D. 3-5 хэм
E. 5-10 хэм

/83./ Биологийн сорил үзэхэд цусыг судсанд яаж явуулах вэ?
A. Урсгаж явуулах
B. 1 минутанд 20-30 дусал
C. 1 минутанд 40-60 дусал
D. 1 минутанд 10-20 дусал
E. 1 минутанд 30-40 дусал

/84./ Мантугийн сорилыг эсрэг гэж тооцох гүвдрүүний хэмжээ хэд байдаг вэ?
A. 1-5 мм

B. 5-10 мм
C. 10-17 мм
D. 5-17 мм
E. 17 мм-ээс дээш

/85./ Шээсний хувийн жин хэвийн хэмжээндээ хэд байх вэ?
A. 1000-1005
B. 1010-1020
C. 1030-1040
D. 1050-1060
E. 1040-1050

/86./ Нярай хүүхэд нэг минутанд хэдэн удаа амьсгалах вэ?
A. 40-45
B. 16-20
C. 20-30
D. 30-40
E. 60-80

/87./ Асаргаа сувилгааны үндсэн зарчмуудад аль нь хамаарагдах вэ?
1. Орчин
2. Хоол
3. Хувцаслалт
4. Сэтгэл зүй
5. Шинж тэмдгийн асаргаа

/88./ Сувилагч нь сувилгааны төлөвлөгөө боловсруулахдаа хэрэгцээний эрэмбийн онолыг ашигладаг. Хэрэгцээний эрэмбийн онолыг зохиосон хүнийг нэрлэнэ үү?
A. Ричард Калиш
B. Жим Оттери
C. Абрахам Маслоу
D. Доротеа Орем
E. Рутвайт

/89./ Сувилагчийн чадварыг дотор нь юу гэж ангилдаг вэ?
1. Гардан хийх ур чадвар
2. Харилцааны ур чадвар
3. Сэтгэн бодох, шийдвэр гаргах ур чадвар
4. Хамтран ажиллах, багаар ажиллах чадвар
5. Компьютер дээр ажиллах чадвар

/90./ Сувилагч хүн үйлчлүүлэгчийн хувьд хэн бэ?
1. Эрүүл мэндээ бэхжүүлэхэд нь туслагч
2. Эрүүл мэндээ хамгаалахад нь туслагч
3. Эрүүл болохын төлөө тэмцэхэд нь туслагч
4. Ойр дотны зөвлөгч
5. Сувилгаа асаргаа үзүүлэх

/91./ Эмийн бодисыг шалгахдаа юуг нь шалгах вэ?
1. Нэр
2. Тун
3. Хэмжээ
4. Тундас
5. Хугацаа

/92./ Арьсан дор тарилга хийх зорилго юу вэ ?
1. Оношлогооны
2. Урьдчилан сэргийлэх
3. Сорил тодорхойлох
4. Эмчилгээний
5. Харшлыг тогтоох

/93./ Ходоод угааж болохгүй эсрэг заалтыг тодорхойлно уу?
1. Улаан хоолойн венийн судас өргөссөн тохиолдолд
2. Ходоод улаан хоолойноос цус алдаж буй үед

3. Жирэмсний сүүлийн саруудад
4. Эмийн бодисоор хордсон үед
5. Химийн бодисын хордлогын үед

/94./ Шинжилгээнд түрхэцийг хаанаас авч болох болох вэ?
1. Хоолойноос
2. Цэрнээс
3. Үтрээнээс
4. Хэвлийн хөндийнөөс
5. Үрэвсэлийн голомтоос

/95./ Эмийг харж байгаад уулгах нь ямар ач холбогдолтой вэ?
1. Эдийн засгийн
2. Эмчилгээний үр дүнг хянах
3. Эмэнд итгэх итгэлийг төрүүлэх
4. Хариу урвал өгөх эсэхийг хянах
5. Эмчлүүлэгчийг хянах

/96./ Эрүүл мэндийн боловсрол олгосноор ямар амжилтанд хүрэх вэ?
1. Мэддэггүйгээс мэддэг болох
2. Буруу ойлголтоос зөв ойлголтод шилжих
3. Тохиромжгүй хандлагаас тохиромжтой хандлагад шилжих
4. Буруу зуршлаас зөв дадалд төлөвшинө
5. Эрүүл мэндийн үзүүлэлт нь дээшилнэ

/97./ Бичил бургуйг хэдэн хэмийн уусмалаар тавих вэ?
A. 34 – 35 хэм
B. 37 – 38 хэм
C. 35- 36 хэм
D. 38 – 39 хэм
E. 40 хэм

/98./ Ямар зорилгоор толгойг угаах вэ?
1. Толгой, хуйхны цусан хангамжийг сайжруулах
2. Үсний ариун цэвэр сахиулах
3. Толгой хэсгийн ариун цэвэр эрүүл ахуйг хангах
4. Үйлчлүүлэгчийг амраах
5. Үйлчлүүлэгчийг тайвшруулах

/99./ Хүйтэн жин, бигнүүрийг ямар зорилгоор тавих вэ?
1. Тархины хавангаас урьдчилан сэргийлэх
2. Үрэвсэл намдаах
3. Цус алдалтыг зогсоох
4. Халуун бууруулах
5. Өвдөлт намдаах

/100./ Цэвэрлэх бургуй тавих эсрэг заалтыг заана уу?
1. Тэжээлийн бургуй тавихын өмнө
2. Хоол идсэн даруйд
3. Мэс засалд бэлтгэх үед
4. Хоол боловсруулах замаас цус алдаж байвал
5. Хордлогын үед

/101./ Хандлага гэж юу вэ?

A. Хандлага гэдэг нь èс зүйг бодвол илүү өргөн утгатай ерөнхий ойлголт бөгөөд аливаа юманд хандах хүний үйл хөдлөл, үг яриагаараа илэрхийлж буй сэтгэлийн дотоод илэрхийлэл юм.

B. Хандлага гэдэг нь èс зүй дотор агуулагдах, харилцааны соèлыг утгандаа агуулсан ерөнхий ойлголт бөгөөд хүний аливаа юманд хандах сэтгэл зүй, зан төлөвийг хэлнэ.

C. Хандлага гэдэг нь ердөө хүний боловсролын түвшингээс шалтгаалан хүнтэй харилцах байдал.

D. Хандлага гэдэг нь хүн хүний хоорондын харилцаа

E. Хандлага гэдэг нь хүнийг хүндэтгэж байгаа байдал.

/102./ Эрэгтэй хүнд шээлгүүрийг ямар хэмжээтэй тавих вэ?

A. 3-4 см
B. 18-20 см
C. 5-10 см
D. 10-15 см
E. 15-18 см

/103./ Дусал тарианы үед яагаад реакц өгдөг вэ?
1. Шингэн өвчтөнд тохирохгүй байснаас
2. Дуслыг хурдан хийснээс
3. Дусал хийж байх үед өвчтөнг дааруулснаас
4. Дуслыг хэт удаан хийснээс
5. Шингэнийг бүлээсгэж хийснээс

/104./ Асаргаа сувилгааны үндсэн зарчимд орчин хоол, хувцаслалт нь чухал яагаад гэвэл, эмчлүүлэгчийн сэтгэлзүйг дэмждэг учир хүн бүрт энэ үйл ажиллагааг төлөвлөдөг.

/105./ Сорил тарилгыг харшлыг илрүүлэх зорилгоор тавьдаг учир бугалганы 1/3 орчмын талбайг сонгодог яагаад гэвэл зарим тохиолдолд халдвараас сэргийлэх зорилгоор тавьдаг.

/106./ Цэвэрлэх бургуйг янз бүрийн хордлогын үед тавьдаг, учир эмчлүүлэгч хоол боловсруулах эрхтнээс цус алдаж байгаа үед, мөн хавантай байвал цэвэрлэх бургуй тавихыг хориглоно.

/107./ Амьсгалаа гаргасны дараа цацлага хэрэглэх нь үр дүнтэй яагаад гэвэл үрэвслийг шууд бууруулдаг учраас өдрийн цагаар голчлон хэрэглэнэ.

/108./ Судасны дотуур урсаж байгаа цус урсах хүчээрээ хананд даралт буй болгодог учир түүнийг цусны даралт гэх ба даралтыг Коротоковын аргаар хэмжинэ.

/109./ Хураагуур судаснаас цус авахдаа вакутейнерийг хэрэглэх нь илүү тохиромжтой байдаг яагаад гэвэл нэг удаад 40-50 мл цусыг авдаг ба энэ нь стандарт хэмжээ юм.

/110./ Наамал гич нь цочроох үйлчилгээгээ +60 дээш хэмд алддаг учир 60+65 хэмийн усанд дүрж, хүйс орчимд нааж хэрэглэнэ.

/111./ Гичийг наамал, ороолт байдлаар хэрэглэдэг яагаад гэвэл гичний үйлчилгээ янз бүр байдаг учир тохирох аргыг сонгохдоо насны байдалд тохируулах нь илүү үр дүнтэй байдаг.

/112./ Биеийн халуун өглөө 9-11 цаг, оройн 16-18 цагийн хооронд багасдаг учир энэ үед өвчтөний халууныг үзэх шаардлагагүй яагаад гэвэл хэмжилт буруу гарна.

/113./ Стрептомициныг их тунгаар удаан хэрэглэвэл сонсголд нөлөөлдөг учир эмчийн хяналтан дор хэрэглэдэг яагаад гэвэл стрептомицин нь сүрьеэгийн микобактериас өөр нянд нөлөөлөхгүй.

/114./ Амьсгалыг тоолохдоо зөвхөн ажиглах аргаар тоолдог яагаад гэвэл үйлчлүүлэгчид мэдэгдэхгүй байх нь чухал учир бусад арга нь үр дүн багатай байдаг.

/115./ Нярай, хөлд ороогүй хүүхдэд өгзөгний арын дээд хэсэгт тарилга хийж болохгүй яагаад гэвэл мэдрэлийн ширхэг элбэг байдаг учир гуяны булчингийн урд 1/3 дунд хэсэгт тарьж болдог.

/116./ Эрүүл мэндийн боловсрол олгох гол зарчим нь өвчнөөс урьдчилан сэргийлэх учир хүн ардыг эрүүл аж төрөхөд тус болдог мөн, үйлчлүүлэгчийг эмнэлэгтэй холбож өгөхөд чиглэгдэнэ.

/117./ Цус сэлбэхэд биологийн тохироог хэрхэн хийдэг вэ?
A. Өвчтөнд 25 мл цус хийгээд 5 минут ажиглан, үйлдлийг 3 удаа давтаж хийнэ.
B. Өвчтөний цусны сийвэнг донорын цустай хольж үзнэ.
C. Донорын цусыг өвчтөний цустай хольж үзнэ.
D. Донорын цусны ийлдсийг өвчтөний цустай хольж үзнэ.
E. Өвчтөнд 25 мл цус хийгээд 20 минут ажиглан, үйлдлийг 3 удаа давтаж хийнэ.

/118./ Ямар зорилгоор Z замын аргаар булчин тарилгыг хийх вэ?
1. Булчин тарилга хийх тохиолдол бүрт буцаан тариаг гаргахгүйн тулд
2. Настай тарган хүнд тариаг буцаж гаргахгүйн тулд
3. Туранхай хүмүүст тариаг буцаж гаргахгүйн тулд
4. Настай туранхай хүнд тариаг буцаж гаргахгүйн тулд
5. Хүүхдэд тариаг буцаж гаргахгүйн тулд

/119./ Үйлийн потенциаль гэж юу вэ?
1. Тайвны потенциалын хэлбэлзэл
2. Сэрэл

3. Зааг хүчээс доогуур хүчээр үйлчлэхэд үүсэх хэлбэлзлэл
4. Зааг хүчний нөлөөгөөр үүсэх потенциалын эгшин зуурын хэлбэлзлэл
5. Бие махбодын хариу урвал

/120./ Насанд хүрсэн хүний цусны улаан эс хэд байх вэ?
1. 4-4.2х1012/л
2. 4.5-5х1012/л
3. 6.5-7х1012/л
4. 10-12х1012/л
5. 7-10х1012/л

/121./ Хамрын дагалдах хөндийд дараахаас аль нь орох вэ?
A. Духны
B. Хоншоорын
C. Самалдагийн
D. Хэнгэргэн хөндий
E. Хамрын хөндийн дээд хэсэг

/122./ Ясны ач холбогдолоос дурьдана уу?
1. Тулгуур хөдөлгөөний
2. Хамгаалах
3. Бодисын солилцоонд оролцох
4. Цус төлжүүлэх
5. Тээвэрлэх

/123./ Симпатик мэдрэлийн үйл ажиллагааг сонгоно уу?
A. Хүүхэн харааг өргөсгөнө
B. Хоол боловсруулах шүүрлийг багасгана
C. Зүрхний үйл ажиллагааг идэвхжүүлнэ
D. Гуурсан хоолойг өргөсгөнө
E. Гуурсан хоолойг нарийсгана

/124./ Цусны их эргэлтийн эхлэл төгсгөлийг сонгоно уу?
A. Баруун тосгуур баруун ховдол
B. Зүүн тосгуур зүүн ховдол
C. Зүүн ховдолоос баруун тосгуур
D. Баруун тосгуур зүүн ховдол
E. Зүүн тосгуур зүүн тосгуур

/125./ Арьсны дайварт аль нь хамаарагдах вэ?
A. Үс
B. Хумс
C. Тосны булчирхай
D. Хөлсний булчирхай
E. Сүүний булчирхай

/126./ Уртавтар тархинд амьсгал, зүрх судас зэрэг амьдралын чухал үйл ажиллагааг зохицуулдаг төвүүд байдаг. Иймээс уртавтар тархи гэмтвэл шууд үхэлд хүрнэ.

/127./ Чихний дэлбээ сонсох үйл ажиллагаанд яаж оролцох вэ?
A. Дууны долгионыг цуглуулна
B. Дууны долгионыг дамжуулна
C. Сонсох үйл ажиллагаанд оролцохгүй
D. Дууны долгионыг ялгана
E. Дууны долгионы хүчийг нэмэгдүүлнэ

/128./ Гөлгөр булчин ямар онцлогтой вэ?
1. Уян харимхай шинж чанартай
2. Энерги бага зарцуулна
3. Автомат шинж чанартай
4. Удаан ядрана
5. Үйл ажиллагааны нэгдмэл чанартай

/129./ Нойр булчирхайн цорго хаана нээгдэх вэ?
1. Нарийн гэдэсний өгсөх хэсэгт
2. Цөсний цоргонд

3. 12 хуруу гэдэсний уруудах хэсэгт
4. 12 хуруу гэдэсний өгсөх хэсэгт
5. Өлөн гэдсэнд

/130./ Харааны туслах эрхтэнд дараахаас аль нь орох вэ?
1. Зовхи
2. Алимны булчин
3. Нулимсны аппарат
4. Нулимсны булчирхай
5. Нүдний алим

/131./ Бээр гэж юуг хэлэх вэ?
A. Холбогч эдэд хуримтлагдсан идээ
B. Арьс руу нэвтрэн цоорсон идээ
C. Анатомийн хөндийд хуримтлагдсан идээ
D. Эрхтний ханаар тархсан идээ
E. Цул эрхтний идээ

/132./ Төлжлийн ерөнхий хэлбэрүүдийг сонгоно уу?
1. Сэргээлтийн төлжил
2. Эрүүл төлжил
3. Эмгэг төлжил
4. Цус үүсэх тогтолцооны төлжил
5. Мэдрэлийн төлжил

/133./ Хоргүй хавдрын шинжүүдийг сонгоно уу?
1. Дахидаггүй
2. Нягт тогтоцтой
3. Эдийн гажигшилтай
4. Богино хугацаанд ургадаг
5. Нэвчрэлтэт ургалттай

/134./ Хүүхдэд клиник үхэл ямар хугацаагаар үргэлжлэх вэ?
A. 1-3 минут
B. 2-4 минут
C. 3-5 минут
D. 5-7 минут
E. 8-10 минут

/135./ Жижиг судасны гэмтлийн үед хүйтэн жин тавих хугацааг сонгоно уу?
A. 10 мин
B. 15 мин
C. 20 мин
D. 25 мин
E. 30 мин

/136./ Донороос нэг удаа авч болох цусны хэмжээг тэмдэглэнэ үү?
A. 100-300 мл
B. 150-350 мл
C. 200-400 мл
D. 250-450 мл
E. 300-500 мл

/137./ Насанд хүрэгчдэд клиник үхлийн үеийн үргэлжлэх хугацааг тэмдэглэнэ үү?
A. 1-2 минут
B. 2-4 минут
C. 4-6 минут
D. 6-8 минут
E. 8-10 минут

/138./ Биеийн халуун 1 хэмээр нэмэгдэхэд судасны лугшилт хэдээр олшрох вэ?
A. 25
B. 20
C. 15
D. 10

E. 5
/139./ Хүний биеийн гадаргуугийн хэдэн % түлэгдэхэд биед ерөнхий өөрчлөлт гарах вэ?
A. 10%-иас дээш
B. 15%-иас дээш
C. 25%-иас дээш
D. 30%-иас дээш
E. 40%-иас дээш
/140./ Концентрацитай хүчлээр түлэгдсэн үед үзүүлэх анхны тусламжийг сонгоно уу?
A. Иодын сулруулсан хандаар угаах
B. Содын сул уусмал, хүйтэн усаар угаах
C. Ямар нэгэн тосон түрлэг хийх
D. 10 %-ийн давсны уусмалаар угаах
E. Ариун самбайгаар арчиж хуурайшуулах
/141./ Хэдэн хэмийн усаар хөлдсөн мөчийг гэсгээх вэ?
A. 10 хэм
B. 15 хэм
C. 20 хэм
D. 25 хэм
E. 30 хэм
/142./ Өтгөн хатаахгүйн тулд ямар хоолыг зонхилон хэрэглэх вэ?
A. Нүүрс усаар баялаг хоол
B. Уургаар баялаг хоол
C. Түүхий сүүний бяслаг
D. Илчлэг сайтай хоол
E. Өөх тос ихтэй хоол
/143./ Үйлчлүүлэгчид бодит үзлэг хийхдээ тэмтрэлтийг яаж хийх вэ?
A. Өвчтэй хэсгээс нь эхлэн аюулхай руу зөөлөн тэмтэрнэ
B. Хэвлийн баруун доод хэсгээс эхлэн зөөлөн тэмтэрнэ
C. Аюулхайгаас зөөлөн тэмтэрч дараа нь гүнзгий тэмтэрнэ
D. Эрүүл талаас нь өвчтэй хэсэг рүү шилжүүлэн зөөлөн тэмтэрнэ
E. Эрүүл хэсгээс эхлэн хэвлийн баруун хэсэг рүү тэмтэрнэ
/144./ Биологийн тохироо үзэхдээ 5 минутын зайтайгаар хийх нийт цусны хэмжээг сонгоно уу?
A. 25 мл
B. 35 мл
C. 45 мл
D. 55 мл
E. 65 мл
/145./ Хугарсан мөчинд чиг тавихдаа ямар зарчим баримтлах вэ?
A. Хугацаа алдалгүй боолт хийх
B. Гөлтгөнөн боолт яаралтай тавих
C. Хоёр талын үеийг оролцуулах
D. Өвдөлтийг хурдан намдаах
E. Цус алдалтаас сэргийлэх
/146./ Аль нь цээжний хөндийд цус хуралдах эмгэгийн нэршил вэ?
A. Пневмоторакс
B. Пиоторакс
C. Гемартроз
D. Гемоперитониум
E. Гемоторакс
/147./ Яаралтай журмаар хагалгаа хийх ходоодны эмгэгийг нэрлэнэ үү?
A. Ходоодны үрэвсэл
B. Ходоодны ур
C. Ходоод цоорох
D. Ходоодны шархлаа
E. Ходоодны хорт хавдар

/148./ Мухар олгойн үрэвслийн үед өвдөлт нь хаанаас эхлэх вэ?
A. Аюулхай хүйс орчмоос
B. Хэвлийн зүүн хэсгээс
C. Хэвлийн доод хэсгээс
D. Баруун хавирганаас
E. Бүсэлхий нуруунаас
/149./ Хавдрын оношийг баталгаажуулах шинжилгээний аргыг сонгоно уу?
A. Рентген зураг авах
B. Бодит үзлэг хийх
C. Хэт авиан шинжилгээ
D. Эд эсийн шинжилгээ
E. Дурангийн шинжилгээ
/150./ Яаралтай тусламжийн тодорхойлолтыг сонгоно уу?
A. Осол гэмтэл, өвчлөлийн үед эмнэлэгт яаралтай хэвтүүлэх арга хэмжээ
B. Осол гэмтэл, өвчлөлийг бүртгэж мэргэжлийн байгуулагад мэдээлэх арга
C. Осол гэмтэл, өвчлөлийн үед эмч ирэх, эмнэлэгт хүргэхээс өмнө үзүүлэх тусламж
D. Үйлчлүүлэгчид тусламжийг сувилахуйн 5 шатлалаар үзүүлэхийг хэлнэ
E. Амьсгал, зүрх судасны үйл ажиллагааг яаралтай дэмжих үйлдэл
/151./ Мушгиа болон түрүү хэлбэрийн боолт хийх боолтын материалыг сонгоно уу?
A. Гурвалжин алчуур
B. Самбай алчуур
C. Бинт
D. Гоюу
E. Даавуу
/152./ Боолт хийсэн мөчний цусан хангамжийг яаж шалгах вэ?
A. Эмчлүүлэгчээс асуух
B. Хумсан дээр дарж үзэх
C. Үеэр нь хөдөлгөж үзэх
D. Боолтоо хөдөлгөж үзэх
E. Мөчийг тэмтэрч үзэх
/153./ Аль нь өнгөц түлэгдэлтэнд хамаарах вэ?
A. Арьсны өнгөн давхарга түлэгдэх
B. Арьс, арьсан доорх өөхөн эд түлэгдэх
C. Булчин шөрмөс түлэгдэх
D. Яс түлэгдэх
E. 3б, 4-р зэргийн түлэгдэлт
/154./ Биеийн гадаргуугийн 9% тай тэнцэх хэсгийг тэмдэглэнэ үү?
A. Ууц нурууны хэсэг
B. Доод мөч тус бүрдээ
C. Их биений урд хэсэг
D. Толгой, хүзүүний хэсэг
E. Гарын алганы хэсэг
/155./ Ариутгасан бикстэй материалыг нээгээгүй үед ариун чанараа хадгалах хугацааг
A. 24 цаг
B. 48 цаг
C. 72 цаг
D. 96 цаг
E. 120 цаг
/156./ Ямар эрхтнээс цус алдвал хөөстэй цус гарах вэ?
A. Гэдэснээс
B. Ходоодноос
C. Уушгинаас
D. Улаан хоолойноос
E. Хамраас
/157./ Эмчлүүлэгчийг байрлалаар нь ангилна уу?
1. Идэвхитэй

2. Албадмал
3. Идэвхгүй
4. Хэвтрийн
5. Суугаа

/158./ Биеийн ямар хэсгүүдэд хаван үүсэх боломжтой вэ?
1. уц нуруу
2. Хөлийн шилбэ
3. Өгзөг
4. Зовхи
5. Хэвлийн урд хана

/159./ Эрүүл ахуйн химийн аргаар агаар, ус, хөрс, хүнсний бүтээгдэхүүний химийн найрлагыг судладаг учраас бие махбодод таагүй нөлөө үзүүлж болох бодис болон хүрээлэн буй орчинд нөлөөлж байгаа хорт бодисын агууламжийг судлах боломжтой.

/160./ Хүний биед цус ямар үүрэг гүйцэтгэх вэ?
1. Хамгаалах
2. Тэжээх
3. Ялгаруулах
4. Цус тогтоох
5. Амьсгалуулах

/161./ Цус юүлэхийн өмнө шалгаж үзэх тохироонуудыг сонгоно уу?
1. Резус
2. Хувийн
3. Биологийн
4. Бүлгийн
5. Сийвэнгийн

/162./ Цус гоожилтыг түр тогтоох аргуудыг сонгоно уу?
1. Даралттай боолт хиих
2. Үеэр нугалж боох
3. Судасны дээгүүр чангалуур тавих
4. Том судсан дээр хуруугаар дарах
5. Цус гарч байгаа мөчийг өргөх

/163./ Хагалгааны дараа өвчтний ам цанган, уруул нь омголтоход ямар сувилгаа хийх вэ?
1. Норгосон хөвөнтэй савхаар буйл тагнайг цэвэрлэх
2. Ам хамрын нүхэн дээр чийгтэй марль тавих
3. Урууланд вазелин түрхэх
4. Хэл дээр нь чийглэсэн самбай тавих
5. Бүлээсгэсэн шингэн ихээр уулгах

/164./ Хэвтрийн эмчлүүлэгчийг холголт цооролтоос сэргийлэх сувилгааг сонгоно уу?
1. Өдөрт 2-3 удаа байрлалыг өөрчлөн хэвтүүлэх
2. Дэвсгэр даавууг үрчлээсгүй, цэвэрхэн байлгах
3. Марлин, хийн, хөвөн цагираган жийргүүдийг тавих
4. Холгож болзошгүй хэсгүүдэд вазелин, камфор түрхэх
5. Удаан дарагдсан хэсэгт иллэг хийх

/165./ Боолт тогтоож болох материалуудыг сонгоно уу?
1. Бинт
2. Алчуур
3. Гоюу
4. Арьсны цавуу
5. Даавуу

/166./ Новокайны хоригийг ямар зорилгоор хийх вэ?
1. Тайвшруулах
2. Өвдөлт намдаах
3. Хэсгийн мэдээ алдуулах
4. Шокоос урьдчилан сэргийлэх

5. Халдвараас сэргийлэх

/167./ Ясны хугарлыг хугарлын шугамаар нь ангилна уу?
1. Хэлтэрсэн
2. Ташуу
3. Мушгирсан
4. Хөндлөн
5. Дагуу

/168./ Шархны үндсэн шинж тэмдгүүдийг нэрлэнэ үү?
1. Өвдөх
2. Шарх ангайх
3. Цус гоожих
4. Улайх
5. Хавдах

/169./ Хоргүй хавдар ямар шинж тэмдэгтэй вэ?
1. Хил хязгаар нь тодорхой
2. Гадууpаа гэр бүрхүүлтэй
3. Мэс заслын дараа дахидаггүй
4. Тунгалагийн булчирхайд үсэрхийлдэг
5. Хавдрын хэмжээ аажим томордог

/170./ Төрөлхийн гажиг, зэмдэг хөгжил ямар байдлаар тохиолдож болох вэ?
1. Тархины ивэрхийтэй
2. Сэтэрхий уруултай
3. Салаалсан умайтай
4. Сиамын ихэр
5. Майга тавхайтай

/171./ Эгэмний хугарлын үед ямар боолт хийх вэ?
1. Гарыг гурвалжин алчуураар сойж боох
2. Ситенкогийн цагираг хэрэглэж боох
3. Мөрний үеэнд түрүү хэлбэрийн боолт хийх
4. Наймын тоо хэлбэрийн боолт хийх
5. Цээжинд чагт хэлбэрийн боолт хийх

/172./ Ивэрхийн хагалгааны дараа хийгдэх сувилгааг сонгоно уу?
1. Хагалгааны дараа өвдөлт намдаах лаа хэрэглэх
2. Цус алдахаас сэргийлж шарханд хүйтэн жин тавих
3. Ханиахдаа шархны боолтон дээр зөөлөн дарахыг зөвлөх
4. Хушга, гуяны ивэрхийн хагалгааны дараа хуухнагт сойлт хийх
5. Эмчлүүлэгчийн тахиман дор ивээс хийж хэвтүүлэх

/173./ Ивэрхийг байрлалаар нь ангилна уу?
1. Хүйсний ивэрхий
2. Гуяны ивэрхий
3. Цавины ивэрхий
4. Хэвлийн цагаан шугамын ивэрхий
5. Хэвлийн ханын ивэрхий

/174./ Мэс заслын тусламж үйлчилгээний хэлбэрүүдийг сонгоно уу?
1. Эмнэлгийн анхан шатны тусламж
2. Ерөнхий мэс заслын тусламж
3. Төрөлжсөн нарийн мэргэжлийн тусламж
4. Салбар хэсэг нэгжид үзүүлэх тусламж
5. Мэс заслын өвчтөнд үзүүлэх тусламж

/175./ Зүрх зогссоноос хойш хэдэн минутын дараа тархинд эргэлтгүй өөрчлөлт гарах вэ?
A. 10 минутын дараа
B. 12 минутын дараа
C. 5 минутын дараа
D. 1-2 минутын дараа
E. Зүрх зогсмогц

/176./ Аврах амьсгалуулалтыг нэг удаад хэдэн секундын хугацаагаар хийх вэ?

A. 1 секунд
B. 2 секунд
C. 3 секунд
D. 4 секунд
E. 5 секунд

/177./ Цээж шахах үйлдлийг 1 минутанд хийх давтамжийн тоог тэмдэглэнэ үү?
A. 100 удаа
B. 90 удаа
C. 80 удаа
D. 60 удаа
E. 50 удаа

/178./ Орой, үзүүр, суурь, их биеэс тогтдог боолт хийх материалыг нэрлэнэ үү?
A. Уян бинт
B. Гурвалжин алчуур
C. Дөрвөлжилсөн марль
D. Цуулбар даавуу
E. Самбай алчуур

/179./ Хугарлын үед илрэх үндсэн шинжүүдийг сонгоно уу?
1. Цус хурж , үжилгүй үрэвсэл болсноос хавдах
2. Хөдөлгөөн байх ёсгүй хэсэгт эмгэг сул хөдөлгөөн үүсэх
3. Тэмтрэхэд хугархайн үзүүрүүд хавиралдаж мэдэгдэх
4. Тэр хэсгийн мэдрэлийн ширхэгүүд цочирсноос өвдөх
5. Хугархайн үзүүрүүд зөрснөөс мөч богиносох

/180./ Шархадсан хүн бүрт заавал хийх тарилгыг сонгоно уу?
A. Татрангийн эсрэг ийлдэс
B. Галзуугийн эсрэг вакцин
C. Хүний иммуноглобулин
D. Стафилакоккын хоргүйсүүр
E. Гамма глобулин

/181./ Татрангийн үүсгэгч нь газрын хөрсөнд удаан хугацаагаар хадгалагдан шархаар бие махбодид нэвтрэн өвчин үүсгэх чадвартай учир хөлдөлт , түлэгдэлт, шарх үүссэн үед татрангийн эсрэг ийлдэс тарина.

/182./ Тунгалагийн булчирхайн үрэвсэл нь ихэвчлэн хоёрдогчоор үүсэх учраас зүүн хөлийн тавхайд хатгагдсан шархтай эмчлүүлэгчийн цавины булчирхай нь томорч, өвдөх шинж илрэх боломжтой.

/183./ Исэлдүүлэгчийн бүлгийн бодисууд нь найрлагандаа хүчилтөрөгч агуулах учир агааргүй орчинд өсч үрждэг бичил биетнээр үүссэн халдварын үед өргөн хэрэглэнэ

/184./ Кариестэй шүд, гүйлсэн булчирхайн архаг үрэвсэл нь халдварын голомт учраас дотоод халдварын эх уурхай нь өвчтөн өөрөө болно.

/185./ Жирэмсэн эмэгтэйн мухар олгойн үрэвслийн үед томорсон умай гэдсийг дээш шахсанаас өвдөлтийн байрлал өөрчлөгдөх учраас эмэгтэйг хажуу талаар нь хэвтүүлэн үзлэг хийнэ.

/186./ Ивэрхий нь ердийн юмуу олдмол нүхээр хажуугийн хөндий рүү эсвэл арьсан дор шилжин гарах учраас гадна ивэрхий, дотор ивэрхий гэж ангилна.

/187./ Хэвлийн гялтангийн цочмог үрэвслийн гол шалтгаан нь мухар олгойн цочмог үрэвсэл учраас мухар олгойн цочмог үрэвслийн үед яаралтай хагалгаа хийхгүй бол бага аарцгийн хөндийн гялтангийн үрэвсэл үүснэ.

/188./ Ходоод, дээрх гэдэсний шархлаа хүндрэн хэвлийн хөндий рүү цоорч болох учраас агуулагдхуун нь хэвлийн хөндий рүү орж гялтангийн үрэвсэл үүсгэх ба рентгенд харахад өрцөн дор хадуур хэлбэрийн хий харагдана.

/189./ Зүрхний шигдээстэй өвчтөнд сувилгааны ямар зарчмыг баримтлах вэ?
1. Өлсгөхгүй, цатгахгүй өдөрт 5-6удаа хооллоно
2. Өвчтөнд өнжөөд цэвэрлэх клизм тавьж бие засуулна
3. Хэвтрийн дэглэм сахиулна
4. Холголт цооролтоос урьдчилан сэргийлнэ
5. Өвчнийх нь байдлыг нууцлана

/190./ Ханасан өөх тосыг хоногт эрэгтэй хүн хэдэн граммаас хэтрүүлэхгүй хэрэглэх ёстой вэ?
A. Насанд хүрсэн эрэгтэй хүн хоногт 30 граммаас
B. Насанд хүрсэн эрэгтэй хүн хоногт 20 граммаас
C. Насанд хүрсэн эрэгтэй хүн хоногт 10 граммаас
D. Насанд хүрсэн эрэгтэй хүн хоногт 40 граммаас
E. Насанд хүрсэн эрэгтэй хүн хоногт 50 граммаас
/191./ Амьдралын хэв маягийг өөрчлөхөд юу орох вэ?
1. Давсны хэрэглээг багасгах
2. Хөдөлгөөний идэвхийг нэмэх
3. Зохистой хоолны дэглэм барих
4. Жингээ бууруулах/барих
5. Архины зөв хэрэглээ
/192./ Эмчлүүлэгч 58 настай эмэгтэй ня-бо ажилтай биеийн жин 90 кг, өндөр нь 160 см өндөртэй хүний байх ёстой жинг олно уу?
A. 58,5 кг
B. 70,5 кг
C. 56.3 кг
D. 60.3 кг
E. 65.3 кг
/193./ Хүний БЖИ ээр хэмжихэд 1-р зэргийн таргалалтын хэмжээг нэрлэнэ үү
A. < 18.5 кг/м 2
B. 18.5-24.9 кг/м 2
C. 30-34.9 кг/м 2
D. 25-29.9 кг/м 2
E. 40 кг/м 2 -с дээш
/194./ Эмэгтэйчүүдийн өвчинд дараах эмгэгүүдийн аль нь орох вэ?
1. Биений юм хаагдах
2. Умайн хүзүүний үрэвсэл
3. Бэлгийн уруулын цагаарал
4. Биений юм өвдөлттэй ирэх
5. Бэлэг эрхтний унжилт
/195./ Жирэмсэн үед зохисгүй хооллох нь ураг, нярайд ямар нөлөөтэй вэ?
1. Өсөлт саатах, амьгүй болох
2. Бага жинтэй төрөх
3. Халдварт өртөмхий
4. Ургийн шингэн багасна
5. Урагт удамшлын эмгэг тохиолдох нь
/196./ Хэвийн үед үтрээний орчин ямар байх вэ?
A. Хүчиллэг
B. Шүлтлэг
C. Саармаг
D. Сул хүчиллэг
E. Сул шүлтлэг
/197./ Төрөх үеийн цус алдалтын эрүүл эмгэгийн заагийг тодорхойлно уу?
A. 80 мл
B. 100 мл
C. 150-300 мл
D. 400 мл
E. 500 мл
/198./ Эмэгтэйн нөхөн үржихүйн хамгийн тохиромжтой насыг заана уу?
A. 18-20 нас
B. 20-35 нас
C. 21-25 нас
D. 26-30 нас
E. 30-35 нас
/199./ Жирэмсний эргэлзээтэй шинжүүдийг нэрлэнэ үү?

1. Өглөөгүүр бөөлжих
2. Үнэрлэх мэдрэхүйн өөрчлөлт
3. Цочромхой, унтамхай болох
4. Хэвлийн цагаан шугам тодрох
5. Хоолны дуршил өөрчлөгдөх

/200./ Үтрээ ямар, ямар үүрэг гүйцэтгэдэг вэ?
1. Хамгаалах үүрэгтэй
2. Үр тогтолтонд оролцдог
3. Төрөх замын зөөлөн хэсэг болдог
4. Биений юмны цус дамжин гадагшилдаг
5. Умайн хүзүүний шүүрэл гадагшилна

/201./ Биений юмны мөчлөгийн өндгөвчийн үе шатыг хэлнэ үү?
1. Фолликул өсөж хөгжих
2. Овуляци
3. Шар бие үүсч хөгжих
4. Хуурах
5. Нөхөн төлжих

/202./ Ураг орчмын шингэн ямар ач холбогдолтой вэ ?
1. Ураг чөлөөтэй өсөж хөгжих, хөдлөх нөхцлийг бүрдүүлнэ
2. Ургийг гадаад орчны таагүй нөлөөнөөс хамгаална
3. Ургийн бодисын солилцоонд оролцоно
4. Умайн хүзүү нээгдэхэд тусална
5. Хүй дарагдахаас хамгаална

/203./ Ихсийн анатоми бүтцийг нэрлэнэ үү
1. Олон тооны салаалсан цэлмэнгүүдээс бүрдэнэ
2. Дугариг улаан саарал өнгөтэй
3. Зузаан нь 2-3 см. голч нь 15-18 см
4. 18-20 долькоос тогтоно
5. Махархуу бүтэцтэй

/204./ Хүй хэдэн судастай вэ?
1. 1 артери
2. 2 артери
3. 2 вен
4. 1 вен
5. 3 вен

/205./ Хөхүүл үе ямар онцлогтой вэ?
1. Бие махбодийн хөгжил өсөлт эрчимтэй явагдана
2. Сүүн шүд ургаж эхэлнэ
3. Хөдөлгөөний идэвх эрчимжинэ
4. Болзолт рефлексүүд үүснэ
5. Ясжилт эрчимтэй байна

/206./ Сүүн шүд хэдэн сараас эхлэн ургах вэ?
1. 5 сараас
2. 7-8 сард
3. 4 сараас
4. 6-7 сараас
5. 9 сараас

/207./ Хүүхдийн их зулай хэдийд битүүрдэг вэ?
A. 8 сартайд
B. 9-10 сартайд
C. 11-12 сартайд
D. 9 сараас 1,5 настайд
E. 1 насанд

/208./ Хөхөөр хооллож буй хүүхдийн өтгөн ямар байдаг вэ?
1. Алтлаг шар өнгөтэй
2. Исгэлэн үнэртэй

3. Нялцгайвтар
4. Тогтворгүй
5. Эвгүй үнэртэй

/209./ Хүүхдэд чийрэгжүүлэлт хийхэд баримтлах зарчим
1. Тухайн хүүхдийн хувийн онцлогт тохируулан хийх
2. Дасгалыг эрүүл байгаа үед нь эхлэх
3. Чийрэгжүүлэх дасгалыг багаас их рүү
4. Хөнгөнөөс нарийн руу аажим шилжүүлэх
5. Тогтмол хийх

/210./ Олон найрлагат бичил тэжээлийн бэлдмэл нь бага насны хүүхдэд өгснөөр ямар ач холбогдолтой вэ?
1. Бичил тэжээлийн дутал, түүн дотроос цус багадалт, цайрын дутлаас сэргийлнэ
2. Хүүхдийн нэмэгдэл хоолны чанрыг сайжруулан хоолны дуршлыг нэмэгдүүлнэ
3. Биеийн эсэргүүцлийг сайжруулах
4. Хүүхдийн өсөлт хөгжилтийг сайжруулах
5. Хүүхдийн оюун ухааны хөгжлийг сайжруулах

/211./ Дутуу нярайн гадаад шинжийг тодорхойлно уу?
1. Мөчүүд харьцангуй урт
2. Дух нүүрний хэсгээс том
3. Хүйс дор байрлалтай, умдагт ойрхон
4. Чихний мөгөөрс зөөлөн, хэлбэржээгүй, толгойд наалдсан
5. Арьс нь үрчгэр улаан

/212./ Нярайн сувилгаанд юу анхаарах вэ?
1. Өрөөг цэвэр байлгах
2. Гараа сайн угаах
3. Өрөөнд олон хүн орохыг хориглох
4. Гэрэлтүүлэг, агааржилт сайтай байх
5. Өрөө дулаан байх

/213./ Нярайг төрмөгц дулаан алдалтаас яаж сэргийлэх вэ?
1. Хуурайшуулах
2. Имж арга
3. Дулаан өрөөнд байлгах
4. Хөхөөр хооллох
5. Дулаацуулах төхөөрөмж ашиглах

/214./ Нярайг төрөхөөс гармагц идэвхтэй эргэлтийг хэзээ хийх вэ?
A. 24 цагийн дотор
B. 12 цагийн дотор
C. 15 цагийн дотор
D. 24-72 цагийн дотор
E. 3 хоногийн дараа

/215./ Дараах шинжүүдээс аль нь илэрвэл эмнэлэгт яаралтай хэвтүүлэх вэ?
A. 14 хоногоос дээш ханиалгах
B. Халуурах
C. Амьсгал олшрох
D. Цустай цэр гарах
E. Цээж хонхолзох

/216./ Шингэн алдалтыг хэрхэн үнэлдэг вэ?
1. Хэр удаан, баасанд нь цус байна уу? гэж асуух
2. Хүүхдийн ерөнхий байдлыг ажиглах
3. Нүд хонхойсон эсэхийг ажиглана
4. Хүүхдэд шингэн өгөх
5. Хэвлийн арьсыг чимхээд тавихад арьсны хуниас арилах

/217./ Рахитын эхлэл үед ямар шинж илрэх вэ?
1. Цочромтгой болох
2. Шээс үнэртэй гарах
3. Хөлрөх

4. Нуруу муруйх
5. Сампингийн эрхийн шинж

/218./ А аминдэмийг ямар зорилгоор хэрэглэдэг вэ?
1. Улаан бурханы эмчилгээнд
2. Хүнд тураалын эмчилгээнд
3. А аминдэмийн дутлаас сэргийлэх зорилгоор
4. Рахитын эмчилгээнд
5. Цус багадалтын сэргийлэлтэнд

/219./ Хүчилтөрөгч өгөх үед анхаарах зүйл юу вэ?
1. Хүчилтөрөгч өгөхийн өмнө амьсгалын замыг чөлөөлөх
2. Хүчилтөрөгч авч байгаа хүүхдийг пульсоксиметрээр байнга хянах
3. Хүчилтөрөгчийн дамжуулах гуурсыг 72 цаг болоод солих
4. Хүчилтөрөгчийн урсгал болон гуурсыг 15 минут тутамд шалгах
5. Пульсоксиметрээр3 цаг тутам хөл, гарт ээлжлэн солих

/220./ Хүүхдэд эм өгөхөд анхаарах зүйл юу вэ?
1. Нэг дор 2-3 өөр төрлийн эм өгөхгүй байх
2. Сайтар нухаж бэлтгээгүй бүхэл, ширхэгтэй эм өгөхгүй байх
3. Хооллохоос өмнө эсвэл дараа уулгах заалтыг анхаарах
4. Эм өгсний дараа хүүхдэд хариу урвал илрэх эсэхийг ажиглах
5. Хүүхэд хахаж цацах, бөөлжих зэргийг анхаарч ажиглан эхэд зөвлөх, хэлэх

/221./ Дутуу нярайн өрөөний дулаан хэдэн хэм байх вэ?
A. 15 – 18 хэм
B. 18 - 20 хэм
C. 20 -22 хэм
D. 22- 24 хэм
E. 25 хэм

/222./ Рахитын өвөрмөц бус сэргийлэлт
1. Хүүхдийг хөхөөр хооллох
2. Нар агаарт гаргаж байх
3. Усанд тогтмол оруулах
4. Аминдэм Д уулгах
5. Аминдэм А уулгах

/223./ Рахитын өвөрмөц сэргийлэлт гэж юу вэ?
A. Нар агаарт гаргах
B. Д аминдэм уулгах
C. Усанд тогтмол оруулах
D. Хөхөөр хооллох
E. Иллэг хийх

/224./ Шүүдэст эмзэгшил үүсэхэд нөлөөлдөг хүчин зүйл
A. Хүүхдийг хөхөөр хооллосноос
B. Нэмэгдэл хоол эрт өгсөнөөс
C. Эх, харшил үүсгэх бүтээгдэхүүн хэрэглэснээс
D. Жимс, хүнсний ногоо хэрэглэснээс
E. Тэжээвэр болгосноос

/225./ Чихний цочмог халдварын үед ямар шинж илрэх вэ?
1. Чихний ард хавдсан, хөндүүр
2. Чих өвдсөн
3. Чихнээс булаг харагдах ба 14 хоногоос удаан гоожсон
4. Чихнээс булаг гараад 14 хоноогүй
5. Халуурсан

/226./ Цагаан хорхойтсон бол эмчилгээг тогтоож зөвлөгөө өгнө үү?
1. Мебендазол өгнө
2. Мультивитамин өгнө
3. Эрүүл ахуйн зөвлөгөөг өгнө
4. 30 хоноод давтан үзүүлнэ
5. 14 хоноод давтан үзүүлнэ

/227./ Тураалтай хүүхдэд ямар сувилгаа хийх вэ?
1. Өдрийн дэглэм зөв баримтлах
2. Зөв зохистой хооллох
3. Шалтгааныг илрүүлж арилгах
4. Аминдэм уулгах
5. Иллэг хийх

/228./ Хүүхдэд сувилгааны оношийг юуг үндэслэж тавих вэ?
1. Биеийн байдал
2. Зовиур
3. Айдас
4. Шалтгаан
5. Төлөвлөгөөг

/229./ Хүүхдэд хүчилтөрөгч өгөх заалтыг тодорхойлно уу?
1. Төвийн хөхрөлт
2. Цээж хүчтэй хонхолзох
3. Амьсгалын тоо 60-аас олон болох
4. Тайван бус цочромтгой болох
5. Ханиалгах

/230./ Хүүхдэд цэвэрлэх бургуй тавих үед ямар хүндрэл гарч болох вэ?
1. Бургуй тавих усны халуун бүлээнийг тохируулагүйгээс цочрол үүсэх
2. Баллоны хошууг сайн тослоогүйгээс салстыг гэмтээх
3. Тавих усны хэмжээг тохируулаагүйгээс хүндрэл гарах
4. Хүүхдийн гэдсэнд хий оруулах
5. Хүүхэд халуурах

/231./ Усан суулгалт гэж юу вэ?
A. Баасны тоо олширох
B. Хоногт 3 ба түүнээс дээш устай суулгах
C. Эмгэг хольцтой гарах
D. Баас шингэрч, бөөлжих
E. Хоногт 3-аас дээш баах

/232./ Ужиг суулгалт гэж юу вэ?
A. Баасны тоо олшрох
B. 14 хоногоос удаан суулгах
C. Эмгэг хольцтой баах
D. Баас шингэрч, бөөлжих
E. Хоногт 3-аас дээш устай суулгах

/233./ Монгол хүүхдийн биеийн цул эхний 6 сард хэдэн гр-аар нэмэгдэх èстой вэ?
A. 400 гр
B. 500 гр
C. 600 гр
D. 700 гр
E. 800 гр

/234./ Усан суулгалтын уршиг юу вэ?
1. Баасаар их хэмжээний эрдэс бодисууд алдагддаг
2. Баасаар их хэмжээний ус алдагддаг
3. Баасаар шимт бодис алдагдана
4. Баасаар зөвхөн ус л алдагдана
5. Баасаар зөвхөн давс алдагдана

/235./ Сэтгэцийн өвчтэй хүн гэж хэнийг хэлэх вэ?
A. Нийгэм сэтгэлзүйн гаралтай, түр зуурын хямралд өртсөн хүнийг
B. Оюуны хомсдол өвчтэй хүнийг
C. Биемахбодийн өвчингүй боловч сэтгэцийн өөрчлөлт бүхий хувь хүнийг
D. Өвчний олон улсын ангиллын хэмжүүрээр онош тавьж болохуйц өвчтэй хүнийг
E. Сэтгэцийн өөрчлөлт бүхий хувь хүнийг

/236./ Сэтгэцийн хувьд эрүүл хүмүүс нь сэтгэцийн эрүүл мэндийн сэргийллийн ямар түвшинд хамаарах вэ?

A. СЭМ-н дөрөвдөгч сэргийлэлт
B. СЭМ-н гуравдагч сэргийлэлт
C. СЭМ-н хоёрдогч сэргийлэлт
D. СЭМ-н анхдагч сэргийлэлт
E. СЭМ-н урьдчилан сэргийлэлт

/237./ Нийгэмд аюултай үйлдэл хийж болзошгүй өвчтөн гэж хэнийг хэлэх вэ?
A. Нийгэм, хамт олонтой дасан зохицох чадвар муутай
B. Хурц солиоролтой өвчтөн
C. Нойргүйдэлтэй өвчтөн
D. Айдастай өвчтөн
E. Сэтгэл түгшилтэй өвчтөн

/238./ Оюуны хомсдолтой хүмүүст аль хандлага нь заавал хэрэгтэй вэ?
A. Оюун ухааныг сайжруулах эмийн эмчилгээ
B. Ад шоо үзэхгүй байх
C. Тусгай сургуульд суралцуулах
D. Амьдрах ур чадвар эзэмшүүлэх
E. Гэр бүлийнхний асрамжинд байлгах

/239./ Сэтгэцийн өвчтэй гэдэг нь бүрэн батлагдсан өвчтөнд ямар арга хэмжээ авах вэ?
1. Нийгэм хамт олны дунд эмчлэхийг эрмэлзэнэ
2. Сэтгэцийн эмчийн хяналтанд байлгана
3. Шаардлагатай үед сэтгэцийн эмнэлэгт хэвтүүлнэ
4. Нийгмээс тусгаарлана
5. Байнгын эмнэлэгт байлгах

/240./ Дараах сэтгэцийн өвчнүүдээс сэтгэцийн яаралтай тусламж шаарддаг байдлыг нэрлэнэ үү?
1. Хурц солиорол
2. Гүнзгий сэтгэл гутрал
3. Догшрол
4. Архинд донтох
5. Айдастай өвчтөн

/241./ Сэтгэцийн эмгэгтэй хүмүүс ямар нөхцөлд нийгэмд аюултай үйлдэл хийх магадлал өндөр байдаг вэ?
1. Өвчин дахих хөдлөх үед
2. Өвчин хурцдах буюу сэдрэх үед
3. Сэтгэцийн нэг болон хэд хэдэн шинж нөгөөгөөр солигдох үед
4. Өвчний хурц үе намжих үед
5. Харьцангуй сайжрал авсан үед

/242./ Амиа хорлох хандлагатай өвчтөнд хийх сувилахуйг нэрлэнэ үү?
1. Өвчтөний бие болоод сэтгэцийн байдлыг сайн мэдэж байх
2. Өвчтөнг ганцааранг орхиж хэрхэвч болохгүй
3. Орондоо хэвтэж байгаа тохиолдолд толгойг нь үргэлж ил байлгах
4. Тарианы өрөөг эзэнгүй онгорхой орхихгүй байх, эмийг цоожтой саванд хадгалах
5. Өвчтөнг оронд нь даруулгатай байлгах

/243./ Сэтгэцийн өвчтөнд эм олгоход заавал баримтлах зарчмуудыг нэрлэнэ үү?
1. Эмийг нухаж бэлтгэнэ
2. Эмийг сувилагч заавал өөрийн гараар өвчтөний аманд хийнэ
3. Эмийг 37 С бүлээн усаар даруулж уулгана
4. Эм уусаны дараа өвчтөний амыг заавал шалгана
5. Эм ууснаас хойш 30 минут өвчтөнг хянах

/244./ Догширсон өвчтөнийг машинд суулгах ба нэг тасгаас нөгөө тасагт шилжүүлэн зөөвөрлөхөд ямар арга барилыг хэрэглэж болох вэ?
1. Өвчтөнийг хоёр сувилагч 2 талаас нь сугадаж бие рүүгээ шахаж авч явах
2. Өвчтөнөө дамнуурга дээр хэвтүүлж орны даавуугаар цээж, өвдөгний тус газраар боолт хийж эсвэл хөнжилд нь өлгийдөж дамнуургаар авч явна
3. 3 хүний оролцоотой өвчтөнийг авч явах
4. Дамнуурга дээр хэвтүүлж зөөвөрлөх

5. Өөрөөр нь явуулж зөөвөрлөх
/245./ Сэтгэцийн өвчтөнд шөнийн цагт хяналт явуулахад баримтлах зарчим юу вэ?
1. Өвчтөнийг толгой дээгүүр нь хөнжил нөмрүүлэхгүй байх
2. Палатны үүдийг онгорхой байлгах
3. Өвчтөнүүдийг байнга хянаж, унтаж буй эсэхийг шалгах
4. Ерөнхий гэрэлтүүлэгтэй байх
5. Палатны гэрлийг асаалттай байлгах
/246./ Саа саажилтай өвчтөнийг сувилагч хэрхэн оношлох вэ?
1. Өвчтөнөөр дөрвөн мөчийг өөрөөр нь хөдөлгөх
2. Саа саажилт байгаа эсэхийг ажиглах
3. Булчингийн хүчдэлийг сувилагч өөрөө хөдөлгөж шалгах
4. Өвчтөний дөрвөн мөчийг сувилагч өөрөө хөдөлгөж шалгах
5. Булчингийн хүчдэлийг өөрөөр нь хөдөлгөж шалгах
/247./ Бүсэлхий нуруугаар өвдөх өвдөлт ямар тохиолдолд сэдэрдэг вэ?
1. Хүнд юм өргөх
2. Эвгүй огцом хөдлөх
3. Даарч хөрөх
4. Эвтэй байдалд удаан суухад
5. Хэт удаан суух
/248./ Цээжээр өвдөх өвдөлтийн байрлалын шинжийг нэрлэнэ үү?
1. Өвдөлт дал хооронд байрлах
2. Хавирга хооронд дарахад эмзэглэлтэй
3. Хавирга руу дамжиж өвдөх
4. Ханиах найтаахад сэдэрнэ
5. Ханиах найтаахад эмзэглэлтэй
/249./ Цус харвалттай өвчтөнд ямар сувилгаа шаардлагатай вэ?
1. Өвчний эхэн үед хаймсуураар шингэн хоол өгөх
2. Давс, өөх тосыг хязгаарлах
3. Хоолыг хэт халуун өгөхгүй байх
4. Хоолыг бага багаар бэлтгэх
5. Эслэг ихтэй хоол хүнс хэрэглэх
/250./ Нугасны эмгэгтэй өвчтөний байрлал ба хөдөлгөөний сувилгааг нэрлэнэ үү?
1. Хэвтээ болон суугаа байрлалд ойрхон солих
2. Цооролтоос сэргийлэх
3. Ивээс зөөлөвчийг байнга хэрэглэх
4. Үе мөчинд иллэг идэвхтэй хөдөлгөөн хийх
5. Гутал нь үдээгүй өмсөхөд хялбар байх
/251./ Уналт таталт өвчин үүсэх хүчин зүйлсийг нэрлэнэ үү?
1. Хүүхдийн халуурaлтын сууринд үүсэх таталт
2. Тархины органик эмгэг
3. Тархины үйл ажиллагааны байдал
4. Удамын хүчин зүйл
5. Гематомын суурин дээр
/252./ Сувилахуйн тусламж үйлчилгээний чанар гэж юуг хэлэх вэ?
A. Аливаа үйл ажиллагаа зорилгоо биелүүлэх үйл явцыг хэлнэ.
B. Аливаа зорилт нь амжилтаар баталгаажих үйл явцыг хэлнэ.
C. Нийгэм болон бие хүний хэрэгцээг хангах үйл явцыг хэлнэ.
D. Үйлчлүүлэгчийн сэтгэл зүйн онцлог, эрүүл мэндийн түвшинг хэлнэ.
E. Үйлчлүүлэгчийн эрэлт хэрэгцээ бүрт үзүүлсэн тусламж үйлчилгээгхэлнэ.
/253./ Сувилахуйн тусламж үйлчилгээний чанарыг тодорхойлдог гол үзүүлэлтийг нэрлэнэ үү?
A. Үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж өндөр байх
B. Үйлчлүүлэгчдэд шуурхай үйлчилгээтэй байх
C. Үйлчилгээний нэр төрөл олон байх
D. Үйлчилгээний үнэ зохистой байх
E. Мэргэжилтний тоо хүрэлцээтэй байх
/254./ Сувилахуйн манлайлалын тодорхойлолтыг сонгоно уу?

A. Манлайлал нь бусдад нөлөөлөх чадварыг нэмэгдүүлэхийг хэлнэ.
B. Манлайлал нь бусдыг удирдан чиглүүлэн өмнө нь явахыг хэлнэ
C. Манлайлал нь бие хүн өөрийнхөө зорилгыг биелүүлэхийг хэлнэ.
D. Манлайлал нь бусдад үлгэр дууриал үзүүлэх үйлдлийг хэлнэ.
E. Манлайлал нь заавал гүйцэтгэх естой үүрэг хариуцлагыг хэлнэ.

/255./ Сувилахуйн үйл ажиллагааны аль шатлалын үед сувилагчийн оролцоог тодорхойлох вэ?
A. Оношлох
B. Төлөвлөгөө боловсруулах
C. Хэрэгжүүлэх
D. Үнэлгээ өгөх
E. Дүгнэлт хийх

/256./ Өрхийн эмч, сувилагч нар харъяалагдах нутаг дэвсгэрийнхээ хүн амыг эрүүл мэндийн байдлаар нь хэдэн бүлэгт хуваан үйл ажиллагаа явуулдаг вэ?
1. Эрүүл
2. Харьцангуй эрүүл
3. Ээнэгшил бүхий архаг өвчтэй
4. Хагас ээнэгшил бүхий архаг өвчтэй
5. Ээнэгшлээ алдсан архаг өвчтэй

/257./ Өрхийн сувилагчийн үйл ажиллагааг нэрлэнэ үү?
1. Үйлчлүүлэгчийн хэрэгцээнд нийцсэн тусламж үйлчилгээ үзүүлэх
2. Гэрийн идэвхтэй эргэлт хийх
3. Хөтлөгдвөл зохих бичиг баримт хөтлөх
4. Дархлаажуулах үйл ажиллагаанд оролцох
5. Эрсдэлт бүлгийн хүмүүсийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах

/258./ Сувилагчийн үндсэн үүргийг тодорхойлно уу?
1. Эрүүл мэндийг дэмжих
2. Өвчнийг илааршуулахад чин сэтгэлээсээ хандах
3. Эмчлүүлэгчид сэтгэл санааны дэмжлэг үзүүлэх
4. Зовлон зүдгүүрийг багасгаж, хөнгөлөх
5. Эрүүл мэндийг сэргээх

/259./ Багаар ажилласны үр дүнд ямар чадваруудыг эзэмших вэ?
1. Харилцааны ур чадвар эзэмших
2. Сэтгэн бодох, шийдвэр гаргах ур чадвар эзэмших
3. Хамтран ажиллах ур чадвар эзэмших
4. Унших, бичих ур чадвар эзэмших
5. Удирдан манлайлах ур чадвар эзэмших

/260./ Эмчлүүлэгчдэд ажиглалт хийх зорилго нь эмчлүүлэгчийн биеийн байдалд үнэлэлт өгч сувилгааны тактик боловсруулах бөгөөд хүндрэлээс урьдчилан сэргийлэхэд чиглэгддэг.

/261./ Хэрэгцээний эрэмбийн шатлалыг тохируулан сонгоно уу.
1. Маслоугийн хэрэгцээний 1 шат
2. Маслоугийн хэрэгцээний 2 шат
3. Маслоугийн хэрэгцээний 3 шат
4. Маслоугийн хэрэгцээний 4 шат
5. Маслоугийн хэрэгцээний 5 шат
A. Хайрлах, хүндлүүлэх хэрэгцээ
B. Өөрийгөө илэрхийлэх хэрэгцээ
C. Физиологийн хэрэгцээ
D. Аюулгүй байх хэрэгцээ
E. Нийгмийн хэрэгцээ
A. 1A 2B 3C 4D 5E
B. 2A 3B 4C 5D 1E
C. 3A 4B 5C 1D 2E
D. 4A 5B 1C 2D 3E
E. 5A 1B 2C 3D 4E

/262./ “Нийгмийн эрүүл мэнд” нь ямар ойлголт вэ?

A. Тодорхой хүмүүс хамт олны эрүүл мэндийн асуудлыг хамруулах
B. Эрүүл мэндийн тодорхой чиглэлтэй үйл ажиллагаа явуулах
C. Хүний эрүүл мэндэд нөлөөлөх тодорхой хүчин зүйлд чиглүүлэх
D. Эрүүл мэндийн асуудлыг бүхэлд нь иж бүрнээр нь авч үзэх
E. Өвчлөлийн байдалд судалгаа хийх үйл ажиллага

/263./ Эрүүл энх байдлын талаархи зах зээлийн сэтгэлгээ хүмүүсийн юунд эхэлж бүрэлдэх нь оновчтой бэ?
A. Ахуйн орчинд
B. Оюун ухаанд
C. Нийгмийн амьдралд
D. Эдийн засагт
E. Ажлын байранд

/264./ Хүн эрүүл, амьдралын өндөр чадавхитай, урт наслах асуудлуудыг хэдийнээс эхлэн хэрэгжүүлэх ёстой вэ?
A. Хүүхэд наснаас
B. Залуу үеэс
C. Нас тогтсон үеэс
D. Жирэмсэн үеэс
E. Тэтгэвэрт гарсан үеэс

/265./ Нийгмийн эрүүл мэндийн хөгжил нь юунд чиглэгдэх вэ?
A. Хүн амын эрүүл аж төрөх ёсыг дээшлүүлэхэд
B. Хүн амын өвчлөлийг багасгахад
C. Хүн амын амьдралын чанарыг дээшлүүлэхэд
D. Хүн амын эрүүл мэндийг дэмжихэд
E. Хүн амын хөдөлмөрийн чадварыг нэмэгдүүлэхэд

/266./ Эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг чиглүүлэх хамгийн оновчтой байдлыг нэрлэнэ үү?
A. Хувь хүнд
B. Бие хүнд
C. Хамт олонд
D. Улс нийгэмд
E. Гэр бүлд

/267./ Эрүүл мэндийн даатгалын тогтолцоонд баримтлах зөв чиглэл нь юу вэ?
A. Даатгал нь зөвхөн өвчлөгсдөд ашигтай байх
B. Даатгал нь зөвхөн эмнэлгийн байгууллагад ашигтай байх
C. Даатгал нь нийт хүмүүст ашигтай байх
D. Даатгал нь нийгэмд ашигтай байх
E. Даатгал нь тухайн хамт олонд ашигтай байх

/268./ Нийгмийн эрүүл мэндийн бодлогод баримтлах хамгийн чухал чиглэл нь юу вэ?
A. Ажиллаж амьдрах таатай орчинг бүрдүүлэх
B. Хүний эрүүл мэндээ хамгаахлах чадварыг хөгжүүлэх, эрүүл мэндийн боловсрол олгох
C. Эрүүл мэндийг дэмжин эрүүл зан үйлд сургах
D. Хорт зуршлаас зайлсхийх, идэвхитэй хөдөлгөөнийг дэмжих
E. Эрүүл байх талаар мэдлэг эзэмшүүлэ

/269./ Халдварт өвчлөлөөс сэргийлэх идэвхит арга хэмжээг нэрлэнэ үү?
A. Чийрэгжүүлэлт
B. Дархлаажуулалт
C. Ахуйн соёлжилт, эрүүл орчин
D. Эрүүл мэндийн боловсрол
E. Эрүүл мэндийг дэмжих зан үйл

/270./ Нийгмийн эрүүл мэндийн үйл ажиллагаанд хамгийн чухал үзүүлэлт юу вэ?
A. 10000 хүн тутамд ноогдох эмнэлгийн ажилтны тоо олон байх
B. Нэг хүнд ноогдох цэвэр ус, хүнсний бүтээгдэхүүн хүртээмжтэй байх
C. Эдийн засгийн чадавхитай байдал
D. Өрхийн ам бүл цөөн байх
E. Эмнэлгийн орны тоо олон байх

/271./ Нийгмийн эрүүл мэндийн анхан шатны тусламжийн зорилго нь юу вэ?
A. Амьдралын чанарыг дээшлүүлэх
B. Өвчлөлийн хоёрдогч, гуравдагч сэргийлэлт
C. Эмнэлгийн ерөнхий ба нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээ
D. Хөдөлмөрийн чадварыг нь сэргээх
E. Эмчлэн эрүүлжүүлэх
/272./ Өргөн утгаараа нийгмийн эрүүл мэндийн анхан шатны тусламжийг хэнд үзүүлэх вэ?
A. Малчдад
B. Эх нялхаст
C. Бүх хүн амд
D. Хүн амын эмзэг хэсэгт
E. Өндөр настанд
/273./ Хүн ардыг нийтээр нь эрүүл байлгах хамгийн оновчтой арга нь юу вэ?
A. Хүмүүсийн бухимдал /стресс/-ийг тайлах
B. Нийгэм эдийн засаг дахь ядуурлыг бууруулах
C. Эрүүл мэндийн асуудлыг төр, эмнэлгийн байгууллагад найдах
D. Эрүүл мэндийн анхан шатны тусламжаар хангах
E. Эрүүл зан үйл, зөв хэвшилд ард иргэдээ сургах
/274./ Нийгмийн эрүүл мэндийн наад захын хэрэглээг нэрлэнэ үү?
1. Аюулгүй байдал
2. Хөдөлмөр, биеийн тамир
3. Эрүүл мэндийн хүмүүжил боловсрол
4. Эмнэлгийн үйлчилгээ, эм тариа
5. Архи тамхины хэрэглээ
/275./ Эрүүл мэнд байдлын үндэс нь юу вэ?
1. Өв уламжлал
2. Нийтийн биеийн тамир
3. Ёс суртахуун
4. Эрүүл мэндийн боловсрол
5. Зан заншил
/276./ Эрүүл гэдэг ойлголт нь
1. Биед ямар нэг өөрчлөлтгүй байхыг хэлнэ
2. Эрхтэн системүүд нь бүрэн бүтэн байгааг хэлнэ
3. Бие бялдар оюун санааны өв тэгш хүмүүжлийг хэлнэ
4. Эрхтний үйл ажиллагаа гадаад орчинтойгоо бүрэн зохицсон байдлыг хэлнэ
5. Нийгэм ахуйн өв тэгш, эсэн мэнд байдлыг хэлнэ
/277./ Өвчлөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлийн үндсэн ажлуудыг нэрлэнэ үү?
1. Эрүүл мэндийн сургалт сурталчилгаа
2. Ариун цэврийн урьдчилсан ба байнгын хяналт
3. Халдварт өвчлөлөөс сэргийлэх ажил
4. Оновчтой сувилан эмчлэх
5. Өвчлөлийн тархалтын хүрээг тогтоох
/278./ Нийгмийн эрүүл мэндийн анхан шатны тусламжуудыг нэрлэнэ үү?
1. Хүмүүст эрүүл мэндээ хамгаалах мэдлэг олгох
2. Нэн шаардлагатай эмээр хүн амыг хангах
3. Халдварт өвчлөлөөс сэргийлэх тарилга хийх
4. Эмнэлгийн ерөнхий ба нарийн мэргэжлийн тусламж
5. Мэс ажилбар хийх
/279./ Нийгмийн эрүүл мэндийн анхан шатны тусламжуудыг нэрлэнэ үү?
1. Гэр бүл төлөвлөлтийн арга хэмжээ
2. Ундны цэвэр усны хангамж
3. Нутагшмал байдлаар илэрдэг өвчлөлөөс сэргийлэх
4. Зохистой хоол хүнсээр хангах
5. Хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох
/280./ Нийгмийн эрүүл мэндийн анхан шатны тусламж үзүүлэхэд баримтлах зарчмуудыг нэрлэнэ үү

1. Эрүүл мэндийн анхны тусламж нь өргөн олныг хамарсан байх
2. Тусламж энгийн хялбар технологитой байх
3. Тусламж үзүүлэхэд орон нутгийн нөөц бололцоог ашиглах
4. Амьдралын чанарыг дээшлүүлэх
5. Салбар хоорондын хамтын ажиллагаанд тулгуурлах

/281./ Өвчлөлөөс анхдагч сэргийлэлтэнд хамаарах асуудлуудыг нэрлэнэ үү?
1. Соёлч боловсон цэвэрч дадал хэвшил
2. Эрүүл мэндийн боловсрол сайтай байдал
3. Хүмүүжил, ухамсартай байда
4. Амьдарч ажиллаж буй орчны цэвэр байдал
5. Байгаль орчны цэвэр байдал

/282./ Эрүүл байхын тулд хүн бүр заавал хэвшүүлэх зүйлс юу вэ?
1. Гимнастикийг тогтмолжуулах
2. Өдөр бүр 10000-аас доошгүй алхах /6-10км/
3. Биед тогтмол ачаалал өгч жин, өндрийн харьцаагаа хянах
4. Нар усаар биеэ чийрэгжүүлэх
5. Амьдралын эерэг зан үйл эзэмшисэн байх

/283./ Эрүүл мэндийн сургалт сурталчилгааны ажлын эцсийн үр дүнг үнэлэх үндсэн үзүүлэлтүүд юу вэ?
1. Сургалт сурталчилгааны ажилд хамрагдсан хүний тоо
2. Халдварт өвчлөлийн тууштай бууралт
3. Өвчлөлийн байдлыг тодорхойлох
4. Хүн амын ариун цэвэр, соёлын түвшингийн дээшлэлт
5. Эмнэлгийн үзлэгийн дүн мэдээ сайжрах

/284./ Ундны усны зөв хэрэглээг бий болгоход анхаарах зүйл юу вэ?
1. Уух усыг буцалгаж хэрэглэж занших
2. Усны эх булгийг зөв сонгох
3. Усны савны багтаамж, цэвэрлэгээг анхаарах
4. Усны хэрэглээний эрүүл ахуйн нормыг хангах
5. Унды устай харьцах зөв зан үйлийг хэвшүүлэх

/285./ Ундны ахуйн хэрэглээний усыг бохирдолтоос хамгаалах арга хэмжээг нэрлэнэ үү?
1. Цэвэр усыг тээвэрлэх явцад хяналт тавьж халдваргүйжүүлэх
2. Унды усыг байнга буцалгаж хэрэглэх
3. Ус зөөх, хадгалах савнуудын цэвэр байдлыг хангах
4. Ус түгээх худгуудыг цөөрүүлэх
5. Ус түгээх байгууламжуудыг олшруулах

/286./ Хүмүүсийн “эрүүл мэнд”-ийн байдалд нөлөөлж буй хүчин зүйлсийг уялдуулан сонгоно уу?

A.Амьдралын хэв маяг B. Хүрээлэн байгаа орчин C.Удамшил D. Эрүүл мэндийн үйлчилгээ
1. 24 %
2. 10 %
3. 50 %
4. 16 %

A. A1 B3 C2 D4
B. A2 B4 C3 D1
C. A3 B1 C4 D2
D. A4 B2 C1 D3
E. A1 B2 C3 D4

/287./ Эрүүл мэндийн эрэлтийн хэлбэрүүдийг уяалдуулан сонгоно уу?

A. Хангагдсан эрэлт B. Онцгой эрэлт C. Сөрөг эрэлт D. Зохисгүй эрэлт
1. Эрхтэн шилжүүлэх 2. Хорт эмийн зуршил 3. Вакцинжуулалт
4. Өвчний эхний үед эмчилгээнээс зайлсхийх

A. A4 B2 C3 D1
B. A1 B3 C4 D2

C. A2 B4 C1 D3
D. A3 B1 C2 D4
E. A4 B3 C2 D1

/288./ Өвчин үүсэх боломжит хамаарлыг уялдуулан сонгоно уу?

A. Биеийн эсэргүүцэл маш сайн B. Биеийн эсэргүүцэл бага
C. Биеийн эсэргүүцэл сайн D. Биеийн эсэргүүцэл маш бага 1. Өвчин үүсэх боломж бага
2. Өвчин үүсэх боломж маш бага
3. Өвчин үүсэх боломж маш их
4. Өвчин үүсч болзошгүй

A. A1 B3 C4 D2
B. A2 B4 C1 D3
C. A3 B1 C2 D4
D. A4 B2 C3 D1
E. A1 B4 C3 D2

/289./ Нийгмийн эрүүл мэндийн үйл ажиллагаа нь өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэхийн тулд нийгмийн нөөц бололцоог бүрэн дүүрэн ашиглахыг чухалчилдаг бөгөөд энэ нь гуравдагч сэргийлэлтийн арга хэмжээнд чиглэгддэг

/290./ Хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох нь өвчлөхөөс урьдчилан сэргийлэн, эрүүл байх талаар мэдлэг-чадвар-хандлага дадлыг системтэйгээр эзэмшүүлэх учраас эрүүл зан үйл аж төрөх ёсыг төлөвшүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа юм

/291./ Халдварт өвчлөл гарсан үед халдварын эх уурхай болсон өвчилж болзошгүй хүмүүсийг тусгаарлан халдвар тээгчдийг дархлаажуулах учраас өвчлөгсдөд анхдагч сэргийлэлтийн арга хэмжээг хэрэгжүүлдэг

/292./ Хооллолтын үнэлгээнд дараах үнэлгээнээс аль нь хамаарах вэ

A. Бие махбодийн үнэлгээ
B. Нас хүйсний үнэлгээ
C. Оршин суугаа газрын үнэлгээ
D. Антропометрийн үнэлгээ
E. Хамт олны үнэлгээ

/293./ Хоол тэжээлийн ач холбогдлыг нэрлэнэ үү ?

1. Хувь хүний өсөлт хөгжилтийг хангах
2. Нөхөн үржихүйг зохицуулах
3. Бие махбод сэтгэлзүйг зохицуулах
4. Дасан зохицох чадварыг нэмэгдүүлэх
5. Хараа сонсголыг сайжруулах

/294./ Хооллолт дараах хүчин зүйлсийн алинаас хамаарах вэ ?

A. Физикийн хүчин зүйлс
B. Химийн хүчин зүйлс
C. Дулааны хүчин зүйлс
D. Газарзүй, уур амьсгалын хүчин зүйлс
E. Эрсдэлт хүчин зүйлс

/295./ Монгол хүний уламжлалт хоол тэжээлийн онцлогийг сонгоно уу ?

1. Уургаар баялаг
2. Ханасан өөх тосоор баялаг
3. Цинк, кальц, төмрөөр баялаг
4. B12 амин дэмээр баялаг
5. Амин дэм Д-ээр баялаг

/296./ Монгол улсын 0-5 насны хүүхдийн дундах хоол тэжээлээс шалтгаалсан цус багадалтын тархалтын хувь хэд вэ ?

A. 50%
B. 12%
C. 45%
D. 28%
E. 17%

/297./ Хоол тэжээл дэх микроэлементийн дутагдалтай холбоотой үүсэх эмгэгт аль нь хамаарах вэ ?

1. Гипоплази
2. Иод дутагдлын эмгэг
3. Магнийн дутагдал
4. Төмрийн дутагдал
5. Ясны сийрэгжилт

/298./ Энгийн нүүрс усны эх сурвалжийг олно уу ?

1. Бүх төрлийн байцаа
2. Гурилан бүтээгдэхүүн
3. Цагаан идээ
4. Төмс
5. Жимс, жимсгэнэ

/299./ Дараах нэгдлүүдийн аль нь энгийн нүүрс усанд хамаарах вэ ?

A. Моносахарид
B. Дисахарид
C. Полисахарид
D. Биофлавоноид
E. Полифенол

/300./ Дараах эрдсүүдээс аль нь макроэлемент ангилалд хамаарах вэ

A. Натри
B. Кали
C. Магни
D. Төмөр
E. Хром

/301./ Насанд хүрэгчдийн нэг килограмм биеийн жинд хэдэн мл усны хэрэгцээ шаардлагатай вэ ?

A. 10-15 мл/ кг
B. 30-60 мл/ кг
C. 70-80 мл/ кг
D. 35-45 мл/ кг
E. 100-120 мл/ кг

/302./ Өвчний түүхийн асуумжийн аль хэсэгт хооллолтын асуумж хамаардаг вэ ?

A. Өвчний түүхийн хэсэгт
B. Ерөнхий зовиурын хэсэгт
C. Паспортын хэсэгт
D. Амьдралын түүхийн хэсэгт
E. Удмын түүхийн хэсэгт

/303./ Хүний биеийн хэдэн хувийг ус эзэлдэг вэ ?

A. 30-40%
B. 40-50%
C. 10-20%
D. 60-65%
E. 50-60%

/304./ Цөсний хагалгааны дараах хоолны онцлогийг сонгоно уу ?

A. Өөх тос ердийн физиологийн нормоос их хүнс
B. Шарж, хуурсан, амтлаг хүнс
C. Хандлагч бодис, амтлагч бага, ууранд болгосон хүнс

D. Мах махан бүтээгдэхүүний орц ихтэй
E. Сүүн сүүн бүтээгдэхүүний орц ихтэй хүнс
/305./ Эмчилгээний 5 дугаарын хоолны онцлогийг олно уу ?
A. Хүйтэн зууш
B. Халуун ногоо, амтлагч өнгө будагчаар амталсан олон төрлийн хүнс
C. Шинэ бэлтгэсэн өөх тосоор бага хүнс
D. Махыг буцалгаж боршсон шөлтэ
E. Ногооны нухашны холимогоор баялаг хүнс
/306./ Насанд хүрэгчдийн хоногийн хоолны илчлэгийн хэд нь эслэг байхаар тооцож хооллолтын зөвлөгөө өгөх вэ
A. 1000 ккал тутамд 10-15 гр эслэг байхаар тооцно.
B. 1000 ккал тутамд 20-25 гр эслэг байхаар тооцно
C. 1000 ккал тутамд 30-35 гр эслэг байхаар тооцно.
D. 1000 ккал тутамд 40-45 гр эслэг байхаар тооцно.
E. 1000 ккал тутамд 50-55 гр эслэг байхаар тооцно
/307./ Зүрх судасны эмгэгийн үед илчлэг хязгаарладаг учраас биеийн жинг хэвийн хэмжээнд барих, зүрхний ачааллыг нэмэгдүүлдэг.
/308./ Улаан лууван бол каротиныг агуулдаг, А амин дэмээр баялаг учраас бага насны хүүхдэд хэрэгцээтэй хүнсний нэг юм.
/309./ Сэтгэл зүйн дарамт нь артерийн даралт ихсэх өвчний эрсдэлт хүчин зүйлсийн нэг учраас хоолны давсыг багасгаж, өөх тостой хоол хэрэглэнэ
/310./ Ундны усны стандартад “ Ахуйн хэрэглээний ус” гэдгийг юу гэж тодорхойлсон вэ?
A. Одоо ашиглаж байгаа, цаашид ашиглаж болохуйц гадаргын болон газрын доорх усы
B. Газрын гадаргуугаас доош орших ус үл нэвтрүүлэх 1 дэх үе дээр байгаа усыг
C. Хүн амын эрүүл ахуй, халдвар хамгааллын хэвийн нөхцөлийг хангах зорилгоор хэрэглэгдэх чанартай, хүрэлцэхүйц хэмжээний, аюулгүй усыг
D. Хүн ам шууд уух болон хоол хүнсийг боловсруулах, ариун цэвэр, эрүүл ахуйн хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор хэрэглэж байгаа чанартай аюулгүй усыг
E. Уул нуруудын цас, мөсний хайлалтаас үүссэн урсгал, тогтмол ус ба хур бороony усыг
/311./ Талхны зөөлөн хэсэгт ямар бактер үржсний улмаас “төмсний өвчин” үүсдэг вэ?
A. Yarrowialipolytica
B. Sphingomonas yanoikuyae
C. Mesentericus
D. Ellipsosporum
E. Hydrogenophagapalleron
/312./ Агаарын чанарын индекс хэд байвал “аюултай” гэж үздэг вэ?
A. 201-300
B. 51-100
C. 300-500
D. 151-200
E. 0-50
/313./ Ундны усанд агуулагдах фторын агууламж хэвийн хэмжээнээс багасвал ямар өвчлөлд хүргэдэг вэ?
A. Флюороз
B. Ангина
C. Холер
D. Хавдар
E. Кариес
/314./ Агаарын даралтыг багажгүй үед хэрхэн тодорхойлж болох вэ

A. Өөрийн мэдрэмжээрээ
B. Термометрийн тусламжтайгаар, хүснэгт ашиглан
C. Бие махбодод илрэх таагүй мэдрэмжээр
D. Цаг агаарын өөрчлөлтөөр
E. Газрын татах хүчээр барагцаалж

/315./ Дотоод орчны агаарт автомашины бохирдолтыг илтгэх үзүүлэлт юугаар илэрхийлэгдэх вэ ?

A. Нарийн ширхэгт тоосонцор
B. Хүхэрлэг хий
C. Нүүрстөрөгчийн дутуу исэл
D. Азотын давхар исэл
E. Азотын исэл

/316./ Хүний эрүүл мэндэд 50 ба түүнээс дээш хувиар нөлөөлөгч хүчин зүйлийг нэрлэнэ үү?

A. Эмнэлгийн тусламжаас шалтгаалсан хүчин зүйлс
B. Орчны хүчин зүйлс
C. Амьдралын хүчин зүйлс
D. Генетикийн хүчин зүйлс
E. Нийгмийн хүчин зүйлс

/317./ Агаарт нүүрстөрөгчийн хийн агууламж өндөр байх нь юуг илтгэх вэ?

A. Автомашины хөдөлгүүрээс үүдэлтэй агаарын бохирдол
B. Ойн түймрээс үүдэлтэй агаарын бохирдол
C. Орон сууцнаас үүдэлтэй агаарын бохирдол
D. Гэр хорооллын утаанаас үүдэлтэй агаарын бохирдол
E. Модны дутуу шаталтаас үүдэлтэй агаарын бохирдол

/318./ Агаарын бохирдолтыг Монгол улсын хуулинд юу гэж тодорхойлсон байдаг вэ?

A. Агаар бохирдуулах бодисын агууламж агаарын чанарын стандартаас хэтэрч, агаарын чанар доройтохыг хэлнэ.
B. Дотоод орчны агаарын чанар стандартаас хэтэрч, агаарын чанар муудахыг хэлнэ.
C. Агаарыг бохирдуулагч хүчин зүйлүүдээр бохирдохыг хэлнэ.
D. Агаарт байгаа химийн бодисууд бусад бодисуудтай холилдон хүний эрүүл мэндэд хортой химийн нэгдэл үүсгэхийг хэлнэ.
E. Автомашины утаа, гэр хорооллын айлуудын утаа зэргүүдийг хэлнэ.

/319./ Дотоод орчны агаарт агаарын хөдөлгөөний гүйцэтгэх үүрэг юу вэ?

A. Бохир агаарыг гадагшлуулах
B. Агаарыг чийгшүүлэх
C. Агаарыг хөргөх
D. Гадаад орчны агаартай адил болгох
E. Агаарт байгаа усыг зохицуулах

/320./ Усаар дамжих халдварт өвчинд аль нь орох вэ?

A. Ангина
B. Кариес
C. Хавдар
D. Балнад
E. Сүрьеэ

/321./ Нэгдсэн оношлогоо эмчилгээний төвд ариутгалын ямар нэгж байхыг эмнэлгийн байгууллагын халдвар хамгаалалын дэглэмд заасан байдаг вэ?

A. Ариутгалын тасаг
B. Ариутгалын нэгж
C. Ариутгалын бүс
D. Ариутгалын хэсэг
E. Ариутгах байр

/322./ Их бохирдсон эмнэлгийн багаж, тоног төхөөрөмжийг хэрхэн ариутгаж, халдваргүйжүүлэх вэ?

A. Автоклавд хийж ариутгана
B. Урьдчилсан цэвэрлэгээ хийнэ
C. Химийн аргаар ариутгана
D. Халуун ууранд ариутгана
E. Хатаах шүүгээнд хийнэ

/323./ Эмнэлгийн хог хаягдалын хэдэн хувийг аюултай хог хаягдал эзэлдэг вэ?

A. 15-30%
B. 25-50%

C. 5-10%
D. 10-25%
E. 50-70%

/324./ Өрхийн эмнэлэг нь эрүүл мэндийн тогтолцооны хэд дэх шатлал вэ ?
A. Доод шатлал
B. Анхдагч шатлал
C. Хоёрдогч шатлал
D. Дээд шатлал
E. Гуравдагч шатлал

/325./ Агаарын хэмийн хэт халалт нь хүний бие махбодод хэрхэн нөлөөлөх вэ?
1. Амьсгал давхцах
2. Зүрх судасны үйл ажиллагаа сулрах
3. Хөлс ихээр ялгарч, цаашид үргэжилбэл ус давсны солилцоо алдагдах
4. Арьс салст улайх, түлэгдэх
5. Судасны цохилт түргэсэх

/326./ Агаарыг бохирдуулж байгаа эх үүсвэрүүдийг нэрлэнэ үү?
1. Үйлдвэр
2. Гэр хороолол
3. Тээврийн хэрэгсэл
4. Эвдэрсэн хөрс
5. Усан сан

/327./ Агаарын даралтыг хэмждэг Барометр багажийг хэрхэн ангилдаг вэ?
1. Шугаман барометр
2. Мөнгөн усны сифонный барометр
3. Бөмбөлгөн барометр
4. Мөнгөн усны аяган барометр
5. Аяганбарометр

/328./ Усны физиологийн ач холбогдолыг дурьдана уу?
1. Хүний биеийн 55-78%-ийг ус эзэлдэг
2. Шиллэг эд буюу нүдэнд 99% хүртэлх ус байдаг
3. Ясны 22% нь ус байдаг
4. Зөөвөрлөгч
5. Илүүдлийг гадагшлуулагч

/329./ Насанд хүрсэн хүний өдөрт авах усны хэмжээ хэд вэ?
1. Метаболизм 400 мл
2. Хоол хүнсээр 500 мл
3. Шингэн байдлаар 1500 мл
4. Эмчилгээний явцад 300 мл
5. Усанд ороод 2500 мл

/330./ Хүний цусан дахь гемоглобины 25-50% нь метагемоглобинд шилжих үед хүний бие ямар шинж тэмдэг илрэх вэ?
1. Сульдах
2. Бөөлжих
3. Гүйлгэх
4. Чичрэх
5. Татах, коллапсын шинжүүд

/331./ Ундны усны эрүүл ахуйн шаардлагыг заана уу?
1. Унд ахуйн зориулалтаар ашиглах зөвшөөрөлтэй
2. Ундны ус нь мэдрэгдэх амт, өнгө, үнэргүй байна
3. Ундны усыг батлагдсан шинжилгээний стандарт аргаар итгэмжлэгдсэн лабораторид тодорхойлох
4. Ундны усны химийн найрлагын үзүүлэлт стандартаас хэтэрч болохгүй
5. Усанд нэмэлт халдваргүйтгэл хийх эсэхийг эрүүл ахуйн дүгнэлтийг үндэслэн шийднэ.

/332./ Эрүүл ахуйн химийн аргаар юуг судладаг вэ ?
1. Агаар, ус, хөрс, хүнсний бүтээгдэхүүний химийн найрлага
2. Хүний биед таагүй нөлөө үзүүлж болох бодис

3. Эрүүл ахуйн судалгаа шинжилгээнд
4. Макро, микро бие махбодийн процессий
5. Хамт олны болон хот, дүүргийн хүн амын эрүүл мэндийн байгууллагын тайлан мэдээнд дүн шинжилгээ хийх

/333./ Уургийн үлдэгдэлийг шалгахдаа ашигладаг сорилыг нэрлэнэ үү ?
1. Ортотолидины сорил
2. Амидопирины сорил
3. “Азопирам-Д” сорил
4. Фенолфталейн сорил
5. Хүчлийн сорил

/334./ Сүүнд содыг ямар зорилгоор хийдэг вэ?
1. Өтгөрүүлэх зорилгоор
2. Исэглэнг бууруулах
3. Бичил биетний үржлийг зогсоох
4. Ээдэхээс сэргийлэх
5. Сүүг сайхан амттай болгох

/335./ Хөрсний бохирдуулагч гол эх үүсвэр юу вэ?
1. Эрдэс бордоо
2. Үйлдвэрийн хаягдал
3. Нефть, нефтийн бүтээгдэхүүн
4. Агаарт цацагдсан утаа, хий
5. Пестицид

/336./ Хүн амын бодит хооллолтыг ямар аргаар судалдаг вэ?
1. Жижиг бүлгийн аргаар
2. Нийгэм-эдийн засгийн үндсийн аргаар
3. Нийгэм-соёлын аргаар
4. Нийгэм- эрүүл ахуйн үндсийн аргаар
5. Нийгэм-хамт олны аргаар

/337./ Монгол улсын “Ундны усны” стандартад ундны усны чанарыг сайжруулах технологийн явцад үүсэх бохирдлын химийн үзүүлэлтийг хэрхэн ангилах вэ?
1. Халдваргүйтгэлийн бодис
2. Халдваргүйтгэлийн дараа үүсэх бодис
3. Угаагч бодис
4. Ус түгээх хоолойн химийн гаралтай бодис
5. Шингээгч бодис

/338./ Хөрсийг механик бүтцээр нь хэрхэн ангилдаг вэ?
1. Элстэй хөрс
2. Элсэрхэг хөрс
3. Шаварлаг хөрс
4. Шавартай хөрс
5. Шороотой хөрс

/339./ Зохистой хооллолтын онолоор хоол хүнс нь ямар байх шаардлагатай вэ?
1. Хоол хүнс нь баланслагдсан
2. Алдсэн энергийг нөхөхүйц
3. Тодорхой нутриент агуулсан
4. Биологийн өндөр идэвхит бодис агуулсан
5. Хямд үнэтэй

/340./ Дараах асуултуудыг хариултуудтай тус тус зөв харгалзуулна уу?
1. Агаарын хэм
2. Агаарын чийглэг
3. Усны pH
4. Агаарын хөдөлгөөн
5. Агаарын даралт

a. 0,2-0,4 м/с
b. 30-60%
c. 18-22°C

d. 6.5-8.5
e. 760 мм муб
A. 1B, 2C, 3A, 4E, 5D
B. 1B, 2A, 3B, 4D, 5E
C. 1D, 2B, 3A, 4E, 5C
D. 1C, 2B, 3D, 4A, 5E
E. 1B, 2A, 3D, 4C, 4E
/341./ Дараах асуултуудыг хариултуудтай тус тус зөв харгалзуулна уу?
1. Гэрэлтүүлэг
2. Сүүний нягт
3. Агаарын хурд
4. Агаарын даралт
5. Усны хатуулаг
a. pH метр
b. Аерометр
c. Люксметр
d. Барометр
e. Анемометр
A. 1B, 2C, 3A, 4E, 5D
B. 1B, 2A, 3B, 4D, 5E
C. 1C, 2B, 3E, 4D, 5A
D. 1C, 2B, 3D, 4A, 5E
E. 1B, 2A, 3D, 4C, 4E
/342./ Дараах асуултуудыг хариултуудтай тус тус зөв харгалзуулна уу?
1. Их халдвартай хог хаягдал
2. Эмгэг судлалын ба анатомын хог хаягдал
3. Химийн ба эмийн бодисууд
4. Аюулгүй хог хаягдал
5. Зүү ба хурц ирмэгтэй хог хаягдал
a. Хар өнгийн уут ба хуванцар сав
b. Нордоггүй шар өнгийн уутанд
c. Цоордоггүй бат бөх шар уутанд
d. Бор өнгийн уут
e. “Их халдвартай” гэж бичээд шар уутанд
A. 1B, 2C, 3A, 4E, 5D
B. 1E, 2B, 3D, 4A, 5C
C. 1C, 2B, 3E, 4D, 5A
D. 1C, 2B, 3D, 4A, 5E
E. 1B, 2A, 3D, 4C, 4E
/343./ Дараах асуултуудыг хариултуудтай тус тус зөв харгалзуулна уу?
1. Сүүний хэвийн нягтын хэмжээ
2. Сүүний исэглэн
3. Сүүний кальцийн агууламж
4. Сүүний ууураг
5. Сүүний тослог
a. 89-178 мг/%
b. 1,027-1,033 г/см3
c. 16-20 °T
d. 1,9-7,8%
e. 2,2-5,6 %
A. 1B, 2C, 3A, 4E, 5D
B. 1B, 2A, 3B, 4D, 5E
C. 1D, 2B, 3A, 4E, 5C
D. 1A, 2B, 3C, 4D, 5E
E. 1B, 2A, 3D, 4C, 4

/344./ Эмнэлэг болон хүүхдийн байгууллагад агаарын хэмийг хэмжихдээ өвчтөн хэвтэж байгаа орны буюу хүүхдийн амьсгалын түвшинд хэмждэг учраас халаалт ба агааржуулах хэрэгслийн ойролцоо термометрийг байрлуулж болохгүй.

/345./ Термограф нь тодорхой хугацаанд агаарын хэмийн өөрчлөлтийг тусгай туузан дээр бичиж тэмдэглэдэг учраас судалгаа, шинжилгээ, цаг уурын албанд өргөнөөр хэрэглэдэг.

/346./ Тасалгааны доторх дулааны өөрчлөлт термометрийг ямар байршилаар хаана байрлуулснаар тодорхойлогддог учраас халаалт болон агааржуулах төхөөрөмжийн ойролцоо байрлуулж болохгүй.

/347./